

77	Литературный жаргон	9. С.Березина
99	такими же	
	такое же значение оно имеет для	
	также как и в языке науки	
19	также	8. С.Березина
	таким же образом, как и в языке науки	
25	таким же образом, как и в языке науки	7. Б.Лысенко
27	таким же образом, как и в языке науки	6. Е.Лившиц
34	таким же образом, как и в языке науки	5. А.Ляпунов
28	таким же образом, как и в языке науки	4. Б.С.Ляпунов
13	таким же образом, как и в языке науки	3. А.Ляпунов
4	таким же образом, как и в языке науки	2. С.Ляпунов
	таким же образом, как и в языке науки	1. Н.Сапрыкин

## АЛГЕБРА

СПЕЦИАЛЬНОЕ УЧЕБНИК

2/1999

Начало обучения

СПЕЦИАЛЬНОЕ УЧЕБНИК

СПЕЦИАЛЬНОЕ УЧЕБНИК

ПРИМЕРЫ

Эрхлэн хэвлүүлсэн

«ШИХИХУТУГ»  
ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

---

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИИ

Ерөнхий редактор

Данзандийн ЛҮНДЭЭЖАНЦАН

Редакцийн гишүүд

Галдангийн СОВД

Жигжидийн БОЛДБААТАР

Чимцидийн ЭНХБААТАР

Жамерэвгийн БЯМБАДОРЖ

Жаргалантын ЭЛБЭГСАЙХАН

Бирваагийн МАНДАХБИЛЭГ

Түдэвэрчинчингийн БАЯРМАА

Нарийн бичгийн дарга

Даншонлогийн ҮҮРЦАЙХ

---

Хэвлэгээний талбай:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж,

«Шихихутуг» ХЭДС-ийн байр.

Утас: 323392, 320176

---

Жилаа 4 дугаар хэвлэгдэн гарна  
Улсын бүртгэлийн дугаар 173

---

Хэвлэлтийн газар

“Согоо нуур” ХХК -д хэвлэв.  
Утас: 315594

## ЭРХЭМ УНШИГЧ ТАНАА

"Шихихутуг" Хууль Зүйн Дээд Сургуулиас эрхтэн гаргажи "Шихихутуг" сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь Монгол Улсад арчилал, зах зээлийн харилцаг хөгжүүлж, эрх зүйт төрийг бүрдүүлэхэд тэр, эрх зүйн онолын сэтгэлгээг чөлөөтэй болгох, ишлэлтэй хөгжүүлэхэд оршино. Монгол улсад социализмын үед нэг үзэл суртлын ноёрхола хатуу хязгаартай байсан боловч социалист тэр, эрх зүйн үзэл баримтлалын хүрээнд хуульчид, эрдэмтлийн үзэл бодол, бүтээс туурвайлыг хэвлэн нийтэлдэг "Ардын төр", "Социалист хууль ёс" гээдэг тогтмол хэвлэгдэг мэргэжлийн хоёр сэтгүүл гардаг байсан нь хуульчдын мэргжил, дадлагыг дээшлүүлж, онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд төдийгүй араа иргэдийн дундаж хуулийг сурталчлан таниузлаад зохиц өч холбогдолтой байсан билээ.

Тус орона нийгмийн байгууллын хэв маяг солигасоноор дээрх хоёр сэтгүүлийн нийтлэлийн бодлого тохиорхгүй болсноо гадна хөрөнгө, санхүүгийн хувьд амьдрах боломжгүй болсноо сүүлийн арав орчим жил орон зай нь эзгүйрэнээс хуульчнаа, эрдэмтдийн онол, эрдэм шинжилгээний бүтээлүүд болон үзэл бодлыг чөлөөтэй солилцох, хуулийн суртал нэвтрүүлгийг өргөн олон нийтээ хүргэх индэргүй болсон нь нэгэн зүйл эмгэнэл билээ.

Ийма "Шихихутуг" гээг хууль зүйн мэргэжлийн тогтмол сэтгүүлийт хэдэн гаргахаар "Шихихутуг" ХЭДС хөрөнгө оруулалт хийж, 1999 оны хоёр дахь дугаардаа уншигч агуулж танаа толилуулж байна.

"Шихихутуг" сэтгүүт нь хуульчид, эрдэмтдийн олон ургалч үзэл бүхий онол, эрдэм шинжилгээний бүтээл болон дэлхийн нэра гарсан эрдэмтлийн үзэл, онолыг ямар нэг хаалт, хязгааралтгүй чөлөөтэй хэвлэхэд нээлтгэйн гадна үзүүлчилж байгаа хуулийн суртал нэвтрүүлгийг өргөн хэвлэж араа түүнний эрх зүйн мэдлэгийг онцлогчжуулж гэгээрүүлжинэг хамтад нь хэрэгжүүлэхийг зорино.

Манай сэтгүүлэд бүтээл туурвилгаа хэвлүүлж, санал бодол, үзэл, онолоо чөлөөтэй солилцохыг хүсье.

Таны тухайд "Шихихутуг" сэтгүүлийн хаалга үргэлж нээлтгэй, нийтлэлийн бодлого чөлөөтэй.

Монгол Усны гавьяат  
хуульч, Хууль зүйн ухааны  
доктор, профессор

Г.СОВД

## ЭРХ ЗҮЙН ТУХАЙ СОНГОДОГ ОЙЛГОЛТ

© 1999 ОН. Цэрэнбалтавын САРАНТУЯА<sup>1</sup>

Төр үүсэхээс омнох эртний үеийг этнологчид судалж үзээд МЭӨ 2-4 мянган онд Грек, Сумэр болон Египет зэрэгт оршин байсан овог аймгуудын талаар бичиж нийтэлсэн байдаг. Эдгээрт тухайн үеийнхээ нийтгэм, эдийн засгийн байгууллыг илүүтэй тусгасан байдаг бөгөөд, тэр үеийн эрх зүй болон түүнтэй тосоотгүй нийгмийн зохицуулалтын талаар нотлох баримт, материал цөөн байдагас өргөн дэлгэр судалгаа хийх боломжгүй байж иржээ.

Дээрх асуудлаарх харьцуулсан судалгааг ч харьцангуй орой хийж эхэлсэн ба ийнхүү анхны доривтой бүтээлийг Lewis Morgan 1877 онд "Ancient Society" гэдэг номоороо туурвисан байдаг.

Энэхүү нийтлэлийн зорилго нь эрх зүйн тухай еронхий ойлголтыг тодруулахад нэг алхам урагш хийхэд оршиж байгаа тул эхний хэсэгт:

- төр үүсэхээс омнох үеийн нэгэн нийгмийн зохицуулалт хэрхэн ямар онцлогтой байсан гэдгийг авч үзэн түүнийгээ торт нийтгэм дэх эрх зүйн тухай ойлголттой харьцуулах оролдлого хийх юм. Нийтлэлийнхээ хоёрдугаар хэсэгт:

- дэлхий дахинь сэтгэгчид эрх зүйн талаар хэрхэн юу гэж үзэж байсныг дүгнэн үзэж, эрх зүйн талаар одоо баримтлаж буй ойлголтыг тодотгох оролдлогыг хийнэ.

I. Эртний нийтгэмүүд хоорондоо адил төсөөтэй зохицуултай байсан тул одоогийн Суданы омно зүйт сууринж байсан Nuer-чүүдийг жишээ болгон авч үзье. Тэдгээр нь Нил морний эргээр оршин амьдарч байсан буюу хүн амын тоо нь 300.000, нийт 15 овог аймагт хуваагдаж байв.<sup>2</sup> Гэр бүл бол тэдний амьдралын чухал нэгж байсан. Эрчүүд нь үхэр маллаж, эмэгтэйчүүд нь гэр орны ажил хийж, газар тариалангийн ажлыг харин хамтарч эрхэлдэг байв.

Гэр бүл нь моногами зарчим дээр тулгуурладаг, учир нь

<sup>1</sup> МУИС-ийн ХЭЦС-ийн Улсын хуулийн эрх зүйн тэнхимийн багш, эзлэх доктор, дэх профессор,

<sup>2</sup> Uwe wesel 'Juristische Weltkunde', 6. Aufl., 1992, S.22. E.E.Evans-Pritchard 'The Nuer', 1940.

нехрийн талас эхнэр болох хүний гэр булд ииж төлдөг ба тэр нь 20-30 үхэр байсан. Эхнэр нь нехроосоо салах явдал цөөнгүй тохиолддог ба нэг хүүхэл төрүүлсэн тохиолдолд иижээс зурган үхрийт буцаан төлөх, харин хоёр хүүхэд төрүүлсэн бол юуг ч буцаан төлөх шаардлагагүй журамтай байжээ. Энэ нь хүүхэд эзгийнхээ ураг төрөлд цаашил хамаарсан хэвээр байх боломжтой гэсэн утгатай юм. Nuer-ийнхны хувьд хүүхэд эсвэл эцэг, эсвэл зөвхөн эхийнхээ ураг төрөлд хамаарах ёстой байдаг ба аль алнид нь нэгэн зэрэг хамаарах боломжгүй гэж үзэг байсан. Үүнийг агнاتик төрлийн холбоо гэж нэрэлдэг. Манай соёл иргэншилд байдаг шиг коннатик холбоо тухайлбал хүүхэд хоёр эмэг эх, хоёр өвөг эцэгтэй байх боломж байгаагүй ажээ. Дээрх агнатик төрлийн холбооныхоо хүмүүс хоорондоо гэрлэж болохгүй бөгөөд экзогам харилцаанд байдаг. Гэрлэлтийг харин дан ганц овог аймгийн хүрээнд зөвшөөрдөг. Энэ утгаараа овог аймгийн дотор эндогам харьцаа ноёрхож байжээ. Тэр үеийн нийгмийн чухал нэгж нь ураг төрлийн холбоо байв. Энэхүү ураг төрлийн холбоо нь хоёроос гурван үедээ ихээхэн хүчтэй хадгалагддаг байсан ба газар болон малыг өөртөө омчлох эрхийг ураг төрлийн холбоонд мэдэж шийддэг байсан тул тухайн үеийн нийгмийн хэв журамд ихээхэн нелөө үзүүлж байв.

Энэ утгаараа ураг төрлийн холбоо нь нийгмийнхээ бүтцийг бүрлүүлж байжээ гэж үзэж болох юм. Овог аймаг нь ийнхүү ураг төрлийн олон тооны бүлгүүдээс бүрдэг байсан, тэдгээрийг тус бүрт нь сегмент гэж нэрэлдэг аж. Сегментүүд дотроо экзогам, овог аймаг нь эндогам харьцаанд байсан байна.

Овог аймгийн хувьд бие дааж аяи дайн хийх, нэгдэж өөрслүүгээ хамгаалах үүрэгтэй учир овог аймгийн хүрээнд эрх зүй үйлчилж байсан гэж Эдвард Эванс Притчард "The Nuer" гэдэг номондоо дүгнэн хэлсэн байдаг. Тухайлбал, Nuer-чууд бүгд хоорондоо адил тэгш эрхтэй. Баян ядуу хүмүүс байсан боловч тухайн нийгэмд хүмүүс бие биетэйгээ адил хэмжээнд харьцлаг байсан, хүмүүс төрөхдоо тэгш байдалтай, ноёрхогч боол гэсэн ялгаа огт байдаггүй нэгэн нийгэм байв. Харин ураг төрөл болон сегментуудын хүмүүсийн хооронд бие биенийхээ амь насыг бүрэлгэсэн тохиолдолд хохирлыг толж шайруулах зарчим үйлчилж байсан. Ийм чиг үүргийг хэрэгжүүлэхэд тусалдаг тусгай хүмүүс үе залгамжилсан шинжтэй ажилладаг байв. Харин эдгээр нь бусдаас илүү эрх дарх эдэлдэгтүй, захиран тушаах эрх мэдэлгүй, гагшхуу зохицуулах л чиг үүрэгтэй бусдын

нэгэн адил хүмүүс байснаараа онцлогтой. Жишээ нь, хэн нэг нь бусдын амь насыг хохироосон тохиолдолд тэрхүү зохицуулагч нь хүн алсан этгээдийг тодорхой хугацаанаа ивээлдээ байлгаж, тэр хугацаанд ураг төрлийнхэнтэй нь ярилцан нас барсан хүний гэр бүлийхэнд хэдий хэмжээний мал/үхэр/ өгснөөр хохирлыг цайруулах вэ гэдгийг тохиролцоод, хохирогчийн гэрт очиж эн тухай хэд хэдэн удаа ярилцсаны эцэст малын тодорхой тоон дээр зөвшеөрүүлж үүнийг шат дараалсан байдлаар төлүүлэх арга хэмжээг авдаг байж. Тодорхой хугацаа онгөрч, мөн тодорхой тооны малыг хохирогчийн гэрт хэрэг үйлдсэн хүний төрөл төрөгсдөөр төлүүлсэнд дараагаар байдал хэвийн болж дээрх маргалдсан хоёр тал хоорондоо ёс хонzon санах зүйлгүйгээр хуучин хэвийн байдалд шилжин ордог байж. Дээрх бүх зүйлийг үйлдэхдээ энд дурьдаагүй олон тооны ёс заншлыг /ритуал/ биелүүлдэг байсан гэж үздэг. Энэ нийгэмд шүүх буюу шийдвэр гүйцэтгэгч гэж байгаагүй, хүмүүс өөрөө өөртөө тусламжаа үзүүлэх байдлаар асуудлаа шийдвэрлэдэг байсан гэж үзэж болох юм.

Дээрх болон тэр үеийн ёс заншлын өөр олон жишээнүүдийг судлан үзэхэд Nuug-ийнхны үеийн болон манай үеийн эрх зүйн хооронд маш их ялгаа байдгийг ажиглаж болох юм. Тэдэнд хууль эрх зүйн мэдлэг, тухайн нийгэмд нь хуульчид огт хэрэгтүй байсантай нэгэн адил тэдгээр нь огт хэрэгцээ шаардлагагүй зүйл байсан юм. Nuug-чуудын дээрх жишээн дээр дурдсан ёс заншлыг билний өнөөдрийн эрх зүй гэж ойлгодог зүйлтэй харьцуулан үзэхэд маш ялгаатай бөгөөд ганц нэг сренхий хандлагаараа жишээ нь хүний амийг бүрэлгэж болохгүй гэх мэт зарчмын шаардлагуудаараа хоорондоо төсөөтэй байна.

Гэхдээ заншлын нийгмийн үед хүн алахыг буруу хэрэг гэж үздэг байсан ч энэ зөрчлийг хувийн шинж чанартай гэж ойлгон хохиргчийн гэр бүлийнхэнд компенсаци /нехэн төлбөр/ төлснөөр хохирлыг цайруулдаг байсан. Харин торт нийгмийн үед үүнийг гэмт хэрэг гэж тооцож төрөөс ял шийтгэл оногдуулдаг. Манай нийгэмд хохирогчийн гэр буда юу ч төлдөгтүй учир ямар нэг компенсацийн тухай ойлголт байхгүй болсон. Торт нийгмийн өмнөх үед компромисс буюу зөвшүүлэлт хүрэх боломжтой байсан тул талууд хохирлыг арилгасны дараагаар цаашдаа хоорондоо харилцан ойлголцон амьдрах бололцоотой байж ирсэн. Харин эрх бухий төрийн

байгууллага - шүүхээс здавал биелэх шинж чанартай шийдвэр гаргадаг болсноор талуудын хоорондын ойлголцол аажимдаа үүгүй болж эхэлжээ.

Төрт нийгэм үүсэхээс өмнөх зөрчилдөөнийг шийдвэрлэхэд талууд нь эрх тэгш байсан ба ноёрхлын ямар нэг элементгүйгээр асуудлыг консенсусаар шийдвэрлэдэг байв. Харин өнөөдөр шүүхээс шийдвэр гаргахдаа талуудын болон гэрчийн этгээдийн мэдүүлгийг сонсдог боловч шийдвэр нь ямаргүй талынх байдаг. Түүнчлэн шүүх нь дан ганши дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагдаг ба харьцангуй бие дэласан байдалтай ажилладаг. Ийм дагнасан шинжтэй эрх бухий байгууллага заншлын нийгэмд байх огт боломжгүй юм. Өөрөөр хэлэх юм бол, заншлын хэв журам нь өөрөө өөрийгоо зохицуулсан шинжтэй, харин торт нийгэм нь ноёрхлын буюу дээрээс нь зохицуулсан элементтэй байна. Төр үүсэхээс өмнө зөрчлийг шийдвэрлэх явдал нь байдлыг хуучин хэвэнд нь оруулах зорилготой байсан. Үүгээрээ нийгэм өөрчлөгдох боломжтой болдог тул төрийн учир нийгэм нь өөрөө өөрчлөгдөхгүй, статик шинжтэй хэвээр байсан. Харин төрийн шүүхийн үйл ажиллагаз нь үүний яг эсрэг үр дүнд хүргэдэг ба хүмүүсийн харилцааг дээрээс нь зохицуулж байдгараа заншлын шинж чанартай болон хуучирч үеэзлэсэн зарим зохицуулалтыг хүчингүй болгож зохицуулалтыг нийлээд дэвшилттэй зүйл гэж үзээт. Заншлын нийгэм нь колектив шинжтэй, ураг төрлүүд бие биенээ харилцаан дэмжих байдал дээр тулгуурладаг бол торт нийгэмд ураг төрлийн буюу өр бүлэгийнхийн дэмжлэг зарчмын хувьт тодийлон шаардлагагүй бөгөөд боломжгүй зүйл юм. Төрт нийгэм бол үүгээрээ индивидуалист шинж чанартай гэж үзэж болох юм. Niug-чуудын соong/ёс заншил/ бол уг чанартай мораль буюу ёс зүйн хэв журам юм. Сайн, муу, зөв, буруу г.м нь бутд тэдний хувьт нэг ойлголт ба бурхан тэнгэрээс үүдэлтэй. Торт нийгэмд байдал шиг мораль ба эрх зүй гэсэн туслгаарлал байдалтуй.

Эрх зүй бол бидний хувьт бие хэрхэн авч байлгах гадаад илрэлийн асуудал бол мораль нь дотоод үзэлэмжийн талын ойлголт байдаг. Иймд манай нийгэмд мораль гэдэг нь индивидуаль шинжтэй, харин өмнөх нийгэмд энэ нь колектив шинжтэй байсан байна.

Дээр дурьсан зарим ялгаануудас үүдээд этнологчид торт нийгмийн өмнөх зохицуулалт эрх зүй мөн эсэх талаарх асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээлтэй тулгардаг байна.

Энэ асуудлыг гол төлов англо-саксоны эрх зүйчил сүүлийн 50 орчим жил судалж байгаа юм. Эдгээр эрдэмтэд гол төлов Law, custom гэдгийн ялгаа буюу харьцааг гаргахаар үүднээс ут асуудлыг сонирхож иржээ. Law гэдэг нь дан ганц хууль биш, эрх зүйт ч бас өөртөө багтаан хамааруулж байгаа юм. Харин custom гэдэг нь манай зан заншил гэлэгтэй нэг угтатай үт юм. Төр үүсэхээс өмнөх үсийн нийгэмд зарим тохиолдолд тодорхой нэг системд оруулж хараахан болохгүй ч албадлагын эхлэл бас ажиглагдаж байдал. Энэ нь Nuer-чүүдийн нийгэмд харин ихээхэн бага ажиглагддаг. Энэ тохиолдолд Law, custom хөбрын тухай асуудал яаж хандах вэ?

2. Law /эрх зүй, хууль/, custom /зан заншил/-ын зааг юунд оршиж байна вэ? гэдэг асуултад мэргэжлийн хуульч хүн эрх зүйн онолын түүхийн хуудсыг сөхөн байж хариулах болно.

Эрх зүй гэж юу болох талаар тоолж барагдашгүй тайлбар бий. Тэдгээрийн үндэслэлийг тухай бүрт нь гаргаж ирсэн байдал. Энэ үйл явц цаашид ч энэ хэвээрээ үргэлжлэх нь дамжуулж байж юм. Эрх зүйн ойлголт соёл, шинжлэх ухаан, зэрэг бусад үзэгалийн тухай ойлголтуудтай адил үргэлж хөдөлгөөнд байж ирсэн. Эрх зүйн ойлголтын талаар 2000 жилийн өмнөөс гүн ухаантан, хуульч болон социологид судлан үзэж ирсэн. Тэдгээрийн заримаас доор жишээ болгон толилуулья:

## 2.1 Платон

Түүний эрх зүйн философитой Politeia /төр/, Nomoi /хууль/ гэсэн хоёр бүтээлээс нь танилшаж болох юм. Дээрх зохицуудаа тэр дотроо гурван иерархитай байдал тухай санааг гаргасал доод түвшинд тариачид, гар урлаачид, худалдаачид, дунд түвшинд цэрэг, шагдаа, хамгаалалтын хүмүүс харин дээр нь гүн ухаантангүүд ногёрхлыг хэрэгжүүлдэг. Дээрх бүх түвшингийн хүмүүс өөрсөд нь оногдсон үүргийг биелүүлэх үүднээс шударгалр хуваариласан эрхүүдийг эдлэх ёстой гэж үзжээ. Платоны үзсэнээр бол эрх зүй гэдэг нь шударга ёсны агуулгыг илэрхийлсэн ойлголт болно.

## 2.2 Аристотелес

Тэрээр эрх зүйн философинийг этикийн буюу гоо зүйн ойлголу гэж үзээд Платоны нэгэн адил төрийн философиийн хэсэг болгон тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, эрх зүй гэж юут хэлэх вэ, тэр нь ямар байх вэ гэдгийг тэр өөрөө тогтооно.

Аристотелес ч гэсэн эрх зүйг шударга ёстой холбон үзэж байсан. Шударга ёс бол тэгш байдал гээд тэгш байдлыг арифметикийн болон геометрийн гэж хоёр хуваасан байна.

Эхнийх нь тэгштэн үзэх, хоёр дахь нь тэгш хуваарилах тэгш байдал гэж дотроо хувзагдаад, эхнийхийг нь иргэд хоорондын харилцаанд, хоёр дахийг нь төрөөс хөрөнгө, алба урамшуулал зэргийг хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилахад илэрдэг гэж үзсэн байна.

### 2.3 Ромын эрх зүй

Энэ нь МЭӨ III зуунд Итали болон колони орнуудад ихээхэн дэлгэрчээ. Тэдгээр нь ан амьтан, хүмүүс бүгд байгалиас заясан төрөлхийн эрхийг эдэлнэ гэж үзээл боогдол нь тэрхүү заяамал эрхэнд харшилах тухай номиж байжээ. Ромын хуульчдын хувьд эрх зүй бол тэдгээрт заясан төрөлхийн эрх болно.

### 2.4 Томас фон Аквин.

Хууль гэлэг бол сэтгэгчийн хувь хүмүүсийн сайн сайхан аж байдлын төлөө хэсэг хүмүүсээс нийтэд зориулан гаргаж буй зохицуулалт бөгөөд тэрхүү зохицуулалт нь төлөө зан байдал дээр тулгуурлана. Эрх зүйт хэдийгээр төрөөс тогтоох боловч тэрээр ногөө талаас төлөө зан байдлын илэрхийлэл байдаг тул нэгэн зэрэг христос шашины төрөлхийн эрх мөн юм гэсэн хоорондоо зорчил бүхий хоёр оөр утгыг илэрхийлдэг гэж үзэж байсан.

### 2.5 Хуго Гронус

Эрх зүйн нь төрд бус, харин дан ганц хүний толов байдал тулгуурланэ гэж тэрээр үзэж байсан байна. Энэхүү үзэл онол нь төрөлхийн эрхийг төрөөс болон христосын шашингаас ангид авч үзсэн шинэ үсийн нэгэн урсгал юм. Шашин шүтлэг болон цаг хугашаанаас үл хамааран дэлхий дахиннаа адилхан үйлчилдэг зарчим, зохицуулалтууд нь хүний төрөлхийн эрхэд тохирох юм гэж үзээд энэ нь дан ганц хувь хүмүүст ч биш, мөн ард түмнүүдэд ч нэгэн адил хамаарах юм гэж үзжээ. Үүгээрээ Хуго Гронус олон улсын түгээмэл эрх зүйт их нээсэн болно.

### 2.6 Томас Хоббес

Тэрээр мөн л Платон ба Аристотелийн адил эрх зүйг төрийн философийтой холбон үзэж байсан. Ялгаа нь төр оршин байх шалтгааныг тодорхой нэг идей буюу үзэл санаатай холбож үзээгүй, харин бодит хэрэгцээтэй холбон үзсэн ба төр үүсэх нь хүмүүсийн бодит байдал, түүн дээр үндэслэн гарсан хэрэгцээнээс үүдэлтэй гэжээ. Байгалийн бодит байдал нь хаос, эмх замбараагүй байдал юм. Хүмүүс бие биендээ дайсагнах болов ч хэн нэг нь захиран тушаах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байсан. Тэр этгээд нь төр юм. Төреөс захиран тушаасан болгон эрх зүй мөн гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, хууль ямар байх вэ гэдгийг авторитет буюу нэр хүнд тогтоохоос биш бодит үнэн үүнийг тогтоож чадахгүй юм гэж үзсэн байлаг. Тэрхүү авторитет буюу нэр хүнд нь сэтгэгчийн үзэж байснаар төр юм.

## 2.7 Иммануель Кант

Кант бол эрх чөлөө ба иргэний нийгэмд тэмүүлсэн, абсолютист төрийн эсрэг үзэл санаа бүхий сэтгэгч байсан. Энэ шалтгаанаар түүний боловсруулсан эрх зүйн онолын үндэс нь төр биш, нийгэм тодруулж хэлэх юм бол хувь хүний мораль юм. Хүн бүр өөрийнхөө үйл ажиллагааг хууль тогтоогчоос зөвшөөрч буй хүрээнд явуулах боломжтой. Ес суртахууны зарчмуудыг хүмүүс өөрт нь оногдсон эрх чөлөөний хүрээнд хэрэгжүүлнэ. Ингэхдээ бусадтай зөрчилдэх явдал гарч болохыг үгүйсгэхгүй, үүнээс сэргийлэхийн тулд тов тодорхой зааг хязгаар тогтоох ёстой буюу тэрхүү зааг хязгаар нь эрх зүй мөн гэж үзжээ. Өөрөөр хэлэх юм бол эрх зүй гэдэг нь эрх чөлөөний срөнхий зарчмын хүрээнд нэг хүн нөгөөгийнхөө эрхийг зөрчихгүй байх иөхцөл бололцоо юм.

## 2.8 Макс Вебер

1925 онд бичсэн "Эдийн засаг ба нийгэм" гэдэг номных нь хоёрлуугаар хэсэгт түүний эрх зүйн сошиологи тусгалаз алсон байдаг. Эрх зүй гэдэг нь гурван элементээс бүрддэг. Нэгл, срөнхий хэм хэмжээ, хоёрт, тэдгээрийг төреөс тогтоосон байна, гуравт, тэдгээрийн хэрэгжилт төрийн албадлагын аппаратадар хамгаалагдсан байна. Төр ба түүний албадлагын аппарат гэдэг зүйлүүд энд хамгийн чухал байр суурийг эзлэж байна.

## 2.9 Хайнс Кельзен.

"Төрийн эрх зүйн тухай сургаалийн гол асуудлуул" /

1911 он/, "Эрх зүйн цэвэр онол" /1934, 1960 он/ зэрэг бүтээлүүдээс тэрээр эрх зүйн шинжлэх ухааныг сошиологи талын элементүүдээс чөлөөлөх оролцлого хийсэн ба нийгмийн шинжлэх ухаануудаас тусгаарлахыг эрмэлзсэн байдал. Энэхүү шалтгаанаар тэрээр "мера сущего" болон "мера должного" хоёрыг злаглан үзсэн байдал. Бусад шинжлэх ухаан нь "мера сущего"-г л судлах ёстой байхад эрх зүйн шинжлэх ухаан нь "мера должного"-г судалдагаараа норматив шинжлэх буюу "эрх зүйн цэвэр сургааль" мөн юм гэж бичсэн байдал. Эрх зүй гэдэг нь энэ утгыараа төрөөс тогтоосон буюу түүний албадлагаар хамгаалагдаж буй бүхий л хэм хэмжээнүүдийн нийлбэр шогц гэж ойлгох юм. Эрх зүйг ёс суртахуунаас төв тодорхой злаглах ёстой гэж үзсэн байдал.

Дээрх есэн жишээнээс голна эрх зүйн тухай ойлголтыг өөрсдийнхөө оршин байгаа үетэйгээ тохируулан гаргаж ирсэн өөр цөөнгүй жишээ байдал юм. Дээрх жишээнүүдийг дурдсандаар эрх зүйн тухай ойлголтыг гаргаж ирэх шалгуур төдийлон их биш байдал гэдгийт харуулах оролцлого хийсэн болно. Түүхэн хөгжлийн явцад эрх зүйт тодорхойлоход дөхөмтэй бүх шалгуурууд гарч ирж байсан гэдгийг зарим цөөн жишээн дээр харууллаа. Тухайлбал, эрх зүй нь:

- төрөөс ангид оршиж буй нийгмийн бүтээгдэхүүн
- эсвэл торт нийгмийн үр дагавар ба чухал элемент гэж өөр өөрөөр тайлбарласан нь дээрх жишээнүүдээс харагдаж байгаа болно.

- Энэ хоёр хэсэг, хоёр ургалыг хослуулсан үзэл ч байдал ба жишээ нь Eugen Ehrlich гэж эрдэмтэн эрх зүйт төрөөс тогтоодог ч түүнийг нийгмээс хүлээн зөвшөөрч байж тэр нь үр зшигтай үйлчилж чадах юм гэж тэмдэглэсэн байдал. Тэр ч бүү хэл эрх зүй ба ёс суртахуун хоёр нэгэн зүйл эсэх гэсэн асуултыг харьшангуй өөр хоорондоо ялгатай байдлаар тайлбарладаг.

Дээрх үзэл онолуудыг судлан үзсэний эзест эрх зүй, түүний шинж чанар нь наа хугацааны явцад өөрчлөгдж ирсэн ба ер нь ч байнга өөрчлөгдж байдал гэж дүтиж болох юм. Түүхэн хөгжлийн үе болгонд адил хэмжээнд тохирих эрх зүйн онол онөөг хүртэл бий болоогүй. Тухайлбал,

- эртний үеийн онолууд нь эрх зүй ба ёс суртахуун хоёрыг ямагт холбоотой авч үзсэн байхад
- сүүлийн гурван зуун орчим жил үүний эсрэг онолууд

гэрч ирж байх жишээтэй.

Энэ нь байдал үнэхээр өөрчлөгдсөнтэй буюу шинэхэн үеийн эх зүй нь төрийн зүтгээс зохицуулах арга хэрэгзэл нь болж өөрчлөгдсөнтэй холбоотой юм. Харин дээр үед бол дадал заншил, уламжлал зэрэг өөрөөр хэлбэл ёс суртахууны салбарт хамарагдлаг зүйлс илүү их үүрэг рольтой байсан. Зан заншил, ёс суртахуун, ёс зүй зэрэг нь манай нийгэмд одоо ч хэрэглэгдэж байдал л нэр томъёо хэвээр байгаа боловч хүмүүсийн дотоод үнэмшил ба үнэлээмжийг илүү илэрхийлсэн ойлголт бодлог. Энэ нь бусад хүмүүс ба эрх зүйн зохицуулалтыас үл хамааралтай. Харин эртний нийгэмд хувь хүний ёс суртахуун нь тухайн үеийн дадал, заншилтай нийшжэй байх ёстой байсан ба аль аль нь эрх зүйтэй нягт холбоотой байсан. Төрийн үүрэг роль ёсөх нь энэхүү нэгдмэл байдлыг эвээхэд хүргэсэн байна. Төрийн зохицуулах үүрэг ёсөх тусам дээрээсээ удирдах явдал ихсэх ба энэ нь чухамхүү эрх зүй мөн юм. Иймд өмнө нь эрх зүй гэж байгаагүй гэж хэлэхэд хүндрэлтэй, түүний шинж чанар ямагт өөрчлөгджэй ирсэн. Иймд, эрх зүй гэж юу вэ? гэсэн асуултанд нийтлэг хариултыг өгөх боломжгүй бөгөөд түүхэн хөгжлийн чухамхүү хэдий үеийн эрх зүйн тухай ярьж байна вэ гэдгээс л шалтгаална гэж хэлэх нь хамгийн оновчтой юм. Эрх зүйн хөгжлийн эхний үе шатанд тэрээр ёс суртахуун, зан заншил гэдэгтэй нэг зүйл байсан. Эцэст нь эдгээр нь турван өөр салангид гэхдээ хоорондоо холбоотой зүйлс болж хөгжсон байна. Платон, Аристотель нар оорсдийнхээ үед тохирсон ижилхэн хариулт өгсөн ба Макс Вебер болон Ханс Кельзен нар манай өнөөгийн үед тохирсон хариултыг өгсөн байна. Энэ бол эрх зүйн хөгжлийн ерөнхий хууль мон юм.

Харин манай үеийн хувь бол эрх зүйн нь одоо ч **терөөс тогтоосон хэмжээ хэвээр байгаа учир дээрх хоёр эрдэмтэн тэргүүлсэн дэлхий, дахинь онолчлын үзэл өнөө ч мөн ойрын ирээдүйд ч өөрчлөгдөхгүй, хэвээр хадгалагдах нь дамжигтгүй. Эхний үед нэгдмэл байсан эрх зүй, ёс суртахуун, зан заншил нь лажимдаа улам бур холдож байгаа болно. Харин Nuer-чуудын siong гэж юу байсан бэ? Тэр бол төр үүсэхээс өмнөх үеийн нийгэм юм. Иймд нийгэмд Law, custom хоёрын хооронд ялгаа гэж байгаагүй учир эрх зүй байсан гэж хэлж болох юм. Энэхүү ялгаа нь дан ганц торт нийгмийн эрх зүйн онолл л байдал учир өөр хоорондоо ийнхүү ялгаатай нийгмүүдийн хувьд дээрх харьцуулалтыг хийх боломжгүй юм.**

## ДЭЛХИЙ ДАХИНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГААЛЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

© 1999 он. Соловцурэнгийн НАРАНГЭРЭЛ<sup>1</sup>

Олон зуун жилийн турш хүн төрөлхтний ухаант мэргэдийн боловсруулсан эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны сэтгэлгээ, сургаал, номлол нь онол, танин мэдэхүйн төдийгүй арга зүйн ихээхэн ач холбогдолтой.

Манай зарим хуулыг эрдэмтэд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны дэлхий нийтийн онолын үндсэн чиглэл, сургаалыг судалж байжээ.

Гэвч Монгол Улс хүн төрөлхтний соёл иргэншилээс тусгаарлагдаж дан ганц марксист-ленинист онолыг бурханчлан шүтэж, үнэндий туйл мэт үзэж байсан тэр үеийн тогтолцооноос шалтгаалан дэлхий нийтийн сод соён гэгээрүүлэгчил, эрдэмтэн мэргэдийн боловсруулсан эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онол сургаалын зарим үндсэн чиглэлийг зөвхөн ангич, намч байр сууринаас авч үзэж, харгис шинжтэй<sup>2</sup> гэж дүгнэж байсан шаг уе түүхийн сургамж болон ара үлджээ.

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь соён гэгээрүүлэх-хүмүүнлэг, сонгодог, антропологи, социологийн гэсэн дөрвөн үндсэн чиглэлийн онола антилж байгаа юм.<sup>3</sup>

### *Соён гэгээрүүлэх-хүмүүнлэгийн сургаал*

Эрүүгийн эрх зүйн соён гэгээрүүлэх-хүмүүнлэгийн чиглэл ХҮШ зуунд үссэн юм. Энэ нь феодалин ноёрхолыг унагаахыг эрмэлзээн хоронготний эрүүгийн улс төр болон эрүүгийн эрх зүйн үзэл санааны штэрхийлэл болсон юм. Энэ

<sup>1</sup> МУИС-ийн ХЭДС-ийн захидал, МОН-ны сронхиалын, доктор /Ph.D./, профессор.

<sup>2</sup> Б.Соловцов. БИМАУ-ын эрүүгийн эрх /сронхиий аяги/ – Ул., 1969, 51-52 дахь тал, Г.Сонз. Эрүүгийн эрхийн курс – Ул., 1973., 50-161 дахь талмыг үзүүлүү.

<sup>3</sup> Наумов А.В. Российское уголовное право., общая часть, курс лекций изда-во "Бек", Москва, 1996., 529 дахь талд. Российское уголовное право. Общая часть, учебник, под редакцией акад. В.П.Кулравицена. изда-во "Спарк", Москва, 1997., 429 дахь талмыг үзүүлүү.

үзэл санаа нь 1789 оноос эхлэн францын хувьсгалын үзэл санааны мөрийн хөтөлбөрийн үндсэн хэсэг нь болж байв.

Энэ үзэл санааны чиглэлийн хүрээнд Францын соён гэгээрүүлэгчдийн эрүүгийн эрх зүйн үзэл санаа /юуны түрүүн/ Монтескье, Вольтер/, Италийн соён гэгээрүүлэгч Чезаре Беккария бичсэн алшарт ном "Гэмт хэрэг ба ял", Францын нэргт хувьсгалын Жан Поль Маратын эрх зүйн онолыг хамааруулж болно.

Ш.Монтескье /1689-1755/ бол ХҮШ зууны Францын соён гэгээрүүлэгчдийн хамгийн гаралтай төлөөлөгч бөгөөд зохиолч, философич, эдийн засагч, хуульч хүн байжээ. Түүний эрүүгийн эрх зүйн үзэл санаа нь 1721 онд бичсэн "Персийн захиалууд", 1748 онд бичсэн "Хуулийн тухай үзэл бодол" номуудал тусгалцаа тодорхой олжээ. Энэ хүн шашин шүтлэгийн хүрээнд эрүүгийн ял хүлээх хэргийг хязгаарлахын толоо зоримог тэмцэж байсан байна. Феодалын эрүүгийн эрх зүйд шашны эсрэг үйлдсэн аливаа үйлслийн толоо хүнийг галш шатаах хүртэл харгис цээрлэл ногдуулдаг байжээ.

Тэрбээр эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмыг үндэслэсэн юм. Тэрээр эрүүгийн хууль нь /зөвхөн гадаад/ үйлслийн толоо цээрлүүлэх ёстой гэж томъёолоод ямар нэг үйлдэл үйлдээгүй байхад хүний зөвхөн хэлсэн үг, санаа бодлын толоо эрүүгийн хариушлага хүлээлгэхийг эрэсэргүүшдэг байв.

Монтескье гэмт хэрэг бүрийг эрүүгийн хуульд тодорхойлсон байхын зэрэгцээ "шүүгч хуулийн заалтаас хазайх ёсгүй" гэж үзэж байв.

Мөн гэмт хэрэг үйлдсэн хүн түүндээ тохирсон ял хүлээх зарчмыг үндэслэсэн байна. Энэхүү зарчмаас ухарч байгааг Хятадын болон Москвагийн жишээн дээр харуулсан байна. Хятадал дээрэмчийг баривчлаад хэдэн хэсэг болгодог байтлаа ердийн хулгайчийг тэгдэгтүй байжээ. Москвад хулгайч, алзан хядагчыг адилхан цаазалдаг байв. Тийм учраас булаах хэргийг дагалдаж хүний амийг бусниулах явдал гардаг болжээ гэдгийг бичсэн байна.

Феодализмын үел цаазаар авах ялыг түгээмэл хэрэглээдэг байжээ. Монтескье цаазаар авах ялыг "Өндөр дээд гэгээнний доромжлох," шашны эсрэг гэмт хэрэг түүнчлэн эд хөрөнгийн шинжлэхүүний гэмт хэрэгт хэрэглэхийг эсэргүүшж байжээ. Тэрбээр ер нь ялыг хөнгөрүүлэх байр сууриний хатуу баримталж байсан байна. Монтескье гэмт явалын шалтгааныг тодорхойлохыг

эрмэлзэж байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхдээ түүний баримталж байсан арга зүйн үндсэн үзэл баримтлал нь засаглалын хэлбэр, хууль, хүмүүсийн эрх, гэмт явдала шаг уурын байдал шийдвэрлэх ач холбогдолтой гэж үзэж байв. Түүний бодлоор хойд зүгээс өмнөд зүг рүү шунал ба гэмт хэргийн тоо улам бүр ихэслэг байна.<sup>1</sup>

Эрүүгийн хуулийн зорилтын хамгийн чухал нь ял биш харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийг тэргүүн зэрэгт тавьсан нь яахын аргагүй түүний сэтгэлгээ хэр зэрэг өнлөрлөгт хурсний нотолгоо юм.

Тэрбээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдлыг хүмүүс болон нийгмийн зан суртахууны төлөвшлийн дээшлэлттэй холбож үзэж байна.

Монтескьеийн эрүүгийн эрх зүйн үзэл баримтлалын талаар Монголын хуульч эрдэмтлийн бүтээлд тусгалаа олсныг дурдавал, хуульч эрдэмтэн Б.Содовсүрэн "Монтескьеийн үзээр бол хүний амьдарч байгаа байгаль, шаг уур, эрхэлээн ажил, ядуу, баяны харьцаа, амьжиргээн хэлбэр нь гэмт хэргийн шалтгаан учраас эд агуурсын тэгш биш байдлыг арилгах, хүмүүсийг сайн хүмүүжүүлэх гол арга бол "сайн хууль тогтоомж гаргах явдал байжээ"<sup>2</sup> гэж Монтескьеийн үзэл бодлыг нэгтгэн дүгнэжээ.<sup>3</sup>

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, проф Г.Совд мөн Монтескьеийн эрүүгийн эрх зүйн онолын үзэл баримтлалыг "Монтескье гэмт хэргийн үндсэн шалтгааныг муу хуультай байгаагаас болж байна гэж үзэж байсан. Түүнчлэн хуулийг хэрэглэж чадахгүй явдал бол гэмт хэрэг үүсэн гарахын бас нэг шалтгаан нь юм. Байгалийн нохшөл, шаг агаарын байдал гэмт хэргийн шалтгаан болдог" гэж үзэж байна.<sup>4</sup>

Эрүүгийн эрх зүйн соён гэгээрүүлэх-хүмүүнлэгийн чиглэлийн хөгжилда Италийн соён гэгээрүүлэгч Чезаре Беккария /1738-1794/ шийдвэрлэх нөлөө үзүүлсэн юм. Түүний 1764 онд бичсэн "Гэмт хэрэг болон ялын тухай"<sup>5</sup> номыг нэрлэж болох

<sup>1</sup> Наумов, А.В. Российское уголовное право. Общая часть курса лекций. издан. "Бек", Москва, 1996., 531 дахь тал, Российской уголовное право., общая часть, учебник, чадаа реформа. В.Н.Кудрявцева. издан-во "Аларк", Москва, 1997., 430 дахь талыг үзүүлүү.

<sup>2</sup> Б.Содовсүрэн дурссан бүтээл 51 дахь тал

<sup>3</sup> Г.Совд дурссан бүтээл. 151 дахь тал

<sup>4</sup> Беккария, Ч. О преступлениях и наказаниях. М. 1939

юм. Тэрбээр эрүүгийн эрх зүй болон эрүүгийн байсан шийтгэх эрх зүйд эрх мэдэл хуваарилах онолыг хэрэглэх явдлыг хэрэгжүүлээд дараахь зарчмыг томъёолжээ. Өөроор хэлбэл, албан ёдгор үйлчилгээний гэмт хэрэгт тооцох эсэхийг зөвхөн хууль тогтоогчийн эрх мэдэлд харин тухайн этгээдэг гэмт хэрэг үйлсэн буюу үйлзээгүй эсэхийг зөвхөн шүүх эрх мэдэл шийдвэрлэж байна гэж тодорхойлжээ.

Беккариа "зөвхөн хуулиар гэмт хэрэгт хүлээлгэх ялыг тогтоох" бөгөөд шүүгч "хуулийн хэмжээ хязгаараас хэтэрсэн ялыг"<sup>1</sup> ногдуулж болохгүй гэж тэмдэглэжээ. Тэрбээр эрүүгийн хариушлагын талаархи Монголын үзэл санааг дэмжихийн зэрэгцээ эрүүгийн мөрдөл мешгелтийг хүмүүсийн санаа бодол ба хэлсэн, ярьсанд биш зөвхөн тэдний үйлдэлд хийх ёстой гэж үзэж байв.

Түүний санал бодлоор "гэмт хэргийн цорын ганц ба жинхэнэ хэмжүүр нь үндэстэнд учруулсан гэм хор" буюу "Нийгмийн сайн сайхан" юм. Тэрбээр ялын асуудлаар үндсэн хоёр зарчим баримталж байжээ. Энэ нь бүх иргэд эрх тэгш байх болон үйлсэн гэмт хэрэг ба ял хоорондоо нийшжэх тохирсон зэрэг юм. Үүнийхээ дагуу Беккариа гэмт хэрэг ба ялын "маш нарийн бөгөөд бүх нийтийн шатлал"<sup>2</sup> бүй болох санал тавьж байжээ. Гэмт хэргийн шатлал нь гэмт хэргийн нийгмийн хор зоуулын хэр хэмжээний ангилалт юм. Ялын шатлалд онцгой харгис ялыг оруулаагүй байна.

Беккариа "ял нь хатуу чангад бус түүний гарцаагүйд оршино гэсэн сэтгэгдэл төрж байна"<sup>3</sup> гэсэн сэдэв /зарчим/ боловсруулсан нь эрүүгийн эрх зүйн цазшлын хөгжилд үлээж нолоо үзүүлсэн төдийгүй олон жилийн өмнө түүний боловсруулсан эл зарчмын үнэ цэнэ өнөө үед ч хэвээр байна. Айлгаж эмээлгэх нь ялын бие даасан зорилго гэсэн лундаж зууны үсийн үзэл санааны зэрэг байр суурийг Беккариа тууштай баримталж, гэмт буруутай этгээдийг давтан гэмт хэрэг үйлдэхийг тогтоон барих нь ялын зорилго гэж үзэж байв.

Чухамхүү Беккариа түүхэнд анх удаа цаазаар авах ялын зэрэг итгэл үнэмшилтэй үндэслэгээ гарган тавьж ялангуа энэ ялын урьдчилан сэргийлэх учир холбогдол хуурмаг юм гэсэн санааг дэвшүүлж байжээ. Тэрбээр цаазаар авах ял хүмүүст

<sup>1</sup> Беккариа Ч. дурсан зохиол 204 дэх тал.

<sup>2</sup> Беккариа Ч. Омни дурсан зохиол 223-224 дэх тал

<sup>3</sup> Беккариа Ч.Омни дурсан зохиол 373 дахь тал

харгислал, хэршигийллийн үлгэр жишээг харуулж, эсийн дунд зан суртахууныг ширүүн ба догшин болгож шинээр гэмт хэрэг үйлдэхэл тус дөхөм үзүүлдэг гэж үзэж байв.

Беккариагийн үзэл санааны нөлоогөөр харгис хэршигийн ялыг халахын толөө тэмцлийн хөдөлгөөн буй болсон гэж хэлж болно.

Вольтер /1694-1778/ бол ХҮШ зууны францын соён гэгээрүүлэгчийн нэрг төлөөлөгчийн нэг юм. Хэдийгээр хуулыч мэргэжилтэй биш ч гэсэн өөрийн бүтээлдээ эрүүгийн эрх зүйн асуудлыг олонтаа тусгаж байжээ. Түүний үзэл санаа нь 1766 онд бичсэн "Гэмт хэрэг болон ялын тухай номын тайлбар", 1977 онд бичсэн "Шударга ёс ба хүмүүнлэгийн шагнал" зэрэг номонд тод томруун тусгагсан байдал.

Вольтер эдгээр болон бусад бүтээлдээ католик сүм, шашны үзэл бодлын эсрэг тэмшэж буй хүмүүсийг харгис хэршигийгээр шийтгэхийг эрээргүүцэж байв. Хүнийг санаж бодсоных нь толөө мөрдөн мөшгөдөг явдлын эсрэг туштай тэмцэж байв. Ингэж мөрдөн мөшгих нь хүн төрөлхтний оюун ухаантай зорчилдэж байгааг нотлохыг эрмэлзжээ. "Христийн шүүх нь тэрс үзэл бодолтой 100000 мянган хүнийг цазалж байсан нь хүн төрөлхтний эсрэг хийсэн гэмт хэрэг юм"<sup>1</sup> гэж бичжээ.

Эрүүгийн бодлогын салбарт Вольтер эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөгжингүй тогтолцоонд тулгуурлана гэж үзэж байв.

Соён гэгээрүүлэгчийн өмнөх төлөөлөгчийн /Монтескье, Беккария/ үзэл санааг улам хөгжүүлж гэмт хэрэг, түүнд ногдуулах ял нь хоорондоо харишсан тохирсон байх ёстой гэж үзэж байв.

Тэрээр "Герман, Францад их замын худгай ба хүн алсан, булаах гэмт хэргийн хооронд ялын ямар ч ялгаа алга байна. Бусдын эд хөрөнгийг устгаж тэдгээр гэмт хэргийнхээ гэрчийг алахад түлхдэгнийг ойлгохгүй байна гэж үү" гэж бичжээ.

Тэрээр Беккариагийн нэгэн адил цаазаар авахын эсрэг тэмцэж байв.

Жан Поль Марат /1743-1793/ бол 1789 оны Францын хувьсгалын гол зүтгэлтийн нэг, түүнчлэн нэрг эрдэмтэн, нийтлэлч байв. Тэрээр физик, анатом хуааны талаар бичсэн

<sup>1</sup> Вольтер. Изд. проз. по угл. праву и процессу. – М., 1956. 76-77 дахь тал

олон бүтээлдээ нийгэм улс төрийн хурааг хамарсан үзэл болдоо илэрхийлжээ. Тухайлбал, "Эрүүгийн хууль тогтоомжийн төлөвлөгөө" номондоо эрүүгийн хуулийн техник, үт хэллэг, хэлбэрийн асуудалдаа голлон анхаарчээ. Түүний үзэл болдээ эдүгээ хүргэл хуучраагүй байна.

Маратын үзэж байснаар хуулийг шударга, ициэн мэргэн байлгахын тулд "тэмт хэрэг ба ялын тухай үл ойлгогдох тодорхой бус дур зоргын ямарваа нэгэн зүйл байх ёсгүй бөгөөд өөрөөр хэлбэл, хүн бүр хуулийг зорчвол өөрт нь юу учрах гэж байгааг мэдэж, хуулийг ойлагж байх ёстой. Эрүүгийн хууль хэт тодорхой байхаас айх хэрэгтүй"<sup>1</sup> гэж бичжээ.

Эрүүгийн хуулья Маратын тавьж байсан өөр нэг шаардлага бол "эрүүгийн хууль хэт энгийн байхаас айх ёсгүй" гэж бичсэн явдал юм. Тэрбээр түүхэнд анх удаа эрүүгийн хуулиар хүний эрх чөлөөг хязгаарлах хэр хэмжээний асуудлыг хөндөж тавьсан гэж үзэж болно. Хууль тогтоогчид нийтэд гэм хоргуй зан үйлийг хориглож, эрүүгийн эрх зүйн хориглолтын тоог аливаа байдлаар нэмэгдүүлснээр түүний үзэл болдоор тийм хууль серег үр дагаварт хүргэх бололцоотой юм. Марат нийт иргэдэд мэдсэн байх тийм арга замаар эрүүгийн хуулийг зарлан тунхаглах ёстой гэж үзэж байв. Тэрээр "Эрүүгийн хууль бүгдийн гарч байх ёстой: Энэ хууль хичинээн хямд төсөр байх тутам түүнийг эрээд олж авах боломжоор хангагдана"<sup>2</sup> гэж бичжээ.

Марат гэмт хэргийн объектыг үндэс болгож, эрүүгийн хууль тогтоомжийн тусгай ангийн тогтолцоог боловсруулж, найман хэсэгт ангилан гэмт хэрэгт хууль зүйн дун шинжилгээ хийсэн байна. Эрүүгийн хууль тогтоомжийн төлөвлөгөөний эл хэсэг угтаа Эрүүгийн хуулийн онолын нэг ёсны анхны загвар болжээ.

Маратын үзэл санданы талаар манай зарим хуульч эрдэмтэд бүтээл туурвидаа тэмдэглэжээ. Жишээлбэл, хууль зүйн шинжлэх ухааны доктор, проф Г.Совд "Сонгодог онолын нэг томоохон төлөөлөгч" Марат гэмт хэрэг үүсэхийн эх сурвалж нь нийгмийн амьдралыас үндэслэсэн байдал гэж үзээд нийгмийн шударга бус явдлыг устгасан тэр цагт гэмт хэргийн шалтгааныг устгана гэж үзэж байжээ. Гэхдээ Маратын үзлээр нийгмийн

<sup>1</sup> Марат. Ж.П. План уголовного законодательства – М., 1951. 4: дахь тал

<sup>2</sup> Марат. Ж.П. дурсаан тохиол 53 дахь тал

шударга бус явдлыг устгах арга нь зөвхөн сайн хууль боловсруулах яшал гэж үзэж байжээ"<sup>1</sup> гэж бичжээ. Монголын, Беккариагийн дараа Марат гэмт хэргээс урьачилан сэргийлэх, гэмт хэрэг ба ялын зохицол ийишэл, ял гарцаагүй байх тухай үзэл санааг бляжуулан хөгжүүлжээ. Маратын үзэл болол нь түүний өмнөх эрүүгийн эрх зүйн соён гэгээрүүлэгч-хүмүүнлэгийн толооологчдээс ялгагдах зарчмын зарим шинжийг агуулж байсныг тэмдэглэх нь зүйтэй юм. Марат хувьсгалын бөгөөд якобинчууд болох радикал жигүүрийн удирдагчын нэг байлаа. Хувьсгалын үед улс төрийн сөрөг хүчинийг аллан хядахыг эрэ шийдвэртэй эсэргүүцэж байв.

### *Сонгодог сургаал*

Эрүүгийн эрх зүйн сонгодог сургаал 1789 оны Францын хувьсгалын дараа ХVIII зууны сүүлийн XIX зууны эхээр үүсэж буй болжээ. Энэ нь эрүүтийн эрх зүйн янз бүрийн сургаалыг хамарч байсан бөгөөд Германы философич Кант, Гегель, Фейербахын эрх зүйн үзэл баримтлал зэрэгт тусгалаа олсон байдаг.

Германы сонгодог философиийн загалмайлсан энэг И.Кант /1724-1804/ нь эрүүгийн эрх зүйн орчин үеийн онол ялангуяа эрүүгийн хариуцлагын үндэслэлийн асуудлыг шийдвэрлэх, ялын тухай үзэл баримтлалыг боловсруулахад чухал нелөө үзүүлсэн юм.

Эрүүгийн хариуцлагын үндэслэлийн тухай асуудлыг зан суртахууны тухай сургаалд үндэслэн шийдвэрлэсэн бөгөөд гол нь "шууд императив" сургалт буюу сайн сайхан зорилгол хүрэхийн тулд үйлдсэн бус харин зан суртахууны хууль "хатуу императив" заалтал бүх нийтээр захирагдах ухамсарт тулгуурладаг гэж үзжээ. Кант вөрйийнхөө томъёолсон зан суртахууны хуулиар гэмт хэрэг, ялын тухай асуудалдаа хандаж байжээ. И.Кант философиийн материйн ойлголтыг эрүүтийн эрх зүйл оруулж иржээ. Жишээ нь: Энэхүү философиийн томъёоллыг эрүүгийн эрх зүйн материйн шилжүүлж, хувь хүн болон хувийн омчиний эсрэг үйлдсэн гэмт хэрэг гэж үздэг байв. И.Кант хүмүүсийн эрх чөлөө нь бусад хүний эрх чөлөөг хязгаарлахгүй байх ёстой гэж үзжэй байв. Үүнээс үндэслэн эрх зүйг зөрчигчийн үзэл санааны эрх чөлөө

<sup>1</sup> Г.Сова дурссан бүтээл. 151 дж тал

нь мөн адил үзэл бодлын эрх чөлөө гэж үзжээ. Кантын ялын тухай үзэл баримтлалд Талионы зарчим буюу адил гэмт хэрэгт ижил шийтгэл ял оногдуулахыг томьёолсон юм. Тэрбээр адил зүйлд яг адилхан хэмжээний хариу авах буюу нүдийг нүдээр ба шүдийг шүдээр хариу солино гэсэн зарчмыг баримталж байв. Тийм учраас хүн албан шаазаар авах, хүчиндсэн бол хөнгөлөх зэрэг ял ногдуулах ёстой гэж үзэж байжээ. Кант бол соён гэгээрүүлэх-хүмүүнлэгийн чиглэлийн үзэл баримтлалтай /юны өмнө Беккариа/ харьцуулахад шаазаар авах ялын асуудлаар үлэмж ахиц давшил гаргасан юм.

Сонгодог сургаал гэсэн ойлголтод нэгдлэг эрүүгийн эрх зүйн онолын үзэл баримтлалын дотор сэтгэлгээний философийн диалектик аргыг үндэслэгч, Германы философич Георги Вильгельм Фридрих Гегелийн /1770-1831/ эрүүгийн эрх зүйн үзэл бодол онцгой байрыг эзэлдэг юм. Гегель тезис /сэдэв/ түүний үгүйсгэл зэрэг тезис, үгүйсгэлийн үгүйсгэл-синтез гэсэн турвалсан хэлбэрээр явагдлаг диалектик хөгжлийг тодорхойлжээ. Зэрэг тезис нь өмнөх хөгжлийг үгүйсгэнэ. Синтез бол эсрэг тезисийг үгүйсгэх төдийгүй өмнөх хөгжлийн буй болгосон бүх үнэт зүйлийт сэргээн тогтооно. Гегель үүнийгээ гэмт хэрэг ба ялын тухай сургаалл дараахь байдалар хэрэглэжээ. Тезис бол бүх нийтийн хүсэл зоригийг илэрхийлсэн хийсвэрлэгдсэн эрх оршин байгаа явдал мөн. Гэмт хэрэгт илэрхийлэгдсэн хувийн хүсэл зориг нь хийсвэрлэгдсэн эрхийг үгүйсгэх бөгөөд өөрөөр хэлбэл тезис юм. Гэмт хэрэгтэнд ногдуулсан ял нь синтез буюу өөрөөр хэлбэл гэмт хэргийг үгүйсгэх, зөрчигдсөн эрхийг сэргээх явдал мөн. Гегелийн үзэл бодлын дагуу ялын талаархи төрийн эрх нь айлгах, засан хүмүүжүүлэх ямар нэгэн зорилго биш харин ял шударга, гаршаагүй байх, эрх сэргээхэд шаардлагатай байх гэсэн логикийг буй болгожээ.<sup>1</sup>

Соён гэгээрүүлэх-хүмүүнлэгийн сургаллын төлоологчийн мөрөөр Гегель эрүүгийн харин шлагыг хүний гэмт санаа буюу сэтгэлгээнд бус харин тагихүү гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хүлээлгэх ёстой гэж үзэж байжээ. Ингэхдээ Гегель хүний мөн чанар бол түүний хүсэл буюу санаа болдоор бус "субъект бол хэд хэдэн үйлдэл": гэсэн түүний үйл

<sup>1</sup> Решетников Ф.М. "Классическая" школа и антропологico-социологическое направление-Уголовное право буржуазных стран. Вып. II. М., 1966. стр 3.

<sup>2</sup> Гегель. Философия права. м., 167 дахь тал

ажиллагазанзас хамаарна гэж үзэж байв.

Гегель хүнийг гэм буруугүй байхад хор уршгаар яллах өөрөөр хэлбэл түүний гэм буруутгүйгээр учирсан үйлдлийн үр дунд эрүүтийн хариушлага хүлээлгэхийг эрс тууштай эсэргүүцж байв. Хэрэг хариушах чадваргүй байх нь эрүүгийн хариушлагыг үгүйгэх нохшол байдал болно гэсэн тэр үедээ дэвшилттэй дүгнэлтийг Гегель хийж байлаа.

Тэрээр хэрэг хариушах чадваргүйл тоошогдсон сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүстэй хүнлэг харьшахын төлөө тууштай зогсож, тэлэнэ ял хэрэглэхийг эсэргүүцж харин ялыг эмчилж арга хэмжээгээр солихыг санал болгож байв. Гарцаагүй байсын асуудлыг эрүүгийн хариушлагыг үгүйгэх нохшол байдал гэж үзэж, феодалын эрх зүйтэй зөрчилдэж, өлсголонгийн эрхээр бусдын өмчид халдаж, нас барагчийн эрхийн толоо тэмцсэн юм. Гегель шударга байх зарчмыг бүрэлдүүлэн хөгжүүлэх гэмт хэрэг ба ял хоорондоо адил байж "иудийг иудээр, шүдийг шүдээр" ос авах Канттын ойлголтыг буруушаах, ял нь үйлдсэн гэмт хэргийн үр дүн гэж тайлбарлах зэргээр их гавьяа байгуулжээ.

Гегель нэгтгэсэн эрүүгийн хууль тогтоомж буй болгох талд тууштай зогсож энэ нь английн шүүн таслах ажиллагазны тогтолцооны эрх зүй буюу шүүхийн шийдвэр бүхий хэм хэмжээний эмхтгэлтэй харьцуулахад шүүхээс үзэмжээрээ шийдвэрлэх хэмжээ хязгаарыг хуулиар хязгаарлах талыг баттай барьж байснаараа эрх зүйн хувьд ихээхэн дэвшилттэй үзэл баримтлалтай байжээ.

XIX зууны Европын эрүүгийн эрх зүйн томообхон судлаач эрүүгийн эрх зүйн өөрийн онолыг буй болгосон Ангельм Фейербах /1775-1833/ бол "сонгодог" сургаалын онолын уламжлалыг эрүүгийн эрх зүйн үзэл баримтлалын нэлээд төвлөрсөн байдаар илэрхийлэгч юм.

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмыг томъёолсонд Фейербахын гавьяа оршино. Тэрбээр эрүүгийн эрх зүйн зарчмыг латин хэллэгээр маш тодорхой илэрхийлсэн байна.

- "nulla poena sine Lege" -хуулыгүй бол ялгүй
- "nulla poena sine crimene" –гэмт хэрэг үгүй бол ялгүй
- "nullum crimen poena legali" –хуулиар тогтоосон ял үгүй бол гэмт хэрэг үгүй.

Фейербахын өмнө дурдсан томъёолол олон улс гүрний

эрүүгийн нэгдмэл хуулийн уназс болж, онөө үед ч эрүүгийн хэргийн шүүн таслах хүрээнд арчилал, хууль ёсны баталга болсоор байна.<sup>1</sup>

Беккариа, Гегель нарын дараагаар Фейербах болол санданд биш гагихүү гэмт хэрэгт эрүүгийн хариушлагыг тутштай шаардаж байв. Тэрбээр шүүх дур зоргоороо хандахыг хязгаарласан тодорхой санкцийг эрүүгийн хуульд тогтоохын төлөө үтээ хэлж байв.

А.Фейербах нь гэмт хэргийн бүрэлэхүүн, гэм буруу, зоншалт, гэмт хэрэг хамтран үйлдэх зэрэг эрүүгийн эрх зүйн чухал институтыг "сонгодог" сургаалын хүрээнд боловсруулах баттай үндсийг оөрийнхөө зохиол бүтээлд тавьжээ. "Сонгодог" сургаал нь бүхэлдээ эрх зүйн хэм хэмжээний агуулга, нийгмийн амьдралын нохцол /улс төр, эдийн засаг, оюун санаа/ тодийгүй хууль тогтоогчын хүсэл зоригтоос шалтгаална гэсэн дүгнэлтэд хурсэн хууль зүйн ертонцийг үзэх үзлийн илэрхийлэгч юм. Ийм хандлагал ололтой талаас гадна дутагдал, алдаа бас бий. "Сонгодгууд" эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг түүхэн тодорхой нохцлоөс нь салангид авч үзэж тайлбарлаж байсан юм.

Эндээс үндэслэн эрүүгийн эрх зүйн үндсэн асуудлын формаль хууль зүйн ойлголт буй болжээ. Үүнтэй уялдан эрүүгийн эрх зүйг үт үсэгчлэн шинжлэн судлах явдал дээл цэгтээ хүрчээ. Негеэ талаас гэмт хэрэг, гэмт явалтыг нийгмийн амьдралын нийгэм-эдийн засгийн нохцлоөс салангид тусгахарлан авч үзэж, гэмт явалтын шалтгааныг гэмт хэрэгтийн хүсэл зоригийн эрх чөлөөтэй нохцолшүүлэлгүйгээр үндэслэх нь XIX зууны төгсгэлд хөгжингүй улс орнуудад гэмт явдал эрс оссон шалтгааны тухай асуудалда энэ сургаалын төлөөлөгчид үндэслэлтэй хариу өгч чадахгүйд хүрчээ. Энэ учирас "сонгодог" сургаал эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны шинэ чиглэл болох антропологи болон социологийн чиглэлийн зүгээс шуул дайралтад өртөх болжээ.

### *Антропологийн сургаал*

Эрүүгийн эрх зүйд антропологийн сургаал буй болсон нь гэмт явалтай тэмцэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг санал болгоход сонгодог сургаал түүхэн үүргээ гүйштэтгэх

<sup>1</sup> Наумов А.В. Уголовное право, общая часть, курс лекций изл-во "БЕК" М., 1996, 539-54 дахь талмыг үзүү.

чадваргүй болсонтой холбоотой юм.

Гэмт явалын осолт ба түүнтэй тэмшэх энэ сургаалийг үндэслэгч нь Италийн сэтгэн гэм судлаач, их эмч Ч.Ломброзо /1835-1900/ юм. Тэрээр гэмт явдал бол биологийн шинжктэй үзэгээл гэдгийг нотлохыг оролджээ. Ломброзо гэмт хэрэгтэн нь антропологийн шинж бүхий биологийн онцлог хэлбэр гэж үзэж, аливаа хүн гэмт хэрэгтийн төрж түүнийг засан хумуужуулж болохгүй тэж үзэж байжээ.

Гэмт хэрэгтэн бүрт гэмт хэргийн илэрхийлэл болсон тодорхой шинж тэмдэг байдгийг Ломброзо түүнийг залгамжлагчид нотлохыг хичээнгүйлэн оролджээ. Жишээ нь: Алуурчин нь буличилаг, урт шүдтэй, уруул нимгэн, бүргээнийн хамартай, хултайч нь хари тогтвортой, жижиг сахалтай, бэлгийн гэмт хэрэгтэн уруул зузаан, үс урт байдаг гэжээ.

Ломброзогийн онолын талаарх үзэл бодлоо Монголын зарим хуульч-эрдэмтээ зохиол бүтээлдээ тусгасан байна. Хуульч эрдэмтэн Б.Содовсүрэн "Хүн эхээс төрөхдөө л хэрэгтэн гардаг, үүнийг хүний биеийн гадаад болон сэтгэхуйн онцлог шинжээр таньж болно. Ломброзогийн онолоор гэмт хэргээс урьачилан сэргийлэх арга нь гэмт хэрэг үйлзэгчийн нэг хэсгийг нь эмчилэх ногоо хэсгийг наасаар нь тусгаарлах, турав дахь хэсгийг нь устгах явдал байжээ"<sup>1</sup> гэж бичжээ.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, проф Г.Сова "Ломброзын онолоор бол гэмт хэрэгтэн байх нь хүний онцлог шинжээс шалтгаалин. Хүний бисийн болон сэтгээцийн талаас ангилан үзэх ёстой бөгөөд түүний зан чанарыг толгойн ясны зохион байгуулалт тодорхойлдог гэж сургасан.

Ломброзо "Гэмт хэрэгтэн хүн" гэдэг номондоо гэмт хэрэгтнийг турван группт хуваана. Үүнд:

1.Төрөлхийн гэмт хэрэгтэн

2.Аймхай гэмт хэрэгтэн

3.Тохиолдлын гэмт хэрэгтэн гэж ангилсан байна. Энэ бүтгийн үндсэн дээр Ломброзо ямар ч амьа /организм/ бие гэмт хэрэгтэн байдаг. Гэмт хэрэгтэн ургамал хортой өвс байна. Түүнчлэн адгуусан амьтдын дотор гэмт хэрэгтэн байдаг. "Ийм учраас гэмт хэрэгтэн хүн бол анхны үр хөврөл байхдаа хүргэл гэмт хэрэгтэн байх болно" гэсэн дүгнэлт хийсэн"<sup>2</sup> гэж бичжээ.

<sup>1</sup> Содовсүрэн Б. Дурсаан бүтээл, 52 дахь тал.

<sup>2</sup> Г.Сова. Дурсаан бүтээл. 152 дахь тал

Гэмт хэрэгтэн төрөлхийн болон засаршгүй гэсэн онолоосоо үндэслэн Ломброзо болон түүнийг заалгамжлагчид гэмт хэрэг үйлзэгчдээ шааздэр авах, хорих, хөнгөлох зэрэг ял хэрэглэхийг санал болгодог юм.

Антрапологийнхны үзэж байгаагаар дурдсан арга хэмжээ нь шүүхээс ногдуулах ялыг орлох аж. Энэхүү сургаалын төлөөлөгчид шүүхийт халж, түүний оронд "гэмт хэрэгтэн хүн"-ий онцлог шинжийг тодорхойлох, түүнд хэрэглэх аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх эрх бүхий захиргазаны тусгай байгууллага байгуулахыг санал болгодог юм. Энэ дүгнэлт түйлийн харгис шинжтэй гэдэг нь бүхэнд тодорхой.

Ломброзогийн онол болон түүнийг үргэлжлүүлэгчид /жишээлбэл Э.Ферри/ арсыны үзлийн бусад онолыг фашист Итали, гитлерийн Германы үед арсыны өнгө, улс төрийн сэдэлэлтээр үй олон хүнийг алсан хядаж, хэлмэгдүүлэхэдээ үндэслэгээ болгож байсан нь санамсаргүй тохиолдол биш билээ.

Антрапологийн онол, нийтмийн орчны нелөөг үгүйсгэж байгаль биологийн хүчин зүйл хүний зан үйлд шийдвэрлэх нелөө үзүүлдэг хэмээн баталддг бүдүүлэг материализмын төлөөлөгчийн философиийн үзэл санааны үндэслэлдээ.

Гэвч шинжлэх ухааны судалгааны үр дунанторопологийн сургаалыг бүрэн ияшаасан юм. Тухайлбал 1918 онд английн хуулыч Моринг олон бүлэг хоригдлыг Кембридж, Оксфордын их сургуулд оюутнууд, түүчинчэн цэргийн албан хаагчид, коллежийн багш нартай харьцуудж Ломброзогийн судалгааг шалгаж үзжээ. Тэдний болон гэмт хэрэгтний хооронд биологийн ямар нэг ялгаа байхгүй болох нь батлагдажээ. Үүнийг энэ чиглэлээр хийсэн бусад эрдэмтдийн судалгааны үр дун ч батагдажээ.

Гэмт явалтын шалтгааны биологи-сэтгэл зүй гэж нэрлэгддэг онолд антрапологийн сургаалын үзэл санаа тод илэрдэг. Жишээлбэл: гэмт явалтын шалтгааныг цэвэр генетикийн байр суурини үүднээс тайлбарлах оролцлого хийж байна. Энэхүү үндэслэгээг "ихэр" ба "хромосом"-ын арга хэрэглэх замаар нотлох нь нэлээд түгээмэл дэлгэрчээ.

Ихэрийнхтэй холбогдсон аргын судалгааны явцад ихэр-гэмт хэрэгтнүүдийн /тэлгээрийн генетик бүтцийн ойролцоо байдлын хэр хэмжээг үндэслэн/ хувь заяа нийтлэг болохыг тогтоох оролцлого хийж хүмүүжнэж байгаа үзтэл илэрхийн нохцел байдлыг ор тас мартсан байдал. Чухамхүү энэ нохцел байдал

гэмт хэрэг үйлдэх генетик урьачилсан нөхцөл байдал тодорхойлогч хүчин зүйл биш гэдгийг харуулж байна.

Гэмт явдлын биологийн уг сурвалж болох "төрөлхийн" гэмт хэрэгтнийг хромосомын аргын тусlamжтайгаар тогтоохыг оролдож байна.

Генетик эрдэмтгийн судалгаа зарим эрэгтэй хүнд хромосомын гаж буюу эрэгтэй хромосомын "илүүдэл" байлаг болохыг илрүүлжээ.

Тэгэхдээ энэ арга шинжлэх ухаанд үндэслэгдээгүй ба, бас батлагдаагүй юм. Тухайлбал америкийн сэтгэшийн эрүүл мэндийн үндэсний институтэд байдал гэмт явдлыг судлах төв АНУ, Канад, Европын улс орны хорих газар байгаа 6432 гэмт хэрэгтэнд судалгаа хийжээ. Ингэхдээ хромосомын онолд нийшүүлэн тусгай бүлэг болгон сонголт хийж авчээ,

Эрдэм шинжилгээний илтгэл-тайландаа судалгааны үр дүнг бичихдээ гэвч "ХҮҮ /гаж хромосомын томъёолол – эрэгтэй хромосомын илүүдэл" С.Н/ гаж хромосомтой хүмүүс түрэмгий хэрцгийн байдал гэсэн өргөн тархсан санаа болол хэвийн хромосомтой гэмт хэрэгтнүүдэл хийсэн хэсэгчилсэн судалгаагаар тогтоогдсонгүй<sup>11</sup> гэсэн байна.

Гэмт кэрэгтний эмнэлэг-биологийн шинж түүний сэтгэшийн оншлог, байдалд дун шинжилгээ хийж харгалзан үзэхийг хууль зүйн шинжлэх ухаан үтгүйсэлэгтүй билээ.

### *Социологийн судалгаа*

Гэмт хэрэгтэн "төрөлхийн" байдал бөгөөд гэмт явдлын эрс осолт үүнээс шууд холбоотой учраас түүнтэй тэмцэх оөрдийн боловсруулсан аргыг хэрэглэхийг антропологийн сургаалын төлөөлогчид шаргуу шаардаж байсан боловч илт шинжлэх ухаан "бус тул удаан хугацааны тури эрдэмтэд, практик ажилтнуудын оюун ухаанд зохих байрыг эзэлж чадаагүй билээ. Энэ учраас гэмт явдлын байдал шинэ үзэл санзааг шаардах болов. Иймд эрүүтийн эрх зүйл антропологийн сургаал үсэг онгөрөөж шинэ чиглэл-сошиологийн сургаал буй болсон түүхтэй.

Түүний гол онолчил нь Германы эрүүтийн эрх зүйн судлазч Лист Принс, Голландын Ван Гамель, Оросын

<sup>11</sup> Предмет. Методология. Преступность и ее причины. Преступник. Под. ред. В.Н.Кудрявцева, И.И.Карпеш и Б.В.Коробейникова. М., 1985, стр 279.

И.Я.Фойнишкий<sup>1</sup> нар юм.

Социологийн чиглэлийн үндэс нь гэмт явдалын хүчин зүйлийн онол гэж нэрлэгдэг. Тэрээр дараах хүчин зүйлийг турван хэсэгт ангилдаг:

а.Нийгэм-эдийн засгийн /ажилгүйдэл, гүйланчлал, одслөлөн, биеэ үнэлэх/.

б.Бие махбодийн болон сансарын /жилийн хугацаа, хоног, шаг уур, шаг агаарын байдал/.

в.Хувийн болон биологийн /хүйс, нас, темперамент, гэмт хэрэгтний сэтгэшийн онцлог зэрэг/.

Ф.Лист гэмт явдал бол хүн төрөлхтний "монхийн" загуул гэж үзэж байсан юм.

Социологийн сургаал "хувь хүний нийгэмд аюултай байдал"-ын онолыг дэвшүүлсэн бөгөөд энэ онол ёсоор амьдрах хэв' ёс, бие махбодийн болон сэтгэл зүйн оншлогоор нийтэд аюултай хүмүүс нийгэмд байдаг гэж үзлэтийн. Энэ онол нь асуудлыг тодорхой гэмт хэрэг үйлдсэн нахцел байдалтай холбож үзээгүйгээрээ люултай юм. Ийм учраас нийгмийг хамгаалах зорилгоор социологичнаа гэмт хэрэгт үйлдэгцэдэд ял ногдуулахын зэрэгцээ тодорхой гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдээгүй эсэхээс шалтгаалахгүйгээр нийгмийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нэн даруй авах саналыг дэвшүүлдэг юм.

"Аюултай байдал"-ын үзэл санаа нь эрүүгийн эрх зүйн онолын хамгийн харгис бүтээлийн нэг юм. Ялыг аюулгүй байдлын арга хэмжээгээр солих нь хэрэг дээрээ эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж записан үйлдэл, эс үйлдлийг үйлдсэн гэм буруутай эхээдэл эрүүгийн хариулага хүлээлгэх зарчмыг үндэслэсэн эрүүгийн эрх зүйн үндсэн институтыг үтгүйгэдэг.

Социологийн сургаалын үзэл санаа фошист дэглэм ноёрхж байх үед буюу 1931 онд батлагдсан Италийн эрүүгийн хууль тусгалаа одж байв.

Социологийн сургаалаа тагихүү шүүмжлэлтэй хандаж огт болохгүй. Чухамдаа эл онол гэмт хэрэгтэн, гэмт хэрэг, гэмт явдалыг шинжлэх ухааны үүднээс судлах нэн чухал арга хэрэглүүрийг хуульчдын гарг ягч, эдгээр үзэгдлийг статистик, социологийн аргаар шинжилэн судлахгүй бол эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан амьдралгүй догматик болж, криминологи ч буй болохгүй байсан.

<sup>1</sup> Преступление как социально-патологическое явление. СПб. 1900, Лист, Ф. Учебник уголовного права. Общая часть. Т., 1903.

Францын хуульч Марк Анселийн нэртэй шуул холбоотойгоор ХХ зууны 50-иад оноос эхэлж тутэн дэлгэрсэн нэгэн сургаал бол нийгмийн шинэ хамгааллын онол юм. Энэ чиглэлийн гол агуулга нь "НИЙГЭМШҮҮЛЭХ" буюу гэмт хэрэгтнийг нийгмийн дэг журамд хэвшүүлэхэд оршино. Нийгмийн шинэ хамгааллын онолыг баримтлагчид эрүүгийн эрх зүй, түүний үндсэн институтэд "хуульын заагаагүйгээр гэмт хэрэг гэж байхгүй" гэсэн үндэслэлийг байлгах, гэм буруутай тодорхой хэрэгт эрүүгийн хариушлага хүлээлгэх, ялыг хүмүүнлэг болгох зэрэг нь зайлшгүй шаардлагатай гэж баталдаг юм. Энэ нь эрүүгийн болон байцаан шийтгэх эрх зүйн арчилсан зарим зарчмаас татгалзах замаар хэрэгжинэ гэж үзлэг.

Энд санкцийг сонгоход шүүгчийн үзэмжийг эрс багасгах, ял шийтгүүлэгчид хэрэглэх арга хэмжээнд шинжээчийн гүйцэтгэх үүргийг хэт үнэлсэн, ялын тодорхой хэмжээ, хугацааг тодорхойлоход мэтгэлзэх зарчмыг хязгаарласан зэргийг хамааруулж болох юм.

Эл онолыг зөв ба буруу гэж нэг талыг барьж үнэлж болохгүй. "НИЙГЭМШҮҮЛЭХ" үзэл санаа нь олон улс орнуудын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагданы олны дэмжлэгийг авч, эрүүгийн бодлогын хүчтэй хэрэглүүр болж байна.

Одоо үед өмнө дурдсан сургаалууд дангаараа байхгүй байна. Эдгээрийн хамгийн дэвшилттэй бөгөөд өнөөгийн байдалд нийцсэн, шинжлэх ухаанч зүйлийг хэрэглэж байна.

XXI зуун хүн төрөлхтөнд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны сургаалын шинэ үндсэн чиглэлийг буй болгох нь эргэлзээгүй.

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ  
СОНГОЛТ ТӨЛӨВИШЛИЙН АСУУДАЛД  
/бодрол, эргэцүүлэл/

© 1999 он. Должингийн БАЯРСАЙХАН<sup>1</sup>

Улс, үндэстэн бүхэн тэрхүү нийгмийнхээ овормоц мончнаарыг тусгасан өөр өөрсдийн эрх зүйн онцлог тогтолцоотой байх ажээ. Үүний хамт дэлхийн улсууд эрх зүйт системийн сэжмээрээ адил төстэй ба ялгагдах шинжтэйн дээр тутгээмэл хэв шинж бүхий бүтэц, тогтолцоог харилсан буй болгосон нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэв маяг болж тогтсон байна.

Эрх зүйн тогтолцоо, эрх зүйн систем гэсэн хоёр ойлголтыг адилтган илэрхийлэх боломжгүй, харин ч уттын болон мэнчнаарын эрс ялгаатай ухагдахуун аж. Эрх зүйн тогтолцоо /система права, system of law/ бол тухайн улсад нийгмийн зохицуулалтын хэв маяг болж тогтоон, салбар, бурдэл, институт бүхий үндэсний онцлог /дэвтэгдашгүй/ зохицолдоо нь болдог. Тэгвэл эрх зүйт систем /правовая система, legal system/ нь дэлхийн улс, үндэстнүүдийн эрх зүйн зохицуулалтын адил төстэй шинжийг тусгасан хэв маятийн бүлэг хүрээг харуулах олон улсын тогтолцоот дур төрхийг илэрхийлнэ.

Системт хандлагын онолын төлөөлөгчдийн дийлэнх хэсгийн үзэж байгаагазар<sup>2</sup> "Тогтолцооны өөрчлөлт нь системийн чиг хандлагад нөлөөлөхөөс изүү системийн өөрчлөлт нь тогтолцооны хувь заяг тодорхойлох хандлагатай боллоо..." гэж мэдэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Гэхдээ орчин үед нилээд нэр хүндтэй гарч ирээн уян хатан ба харьцангуй дуалист зарчим нь тогтолцоо хийгээд системийн харилсан хамаарлын зохицтой хувайлбарыг сонгон тогтооход ихээхэн түлхэц үзүүлж байгаа хэдий ч тэдгээрийн төлөвшлийн динамикийг бүрдүүлэхэд зарим сөрөг нөлөө үзүүлэг байна.

Эдүгээ бидний ярьж, олон улсын практикт хэвшмэл нэр томъёо болж хэрэглэгдсээр байгаа 2 том систем /Эх газрын ба Англо-саксоны/ болон дагалдах бусад систем /социалист, лалын, дорнын/ зорэг нь эдүгээ улс орон бүхэнд өөрийн тусгал,

<sup>1</sup> МУИС-ийн профессор, хууль зүйн ухааны доктор/Ph/

<sup>2</sup> Государство и право. 1998, №6, стр 35-40.

monitors via TCP port 2000 (using standard TCP port 2000). The monitor can be used to control the robot's motion and receive sensor data.

МУЛЯЖИ ПОДСЫПОЧНЫХ ГЕОЛОГИЧЕСКИХ

XOJBOOOTON.

Съзанин ѝза за изпращане конкретни обхвати съдържание и търговския експортът, търговският и пакетният транзит  
животновъдствените и растениевъдствените производстви, както и съдържанието на земеделието и  
съдържанието на промишлеността и строителството.

Одними землями болонкійською є їхні відмінні якості, іншими - їхні вади. Епізоди, що відбуваються в місцях зростання, відповідають землям, які вони обирають. Важливо пам'ятати, що болонкійські рослини не можуть жити в сухих, піскових ґрунтах, але вони добре розвиваються в піщаних ґрунтах, які мають високу вологість та підвищений вміст органічних речовин.

байдаг. Угтаа бол Монгол нь эрх зүйл тулгуурласан төр ёсыг бус, харин төр ёсонд тулгуурласан эрх зүйг бий болгон хөгжүүлж иржээ. 1930-1990 онд Монголын төр ёсны түүхэн уламжлалт шинж ихээхэн алдагдаж, Зөвлөлт болон социалист хэв маягийн тогтолцоог даган дуурайж төлөвшүүлсэн билээ. Энэхүү социалист эрх зүйн тогтолцоо нь Монгол үндэсний өөрийнх нь жам ёсны чөлөөт хөгжлийн сонголт хийгээд түүний баталгааг хангахад сөргөн нелөө үзүүлсэн нь мэлээж боловч тухайн үедээ нийгмийн харилцаат зохицуулан тохируулах үүргээ биелүүлсээр ирснийг үгүйсгэх арагтай.

Монгол Улсын хувь одоо нэгэнт бүрэлдэн тогтчихоод байгаа эрх зүйн шинэ тогтолцоо нь ямар уламжлалыг хадгалж, ямар шинэчлэл хэв маягийг тусгасан, аль хэр баталгаатай ямар тогтолцоо вэ? гэдэг нь галны болон манай эрдэмтэн судлаач, улс төрч, хуульч хэн бүхний анхаарлыг татсан зангилаа асуудал болоод байгааг хайхрахгүй орхиж болохгүй мэт.

1992 оны шинэ Үндэсн хууль батлагдсаны дараахан хэсэгхэн хугацаанд олон хууль, тогтоомж гарч үйлчлэх болсонтой холбогдуулж зарим судлаач, эрдэмтдийн дуна Монгол Улсын эрх зүйн тогтолцоог Ром-Германы эрх зүйт системд хамарагдана гэх буюу уг системийг хүлээж авах боломж, нохшол манайд харьцангуй илүү байгаа гэж үзэх<sup>1</sup> хандлага нийлээд газар авсан ба одоо ч хэвээрээ байна. Гэтэл цаашдын үйл явши, орнол, болоод чиг хандлагыг нь авч үзэх юм бол тус улсын эрх зүйн зохицуулалтын нийлээд хэсэг нь Англо-Америкийн эрх зүйн зарчим, жишгийн дагуу хэрэгжиж эхэлсний тадна социалист эрх зүйн ухамсар, сөёл, хэрэглээний практик ч манайд амь бөхтэй хадгалагдсаар байгаа зэрэг нь анхаарал татах боллоо. Ялангуяа иргэн, аж ахуй, банк, санхүү бизнесийн хүрээн дэх эрх зүйн хэм хэмжээг бүтээх, хэрэглэх үйл явши нь тэдгээрийн институт бурийн зохицуулалттай тус тусдаа холбогдон хэрэгжиж байгааг нь Англо-Саксоны системтэй олон шинжээр азил төстэй мэт.

Монгол Улсын Иргэний хууль хэдийгээр шинэчлэгдсэн нэргэй, түүний бүх залтанд тухайн салбарын эрх зүйн бүралдүүд бүхэллээ тусгагдсан гэж үздэг боловч ихэнх тохиолдолд дэвшигдсэн асуудал гарсан маргаан зөрчлийг дээрх хуулиар бус, харин түүнд нийцсэн ба уялдаж гарсан гэрээ, журмын

<sup>1</sup> "Шинэ толь" 1993 №1, 43-47-р тал

бюджета. Тарифы общеобразовательных учреждений определяются в соответствии с законом о тарифах на образование и включают в себя расходы на содержание ученика, оплату труда педагогических работников, оплату труда администрации и т.д.

Установленные тарифы определяются в соответствии с законом о тарифах на образование.

Согласно закону № 122-ФЗ «О тарифах на образование», тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников. Тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников. Тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников.

Тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников.

Тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников.

Тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников.

Тарифы на образование устанавливаются на основе соотношения затрат на содержание ученика и затрат на оплату труда педагогических работников.

ЗУРАГ 1.



Төр, иргэн харилсан үүрэг хүлээх зарчим болон хүний эрхийг хүндэтгэх, хуулийг дээдлэх ёсоond үндэслэн эрх зүйн тогтолцоог салбаруудаар ангилах шалгуур нь:  
а/ Эрх зүйн зарчим,

б/ Эрх зүйн эх сурвалж,

в/ Эрх зүйн зохицуулах зүйл,

г/ Эрх зүйн зохицуулалтын арга гэсэн 4 шалгуур орчин үед зонхилох хэмжүүр болсныг харгалзах нь зүйтэй санагдана. Энэ шалгуураар<sup>1</sup> нийтлэг жишгийг үндэслэн нягтлан авч үзвэл:

а/ Торийн буюу нийтлэг эрх зүйн бүлэгт: Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Экологийн эрх зүй, Татварын эрх зүй, Гаалийн эрх зүй, Төсөв, зээл, санхүүгийн эрх зүй, Цэргийн эрх зүй г.м.

б/ Иргэний буюу хувийн эрх зүйн бүлэгт: Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүй, Хөдөлмөрийн эрх зүй, Худалдаа/ бизнесийн/-ны эрх зүй г.м.

в/ Шүүхийн буюу процессийн/хэвшүүлэя шийтгэх/ эрх зүйн бүлэгт: Эрүүгийн эрх зүй, Ял эллүүлэх эрх зүй, Иргэний хэргийг шүүхэл хянан шийдвэрлэх эрх зүй. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх эрх зүй г.м.

Дээр дурьсан баримтлалууд бол тус улсын эрх зүйн тогтолцоог бүхэлд нь тодорхойлж, үнэлэлт өгөх гэсэн хэрэг огт биш, зөвхөн онолын асуудлыг сонирхон суудлагч очижухэн би бээр өөрийн молхи эрэгцүүлэлд тулгуурласан бодомж төдий зүйл гэдгийг дурдахыг хүсч байна.

<sup>1</sup> Энэ шалгуур бол зөвхөн тухайн ижтэй улсын эрх зүйн тогтолцооны лигитийн тогтооход баримтлах тохиул нь юм. Харин хууль зүйн шийжлийн ухааны салбаруудыг залгах шалтуур биш юм.

Монгол Улсын эрх зүйн тогтолцооны төлөвшилд харгалзах учиртай нэг чухал зүйл бол Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийг хэрхэн антлж, тэдгээрийг яаж үндэлж, хэрэглэх вэ? гэдгийг тогтоох явдал юм. Одооны практикаас үзэхэд нийлээ шүүгчид эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхдээ зөвхөн кодекс буюу төрөлжсөн хуулийг хэт шүтэж, түүний заалтуудыг эрх зүйн ухамсрын маш явцуу хүрээнд удирдлага болтон баримталдаг байна. Гэтэл Монгол Улс оноөдор олон улсын 90 шахам гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон буюу соёрхон баталж, Үндсэн хуулианд тэдгээрийг кодекс буюу үндэсний төрөлжсөн хуулийн хэмжээнд үндэлж тогтоочихсон байдаг. Уг нь шүүгч хүн хуулийг тодийгүй Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэх мэдлэг чадвартай байх ёстойсон. Түүнчлэн манай улсын нийгмийн амьдралын оноогийн дүр төрх нь аль ч улсын дамждаг шилжилтийн үйл явцын дунд үедээ байгаа гэдгийг харгалзвал Монгол Улсын эрх зүйн тогтолцоо нь бүрэн төлөвшиж амжаагүй, хуримтлагдсан олон асуудлууд тулгамдсан бөгөөд шийдлээ хүлээсэн шинжтэй байгаа нь тодорхой. Хуулиар хориглоогүй бухнийг зөвшөөрч байж хуулиар зөвшөөрөөгүй бүхнийг хориглох нь оноогийн нехцөлд илүү боломжтой загвар байж болох юм. Ер нь зөвшөөрлийн ба хориглолтын хязгаар хүрээг эрх зүйн императив ба диспозитив аргын уялдаа, хамааралд нь авч үзэж тогтоох нь зөв болов уу?

Эрх зүйн тогтолцооны төлөвшилд түүний онол, сэтгэлгээний бөрчлөлтөөс гадна хууль зүйн практик, эрх зүйн сургалт, эрх зүйн орчны шинчилэл зэрэг олон зүйл нэгэн алил хамааралтай гэдэг нь ойлгомжтой. Цаашдаа Монгол Улсад эрх зүйн шинэ тогтолцоо хэрхэн бүрэлдэн төлөвшиж байгааг шинжийн судлах, түүний хөгжлийн явц, чиг хандлагыг ямагт анхсаарч, хуримтлагдсан зангилаа асуудлуудыг хугацаа алдаагүй шийдвэрлэж байх шаардлагыг зүй ёсоор тавигдаж байна.

## ДААЛГАВАРГҮЙГЭЭР БУСДЫН АШИГ СОНИРХОЛЫН ТӨЛӨӨ УЙЛДЭЛ ХИЙХ

© 1999 он. Балганы СҮРЭНХҮҮТ<sup>1</sup>

Амьдралл нэг этгээд ногдоо этгээдээс тодорхой үйлэл хийх ямар нэг бүрэн эрх олгогдоогүй байхад бусдын ашиг сонирхлын толоо сайн дураар тодорхой үйлдэл хийж гүйшэтгэх нөхцөл байдал зарим үед үүслэг. Энэ үйлдлийг жишээ нь, гэрийн тэжээмэл амьтныг нь асарч хамгаалах, байгалийн гамшигийн үед бусдын эд хөрөнгийт аюулгүй газар зөөх, баглаж бэхлэх, хөршийнхөө гэрт гарсан галыг унтраахад сайн дураар ороцшох зэргээр эрх ашиг сонирхол нь хамгаалагдагч этгээд ямар нэг шалтгаанаар өөрийн эрх, ашиг сонирхолоо хамгаалах боломжгүй буюу түр хутацаагаар байхгүй үед нь түүний эд хөрөнгийн ашиг сонирхолд нь заналхийлсэн хохирлоос урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг багасдах зорилгоор хамгаалагч этгээд ёс суртахууны ухамсар төсөөлөл, бодлогоор дээрх үйлдлийг хийдэг байна.

Иргэний эрх зүйн энэ харилцаанд даалгаваргүйгээр бусдын ашиг сонирхлын толоо тодорхой үйлдэл хийгч, эрх, ашиг сонирхлоо хамгаалуулсан этгээд гэсэн хоёр тал байна. Бусдын ашиг сонирхлын толоо тодорхой үйлдэл хийгч этгээдийг ром-германы эрх зүйн системт улсуудаа гестор/gestor/ гэж нэрлэдэг, харин эрх ашиг сонирхол нь бусдаар хамгаалагдсан этгээдийг доминус /dominus'a/ гэж нэрлэж ирсэн байна.

Бусдын ашиг сонирхолын толоо үйлдэл хийгч этгээд тодорхой нөхцөлд ашиг сонирхол нь хамгаалагдсан этгээдээс дээрх үйлдлийг хийсэнтэй холбоотой гарсан зардал, зарим тохиолдола үйлдлийнхээ толоо шагнал урамшуулал хүртэх эрхийг олж авдаг. Ийм төрлийн үүрэг нь бүр Римийн эрх зүйн үзэс хэрэглэгдэж, negotiorum gestio гэж нэрлэгдэж ирсэн байна.

Монгол Улсын Иргэний эрх зүйн салбарт дээрх харилцаа мөн зохицуулагдаж ирсэн ба Иргэний хуулийн 329 дугаар зүйлийн 2-т "Бусдын эд хөрөнгөнд хохирол учирч

<sup>1</sup> "НИК" ХК-ийн хуулийн зөвлөх, хууль зүйн ухааны магистр.

болзошгүй бодитой аюулын тухай омчлогч буюу эзэмшигчид нь урьдчилан мэдэглэх боломжгүй нохцөлд уг аюулыг зайлцуулсан зохих бүрэн эрхгүй этгээд зардал, хохиролоо төлүүлэхийг омчлогч буюу эзэмшигчээс шаардах эрхтэй" хэмэн хуульчлан зохицуулжээ. Даалгаваргүйтгээр бусдын ашиг сонирхлын төлөө үйлдэл хийхэд хэдэн нохцол бий болсон байх ёстой. Үүнд:

а/Юуны өмнө үйлдэл хийгч /gestor/ өөрийн санаачлаггаар бусдын ашиг сонирхлын төлөө тодорхой үйлдэл хийсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, сонирхогч этгээдтэй ямар нэг гэрээ хэлцэл байгуулаагүй, даалгавар хүлээгээгүй байх, мөн ямар нэг урьачилсан заавар буюу тохиролцсон амлалт аваагүй байх ёстой /Жишээ нь асран хамгаалагч асран хамгаалагчийн ашиг сонирхлын төлөө авлагдсан эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэг энд хамаарахгүй.

б/Бусдын ашиг сонирхолын төлөө үйлдэл хийгч нь мэдээжийн бодитой ашиг сонирхолын төлөө үйлдэл хийх ёстой. Өөрөөр хэлбэл, сонирхогч этгээдэд үнэхээр ашигтай үйлдэл хийсэн байх ёстой. Үйлдлийн ашиг нь эд хөрөнгөд учрах байсан наал захын эвдрэл, гэмтэл алдагалыг сэргийлсэн байх ёстой.

в/Гестор бусдын ашиг сонирхолын төлөө үйлдэл хийхэд сонирхогч этгээдээс зохих зөвшөөрөл авах боломжгүй нохцөл бий болсон байх. Өөрөөр хэлбэл, ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд ойр орчимд байхгүй байсан, түүнээс зөвшөөрөл авах боломжгүй байх. Учир нь бий болсон нохцөл байдал нь удаашрал үүсвэл эд хөрөнгийн алдагалыг багасгах сэргийлэх боломжгүй байж, гестороос шуурхай үйлдэл хийхийг шаардсан байдалаг. Хэрэв яаралтай нохцөл байдал үүсээгүй, сонирхогч этгээдээс зөвшөөрөл авах боломжтой байсан бол дээрх үүргийг үүсгэхгүй.

г/Бусдын ашиг сонирхлын төлөө өөрийн хийж буй үйл ажиллагааг ухамсарлан ойлгосон байх, иргэний эрх зүйн ямар нэг өөр үүрэг үүсгэхэд чиглэгдээгүй байх ёстой. Дээрх шинжээр нь түүнийг иргэний эрх зүйн бусад үүргийн эрх зүйн харилцааныас, жишээ нь үндэслэлгүйгээр эд хөрөнгө олж авах үүрэг, бэлэглэл, ажил гүйшэтгэх тэрээний үүргээс ялгах боломжтой. Хэрэв үйлдэл хийхээ өөрийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн гэж алдаатайгаар төөрөгдсөн /өөрийн эд хөрөнгийг эвдрэл, гэмтлээс хамгаалсан гэх/ бол энэ нь эд хөрөнгө үндэслэлгүйгээр олж авснаас үүсэх харилцаа болно.

Дээрх бүгдээс дүгнэж үзүүлэлт хийснээс үүсэх үүрэг нь хэн нэг этгээдийн болит ашиг сонирхлын төлөө үйлдэл хийснээс үүсэх үүрэг нь хэн нэг этгээдийн болит ашиг сонирхлын төлөө тодорхой этгээд сайн дурын үндсэн дээр болит болон хууль зүйн үйлдэл хийснээс, ашиг сонирхлоо хамгаалулсан тал түүнд зайлшгүй гарсан зардал, учирсан хохирлыг арилгах, зарим тохиолдолд шагнал өгөх үүргийг үүсгэж байгаа гэрээний бус үүрэг болно.

Дээрх үүрэг сайн дурын үндсэн дээр үүсэж байгаа боловч энэ нь үйлдэл хийгч гесторыг ямар нэг үүргээс чөлөөлж байгаа хэрэг бус. Хэрэв өөрийн санаачлагадаар бусдын ашиг сонирхолын төлөө үйлдэл хийсэн бол наад зах нь дараах гурван дүрмийг баримтлах ёстой. Үүнд:

а/ тэрээр зайлшгүй анхаарал болгоомжтойгоор тухайн нөхцөл байдалд хандаж үйлдэл хийх. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагандаа халамж тооцоотой эзний ёсоор хандаж, хэтэрхий бүдүүлэг, илт болгоомжгүй алдаа, дур зоргоор үйлдэл хийхгүй байх ёстой. Хэрэв үйлдэл нь илт санаатай, хэтэрхий болгоомжгүй бол зохих хариуцлагыг хүлээн.

б/ анхны боломжит хугацааны дотор ашиг сонирхол нь хамгаалагдсан этгээдэд өөрийн үйлалийн талаар мэдэглэж, түүний авч хэрэгжүүлсэн үйлдлийг дэмжсэн буюу эс дэмжсэн тухай санал, шийдвэрлиг боломжит хугацааны дотор хүлээн.

в/ өөрөөс гарсан зардал, алдагдал хохирлыг тоошож мэдэгдэх ёстой. Гэхдээ энэ зардлын хэмжээ нь учирч болох байсан хохирлын хэмжээнээс бага байх ёстой гэсэн зарчим мөн үйлчилдэгийг анхаарах хэрэгтэй.

Эдгээр нөхцөл бүрдсэн тохиодолыг доминус буюу ашиг сонирхол нь хамгаалагдсан этгээд гестороос гарсан зардал, хохирлыг төлөх үүрэг хүлээдэг байна.

## ЭРХИЙН ХИЙДЛИЙН<sup>1</sup> ТУХАЙ МИНИЙ ТӨСӨӨЛӨЛ

© 1999 он. Дашилдогийн ҮҮРЦАЙХ.<sup>2</sup>

*"Хуулшуд бол аалмын шүлстэй адил: Сүл дорийн чуудыг тэр ороодог, харин хүн чадалтнууд түүнийг урж массадаг."*

*/Салон. Эртний долоон мэргэдийн нэг/*

Эрх зүйн онолын нэг үндсэн судлагдахуун нь эрхийн хийдлийн тухай асуудал байдаг. Түүнийг шинжлэх ухаанчаар судлахын ач холбогдол нь нийгмийн харилцааг эрхийн хэм хэмжээгээр зүй ёсонд нийцүүлэн бүх талаас нь бүрэн дүүрэн зохицуулж, ингэснээр нийгэмл шударга ёсыг тогтооход оршино.

Эрхийн хийдлийн талаар манай орны болон гадаадын эрдэмтэн судлаачид харилцан адилгүй үзэл болдлыг дэвшүүлсэн байдаг.

Тухайлбал, хууль зүйн ухааны доктор /Ph/ Д.Баярсайхан эрхийн хийдлийг тодорхойлохдоо: "Эрх зүйн хийдэл гэлэг нь хууль, түүний хэм хэмжээнүүлээр шууд зохицуулагдах харилцаа нь тийнхүү хуульчлагдаж чадаагүйгээс эрх зүйн үйлчлэл дутагдаж, хууль зүйн үр дагавар бий болгосон серөг нехцөл байдал мөн" гэжээ.<sup>3</sup> Тэгвэл зарим эрдэмтэд "Эрх зүйн хийдэл гэлэг нь эрх зүйн харилцаны хурээнд байгаа нийгмийн холбоо, фактуудад эрх зүйн хэм хэмжээ бүрэн ба хэсэгчлэн дутагдах явдал юм"<sup>4</sup> хэмээн тодорхойлсон байна.

ОХУ-ын эрдэмтэн хууль зүйн ухааны доктор, профессор В.И.Леушин, хууль зүйн ухааны доктор, профессор

<sup>1</sup> Нэр томъёоны хувь "эрх зүйн хийдэл" биш "эрхийн хийдэл" гэж изэрлэсн нь эрх чөлөө гэдэг бол боломж, эрх гэдэг нь болохийн хэмжээ, нийгмийн харилцааг эрхээр зохицуулдаг, харин эрх түй бол эрхийг судалдаг шинжлэх ухаан, хууль гэдэг бол нийтийн эрхийн ширэхэн хэлбэр хэмсэн үзэг зохиончийн үзэг болдийн холбоотой юм. /Д.У/

<sup>2</sup> "Шинийн түүх" ХЭЦС-ийн багийн, хууль зүйн ухааны магистр.

<sup>3</sup> Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 1996 но. 83 дахь тал.

<sup>4</sup> Ч.Нямсүрэн. Эрх зүй төрийн сронхийн онолын зарим асуудал. УБ., 1995 он. 78 дахь тал, И.Гантула. Төр, эрх зүйн сронхийн онол. УБ., 1998 он. 118 дахь тал.

В.Д.Перевалов нар бичихдээ: "Эрх зүйн зохицуулалтын хүрээнд орж ирсэн нийгмийн харилцааг зохицуулахад шаардлагатай тодорхой эрх зүйн хэм хэмжээ дутагдахыг хууль тогтоомж дахь хийдэл гэнэ"<sup>1</sup>

Эрхийн хийдэл нь ямагт позитив эрхийн хүрээнд гардаг бөгөөд харин төрөлх эрхийн хэм хэмжээ нь формаль тэгш байдлынхаа агуулга болон нийгмийн иөөц баялгийн хязгаарлагдмал байдлаар нөхцөллөж ямар ч хийдэлгүй байдлаар тодорхойлогддог. Харин субъективт оюун санаа /терийн/-ны оролцоотойгоор тогтоогдсон позитив эрх нь хүн бүрт тэгш боломжийт тэр бүр олгож чаддагтуй бөгөөд зарим зохицуулагдах шаардлагатай нийгмийн харилцааг зохицуулалтгүй орхигнуулах нь элбэг байдаг. Ийнхүү орхигнуулсанас тэдний хооронд үүслэг аяндаа зохицохгүй зорчил нь шударга ёсанд нийшэхгүй арга хэрэгслээр шийдвэрлэгдэж, зүй ёсанд нийшэхгүй үр дагаварыг авчирдаг. Ингэснээр бодит тэгш байдлын агуулга зөрчигдэж, улмаар нийгэмд сахилга, дэг журамгүй байдал үүсэх аюулыг агуулж байдаг. Позитив эрхийн хүрээнд эрхийн хийдэл гардаг явдлыг субъективт оюун санааны хүч чадавхитай холбон үзэж болохоос гадна төрөлх эрх бол хийсвэр шинжтэй байшаг, харин позитив эрх бол илүү бодит шинжийг агуулж байдгэр бас тайлбарлаж болох юм.

Эрхийн хийдэл гэдэг бол эрх бүтээх үйл ажиллагаанд гарсан алдана, дутагдлын улмаас эрхийн зохицуулалт шаардлагатай байгаа нийгмийн харилцаануул зохицуулалтгүй орхигдож, эрхийн зарчмыг зорисон сөрөг үр дагаварыг бий болгодог нийгмийн сөрөг үзэгдлийг хэлнэ.

Эрхийн хийдлийн шалтгаан нь хууль тогтоомж амьдралын хөгжлөөс хоцорсон эсвэл хууль тогтоох процессод зайлшгүй тооцож үзэх ёстой нөхцөл байдлуудыг тооцоолоогүй явдал байдаг байна.

Хууль зүйн ном зохиолд эртний Грекийн нээрт сэтгэгч Аристотель "эрхийн хийдлийг хэсээ ч хувиршгүй жам ёсны хуулиар шийдвэрлэх хэрэгтэй" гэж үзэж байсан талаар тэмдэглэсэн нь бий.<sup>2</sup> Эндээс позитив эрхийн хийдэл нь аль ч нийгэмд зайлшгүй байдаг нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд

<sup>1</sup> Теории государства и прав. Со автор, ред. В.М.Корельский, Д.В.Перевалов. М., 1998, стр 390.

<sup>2</sup> Ч.Икмсүрэн. Эрх зүй төрнийн сронхий онолын зарим асуудал. УБ., 1995 он, 77 дахь талаа үзүүлүү.

түүнийг даван туулах, шийдвэрлэх арга замыг че үеийн эрдэмтэн судлаачид эрж хайсаар ирснийг мэдэж болно. Позитив эрхийн илрэх хэлбэр нь төрөөс батлан гаргаж буй хууль тогтоомж байдаг учир эрхийн хийдлийг хууль тогтоомжкоос эрж хайх хэрэгтэй болно. Өөроор хэлбэл, эрхийн хийдэл нь төрөөс батлан гаргасан хууль тогтоомжийг тусгалаа олсон байдаг бөгөөд түүнийг одоо үйлчилж байгаа хууль тогтоомж болон эрхээр зохицуулагдаа ёстай нийгмийн харилцаа хоёрын хоорондын харьцааг судлан шинжилсний үндсэн дээр нээн илрүүлж болох юм. Харин түүний илрэх түвшний хэмжээ нь тухайн улсын хөгжлийн цараа, төрийн төлөвшүүлээс хамаараад янз бүр байдаг.

Эдүгээгийн эрхийн онолд эрхийн хийдлийг эрх зүйг хэрэгжүүлэн биелүүлэх үйл явцтай холбоотойгоор авч үзэж судалдагтай миний бие бүрэн санал нийлэхгүй байгаа юм. Учир нь эрхийн хийдэл бол эрхийн хэм хэмжээг тогтоож огоонгүйгээс, эрхийн зохицуулалт дутагдсанаас үүсэж байгаа нийгмийн сөрөг үзэгдэл болохоос нэгэнт батлагдаад гарчихсан хэм хэмжээг буруу ташаа хэрэгжүүлэн биелүүлснээс үүсэн гарч байгаа сөрөг үр дагавар биш юм. Эрх бүтээх үйл ажиллагааны явшал субъектив өюун санааны хүч чадавхи дутгасанаас болж үүссэн эрхийн хийдлийг бол буруутах аргагүй юм. Харин манай эрхийн ном зохиолуудад "дамжмал", "дараачийн", "үучилж болшгүй" гэх зэргээр нэрлэсэн сөрөг нохцол байдал нь бол энэхүү өгүүллийг бичигч миний бодоход эрхийн хийдэл биш харин эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэн биелүүлэх явшал гарч байгаа эрх зүйн субъектив алдаанууд юм. Зарим тохиолдолд бүр гэм буруутай, эрхийн зөрчил ч байж болох талтай юм. Ямар нэг ашиг сонирхлын үүднээс эрхийн зохицуулалтыг буруу ташаа байдлаар тогтоох, түүнийг хэрэгжүүлэн биелүүлэх явшал буруутгаар тайлбарлах, хэрэглэх зэрэг нь субъектүүдийн сөрөг үйл ажиллагаа болж хувирна. Үүнийг эрх зүйн хийдэлээс ялгаж ойлгох шаардлагатай болов уу. Эрхийн хийдэл гэдэгт тухайн нэг нийгмийн харилцааг зохицуулсан эрхийн хэм хэмжээ огт байхгүй байхыг ойлгох бөгөөд манай орны зарим эрдэмтдийн тайлбарлаж байгаачлан нийгмийн харилцааг хагас дутуу /буруу Д.Ү./ зохицуулсан байдал нь бол хууль тогтоогч субъективийн буруутай үйл ажиллагааны үр дүнч бий болсон эрх зүйн алдаатай зохицуулалт юм. Өөроор хэлбэл, тодорхой нэг нийгмийн харилцаанд тодорхой нэг л эрхийн хэм хэмжээний зохицуулалт хэрэгтэй бөгөөд тэр зохицуулалт нь тогтоогдсон уу, үгүй юу,

хэрэв тогтоогдсон бол буруу юу, зөв үү гэлэг асуудал л яригдах ёстой болохоос бүрэн ба хагас дутуу зохицуулалт гэсэн ойлголт байж таарахгүй гэж үзэж байна. Тиймээс эрх зүйн хийдлийг а/ аливаа харилцаны зохицуулалт бүрэн дутагдах, б/ хагас дутуу зохицуулагдах гэсэн төрөлд ангилан авч үзэх шаардлагатай юм. Тухайлбал, иргэн Б нь хүч хэрэглэн иргэн Ц-ийн эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулжээ. Энгийнээр тайлбарлавал, энэ хоёр нийгмийн гишүүний хооронд үүссэн нийгмийн харилцааг "Хүний эрүүл мэндэд хүч хэрэглэн хүнд гэмтэл учруулж болохгүй. Хэрэв үүнийг зөрчиж хүнд гэмтэл учруулавал тээзи жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ" гэсэн гипотез, диспозиц, санкциас бүрдээн нэг л эрхийн хэм хэмжээгээр зохицуулсан байгаа юм. Аливаа эрхийн хэм хэмжээ нь эдгээр гурван элементийг заавал агуулсан байх шаардлагатай гэдэг дээр эрхийн онолын судлаачид барог бүгд санал нэгддэг билээ, Эдгээр элементүүдийн аль нэг нь байхгүй тохиолдолд эрхийн хэм хэмжээ болж чадахгүй юм. Тэгэхээр аль нэг элементийг нь хууль тогтоогч хууль тогтоомжлоо тусгалгүй орхигдуулсан бол энэ нь хагас дутуу зохицуулалт биш, харин эрхийн хэм хэмжээгээр огт зохицуулагүй буюу эрхийн хэм хэмжээ дутагдаж эрхийн хийдэл бий болж байгаа хэлбэр юм. Дашрамд хэлэхэд манай хууль тогтоох практикт сүүлийн үед хариуцлага /санки/-гүй тунхаглалын шинжтэй үүргүүдийг их хэмжээгээр хуульчилдаг болоод байгаа билээ. Өөрөөр хэлбэл, үүрэг болгосон, хориглосон шинжтэй хууль тогтоомжийн заалтууд их тааралдааг боловч тэлгээрийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудлыг орхигдуулсан байх нь элбэг тохиолдох болжээ. Субъектив эрх бүрийн негөө талд хууль зүйн үүргийн тухай асуудал бодитойгоор оршиж байдаг богоод үүрэг бүрийн ара үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын асуудал заавал яригдах ёстой.

Өөрийн энэхүү эмпирик санаа бодолдоо үндэслэн би эрхийн хийдлийг даван туулах, шийдвэрлэх цорын танц арга зам бол тухайн нийгмийн харилцанд дутагдаж байгаа эрхийн зохицуулалтыг тогтоож өгөх буюу эрхийн хэм хэмжээг шинээр батлан мөрдүүлэх явдал юм гэсэн дүгнэлтэд хүрч байна. Харин эрхийн хийдлээс урыачилсан сэргийлэхийн тулд хууль бүтээх үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдана.

Эрдэмтэн судлаачид эрхийн хийдлийг шийдвэрлэх аргад

эрхийн хэм хэмжээ, зарчмыг төсөөтэй хэрэглэх зарчмыг хамгаруулан авч үзсэнд бүрэн тал өгч болохгүй байгаа юм. Тухайн нийгмийн харилцааг зохицуулсан эрхийн хэм хэмжээ дутагдаж байгаа нөхцөлд хууль хамгаалах байгууллагын субъектүүд хууль тогтоомжийн заалтыг төсөөтэй хэрэглэх, тийнхүү төсөөтэй хэрэглэх хууль тогтоомжийн заалт байхгүй тохиолдолд эрхийн агуулга, зарчимд нийшүүлэн шийдвэрлэх эрхтэй байдааг хэдий ч тэдэнд ямар нэг хууль тогтоох эрх мэдэл байдаггүй билээ. Энэ бол бидний сонгосон эх газрын эрхийн тогтолцооны хэлбэрийн онцлог билээ. Гэтэл бас хэм хэмжээг нь төсөөтэй хэрэглэж болдоггүй эрхийн салбар /Эрүүгийн эрх/ байдаг. Түүнээс гадна төрөлх эрхийн агуулга, зарчимд нийшүүлэн аливаа асуудлыг шийдвэрлэнэ гэвэл хэдийгээр позитив эрхийг төрөлх эрхэд аль болох ойрсон байлаар тодорхойлон тогтоохыг хичээдэг ч гэсэн үнэн хэрэг дээрээ тэс өөр хязгаарлалт, хориглолтыг тогтоосон байdag учир позитив эрхийнхээ бусад хэм хэмжээнүүдийг үтгүйсгэж, улмаар эрхийн тогтолцоо маань нурахад хурч болзошгүй юм.

Харин бид Англо-Саксоны эрхийн тогтолцоонд хэрэглэгдлэг шүүхийн прецедентийн тухай асуудлыг авч үзвэл дээрх билний эрхийг төсөөтэй хэрэглэх зарчмытай агуулгын хувь маш ялгатай болохыг олж харж болно. Энэхүү шүүхийн прецедентийг хэрэглэж байгаа тохиолдолд нэг талаас тодорхой нэг хэрэг маргзаныг шийдвэрлэж байгаа шүүхийн процесс боловч негээ талаас хууль тогтоо агуулгыг давхар агуулж, тэрхүү шүүхийн шийдвэр нь тухайн хэрэг маргаантай ижил дараагийн тохиолдолд хуулийн хучин чадалтайгаар үйлчилдэг билээ. Тэгэхээр энэ бол тухайн нийгмийн харилцааг зохицуулсан эрхийн хэм хэмжээг шинээр тогтоож байгаа хэрэг болохоор энэ тохиолдолд эрхийн хийдлийг шийдвэрлэж чадлаа гэж үзэж болох юм. Гэвч энэ нь шүүхийн прецедент хэрэглэх нь эрхийн хийдлээс зайлсхийх зөв зүйтэй цорын ганц арга зам мөн гэсэн үт хараахан биш юм.

Ром-Германы эрхийн тогтолцоонд хамарагдах эрхийн тогтолцоотой улс орнууд сүүлийн үед өдөр ирэх тусам асар их шинэ агуулгаар баяжин нэмэгдэж байгаа нийгмийн харилцаануудыг бүтгийг нарийвчлан хуулиар зохицуулах боломж хомс болж байгаа учир срөнхий зарчим, хандлагыг нь хуульчлан тогтоож өгөх чиглэлийг баримтлах болсныг бас дурдах хэрэгтэй юм.

Түүнчлэн манай зарим эрдэмтэд эрхийн хийдлийг хуулийн албан ёсны тайлбараар шийдвэрлэж болно гэж үзээн байдаг.<sup>1</sup> Хэрэв нийм аргаар эрхийн хийдлийг даван түүдах гэвэл маш аюултай, хамгийн бүдүүлэг алдаа болно гэж үзэж байна. Энэ нь тэр ч байтутай засаглалын эрх мэдлийн хувалцалалтын зарчим, төрийн төлөвшийд ч аюултай байж болох талтай. Хуулийн албан ёсны тайлбар хийнэ гэдэг нь хуулийн зүйл, залтны агуулгыг хуулийнхаа хүрээнд тайлбарлах үйл явц болохоос эрх зүйн зохицуулалт дутагдсан нийгмийн харишиааг зохицуулалттай болтох, шинээр хууль тогтоох үйл явц байж хэрхэвч таарахгүй юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн албан ёсны тайлбар нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зарчмыг хангах, нийгмийн харишиааг нэгэнт зохицуулж эхлээд байгаа хууль тогтоомжийг амьдралд хэрхэн зөв ойлгож, хэрэглэх тухай гарч байгаа акт болохоос тухайн нийгмийн харишиаанд дутагдаж байгаа эрхийн хэм хэмжээг тогтоож буй акт биш юм.

Сүүлийн жилүүдэд манай улсад эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хуулиуд олноороо шил шилээ даран ойр фйорхон гарах болсон нь нийгмийн зохицуулагдаагүй харишиааг зохицуулалттай болгож байгаа сайн талтай ч, цаг үеэ олоогүй, хууль зүйн арга техникийн хувьд алдаатай бүтээгдсэн, тооцож үзэх ёстой нөхчөл байдалдуудыг бүрэн хамаарч чадаагүй хуулиуд нь нийгэмд үр дүнгээ өгөхөөсөө илүү сорог нөлөө үзүүлж үр дагавар авчрах нь их болжээ.

Хуулийг бүтээхдээ байх ёстой шаардлагыг нь байгаа бодит байдала нь тулгуурлан томъёолох замаар гаргадаг байна. Ингэхдээ тухайн үндэсний онцлог, нийгмийн хөгжлийн түвшин, боломж нөхчөл, хүний эрхийн байдлыг зайлшгүй харгалздаг. Үүний хамт дэлхийн хөгжлийн ба хөгжих бүй орууудын нийтлэг жишиг, түгээмэл хандлагыг ч бодолсон байх учиртай. Эдгээр зарчим, үндэслэл, зүй тогтолыг тооцохгүйгээр хуулийг "механикаар" зохион гаргавал тэр нь олон нийтийн изрэлж заншсаныар "хуулийн цоорхой" буюу эрх зүйл томъёологдсон "Эрхийн хийдэл" гэгч сорог үзэглийт бий болтоно.

Нийгмийн социалист байгууллаас зах зээлийн эдийн засаг бүхий нийгэмд шилжин ороод удаагүй байгаа манай орны эрхийн тогтолцооны хувьд эрхийн хийдлийн асуудал нийзэд

<sup>1</sup> Ч.Нямсүрэн. Эрх зүй төрийн сронхий онолын зарим асуудал. УБ., 1995 он. №2, 78 дахь талд үзүүлүү.

1996 oħrae sejher xypja. Ie ja onn qiegħi minnha

Еп ти сподихи хутияи та тодомою тафхини иншанин  
хендер зонундаган ахын замгандар хөтөлбөрүүлүп  
тапшырып чең күнүн дөңгөлөнүүнүн көмүкүүнүн  
алынчында жана таңында жана таңында жана таңында

Городской округ села Красногородка, Тульская область, 300000, г. Красногородка, ул. Мира, д. 10, тел. 7661-0661.

хуулиуд цаг хугацшаны шалгуураар орж, түүний зохицуулалтын агуулга нь нийлээд хэмжээгээр танигдаж мэдэгдсэн юм. Эрхийн хийдэл ил гарч, нийлээд нохтой үр дагавар бий болгож эхэлсэн ўе гэж үзэж болно.

Энэ үед хууль тогтоох ажиллагаа хямралд орж, гарсан хуулиуд нь илт хоорондоо зөрчилдэх болсон төийгүй, нэг байгууллага, нэг хувь хүнд зориулж хууль үйлдвэрлэж, "хуулийн цоорхой"-г хуулын нэмэлт, ворчлолт оруулах замаар шийлдвэрлэх гэсэн оролцлого нийлээд гарах болсон юм.

Энэ үед хууль тогтоогч субъектийн мэргэшшлийн чанар нь алдагдаж, эрх зүй ба хуулийн хоорондын харилцааг эс тоосноос болж хууль зүйн ач холбогдол бүхий шинжлэх ухааны нэр томъёонууд нь хуулийнхаа заалттай зөрчилдэж хуульчид чөөрдсөө ойлгож хэрэглэж чадахарагүй хуулиуд бүтээгдэх болсон байна.

Түүнчлэн тодорхой нэг субъектийн ашиг сонирхлын үүдиээс зориудийн "хуулийн цоорхой" үүсгэх, эсвэл зориудын буруу зохицуулалттай хууль гаргах, эрхийн хийдэл гарч болзошгүй нөхцөл байдлыг таслан зогсоохгүй байх явдал зарим үед хууль тогтоогчийн зүгээс ажиглагдаж байлаа.

Эрх хийдэлтэй байх нь торны завсраар унаачих боломжтой жижигхэн бие /сэтгэл/-тэй шударга биш хүмүүст, эсвэл торны энгийн нухээр хуруу нь багтан орж хүчтэй аттак боломжгүй үзэмж биетнүүдээ л ашигтай байдал. Аливаа гэмт хэрэг, зорчлийг томоохон албан тушаалтан үйлдээд хариушлага хүлээхээд хүрвэл "хуулийн цоорхойг" ашиглан бултах гэж оролцдог нь өнеөдөр нэгэнт зурсил болоод байна. Эрхийн шинэтгэлийг "эрчимтэй" хийхийг нийгмийн амьдрал, зохицуулалтгүй байгаа олон харилцаанууд биднээс шаардаж байгаа боловч бидний зохицуулчихсан гэж бодож байгаа зохицуулалтгүй орхигасон бусал харилцаанууд эрхийн шинэтгэлийг бас "чанартай" хийхийг шаардсан байгаа билээ.

Тэгэхээр эрхийн шинэтгэлийг эрчимтэй бас чанартай хийхэд бидэнд ямар бэрхшээл байна вэ? гэвэл, хууль бүтээх үйл ажиллагааны бүх ўе шатанд эрх зүйн эрдэмтдийн хүч оролцоог бүрэн дайчилж, боловсон хүчиний зөв боллогоо баримтлан, хууль тогтоогчийн мэргэшсэн чанарыг дээшлүүлэх, товчихон хэлбэл, хууль бүтээх үйл ажиллагаагаа цаашид улам боловсронгуй болгох шаардлагагаа тулгараад байна.

## МОНГОЛ ДАХЬ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТОЛОВШЛИЙН ҮНДЭСНИЙ ЗАГВАРЫН ОНОЛ-ПРАКТИКИЙН АСУУДАЛД

© 1999 он. Гэлэгнүүлийн ЧУЛУУНБААТАР<sup>1</sup>

Иргэний нийгэм бол хүн төрөлхтний түүхэн жам ёсны ўйл явцын хүрээнээ дэлхийн жишиг, ерөнхий хандлагын зүй ёсны үр дүн болон төлөвшүүлж буй нийгэм-иргэншилийн нэглмэл уг чанар бүхий бие даасан тогтолцоо мөн. Түүний үндэс эдүгээ дэлхийн тэргүүний хөгжилтэй улс орнуудын нийгмийн практикт хэдийнээ тавигдаж, орчин үеийн иргэншилт улс түмнүүдийн хөгжлийн ирээдүйн чит баримжаа болж байна. Энэ утгаараа иргэний нийгэм бүс нутаг, улс үндэстэн бүрийн нийгмийн амьдралд төлөвшин тогтоходо олон янзын хувилбар, үндэсний загваруултай байх нь эргэлзээгүй. Аль ч улс үндэстэн иргэний нийгэмд хүрэх замдаа харьялагдаж буй бүс нутгийнхаа хэмжээнд үүсэн хөгжих буй өвөрмөц хувилбарыг түшиглэсэн үндэсний бие даасан загварыг бүтээх нь тухайн ард түмний туурга туслгаар тогтнон хөгжих, хүн төрөлхтний иргэншилийн хөгжлийн нийтлэг сан хөмрөгт хувь нэмрээ оруулж буйн баталгаа мөн.

Мэдээлийн болон технологи, худалдаа хамтын ажиллагааны хамгийн эрчимтэй сүлжээгээр холбогдож, улс хоорондын олон талт харилцаанд газар зүйн байрлалаас шалтгаалсан саад бэрхшээл үлэмж багассан өноогийн олон хэмжээст дэлхий өртөнчэд нийгэм-иргэншилийн ялгаа бүхий хувилбар, бие даасан загварын тухай асуудал нийлээд өөрийн утга учиртай болоод байна. Орчин үед иргэний нийгэм төлөвших явцад янз бүрийн хувилбар хийгээл үндэсний загварууд үүсэн хөгжих нь зарим нэг хүчин зүйл дээр нөхцөлдөж түүхэн ёсоор зайлшгүй болж байна гэж үзэх үндэстэй юм.

Хүн төрөлхтний түүхэн ўйл явцын их масштабын шатлалаар дэлхий дахинь хэмжээнд нийгэм-иргэншилийн хөгжлийн хүрсэн төвшнөөрөө ялгаа бүхий бүс нуттууд оршиноор байгаа бөгөөд тэрхүү бүс нутаг бүрийн хүрээнд төлөвшин бүрэлдэж буй нийгэм-иргэншилийн тогтолцоо нь ерөнхий

<sup>1</sup> ШУА-ийн Физикофициология, социология, эрхийн хурээлэнтгийн захираг, доктор /РН/.

хандлагат, язгуур жишгийнхээ шинж байдлаар адил төсөвтэй байхын зэрэгцээ хэлбэр, зохион байгуулалт, үйлчилэн орших арга механизмынхаа талаас ялгаттай хэвээр байна. Энэ нь нийтлэг шинжлэх үйл явши бус нутгийн онцлог бүхий Дорноц Епропын, Америк-Канадын, Япон-Зүүн өмнөд Азийн гэх мэт хувилбаруудтайгаар хэрэгжих явдлыг нөхшүүлж бойгаа болно. Үүний зэрэгцээ нэг бус нутгийн хүрээнд харьялгадж буй улс орнууд ч дотроо хөгжлийн өөр өөр төвшинтэй, үндэсний өвөрмөц онцлогтой байна. Энэ нийгэм-иргэншилийн тогтолцоо хийгээд иргэний нийгмийн толёшиг нь ард түмэн бүрийн үндэсний өвөрмөц онцлогийг тусгасан Америкийн, Оросын, Японы, Монголын гэх мэт үндэсний загварууд үүсэн хөгжих суурь дэвсгэр агуулгадж байгаа болно. Орчин үед дэлхийн янз бүрийн бус нутгуудад бие даасан үйлдвэрлэл, эдийн засгийн хүчинчлэг төвүүд үүсэн хөгжжэй байна. Ийм төвүүдийн хүрээнд шашин-соёлын болон нийгэм-иргэншилийн тогтолцооны бие даасан хувилбар, тэнд харьялалтай ард түмний амьдралда хөгжлийн үндэсний загварууд үүсэх үйл явц өрнөж байна.

Нийгмийн хөгжлийн хувилбар, загварын тухай асуудал зөвхөн өнөөгийн шатны үзэгдэл гэж үзвэл ташаа ойлголт болно. Түүнд түүхийн гүнзгий сурвалж бий.

Хүний нийгмийн хөгжлийн бүх түүх үндэснээс түхийн янз бүрийн субъектүүдээр дамжин бүтээгдсэн хувилбар, загваруудын гинжин хэлхээ байсан гэж үзэж болох үндэстэй. Дэлхийн түүхийг их масштабын түвшинд хамаарч судалгаа хийсэн томоохон сэтгэгчдүүн бүтээлүүдэд нийгэм-иргэншилийн үйл явцыг үечлэн тайлбарласан өдий төдий онол, баримтлал байдал нь чухамдаа хөгжлийн янз бүрийн хувилбар, загваруудын үзэл санзааг агуулж байдал билээ. Жишээлбэл, К.Маркс формацийн онолын үүдээсээ хүний нийгмийн хөгжлийн түүхийг их масштабын шаталцаар үечлэхээ "...хүн байгалийс хараат нийгэм, хүн хүнээсээ хараат нийгэм, хүн юунаас ч хараат бус нийгэм" гэсэн бол Улс төр, эдийн засгийн ухданыг шүүмжлэх нь зохиолын оршилдоо "эртний Грек-Ромын, феодалын, орчин үсийн" гэх мэтээр ангилсан байдал. Үүний эхний үечлэлд иргэний нийгмийн хувилбар, загвартай холбон үзэж болох нийгэм-иргэншилийн аспект түлхүү ажиглагдаж байхад хоёр дахь нь бүхэлдээ нийгэм-эдийн засгийн формацийн шаталсан хувилбарт хөгжлийн үндэсийг тодорхойлжээ.

АНУ-ын угсаатны зүйч, түүхч Люис Генри Морган XIX

зууны дундуур хүн төрөлхтөн нийгэм-иргэншилийн хөгжлийг зэрлэг, бүдүүлэг, соёлт гэсэн турван үе болгон ангилж, ангилаал тус бүрд дээл, доод дуна шатуулыг гаргаж байсан хийгээд мөн У.Ростоугийн ололтын таван үечлэл бүхий онол, германы сошиологич О.Шпенглерийн иргэншилийн хөгжлийн турван үе, Английн түүхч А.Тойнбийн ердийн нийгэм ба иргэншилийн төрлүүл, амьт ба сөнөсөн иргэншилийн тухай ойлголтууд,<sup>1</sup> К.Ясперсийн түүхэн хөгжлийн үндсэн замнал хийгээд түүний янз бурийн хувилбаруудын талаарх сөрөнхий бүдүүвч<sup>2</sup> зэрэг нь хүний нийгмийн хөгжлийн түүхийн нэгдмэл хийгээд олон талтай үйл явц аль нэг бүс нутаг, улс үндэстний амьдралд биежин хэрэгжихдээ янз бурийн үе шатанд өөр өөр загвартай хөгжиж ирснийг гэрчлэн харуулж байна.

Бүс нутгийн хэмжээнд болон түүний доторх улс үндэстнүүдийн нийгэм-иргэншилийн хөгжлийн оншлогийг тусгасан хөгжлийн бие даасан хувилбар, загвар байсан тухай Ази, дорно дахини судалгааны бүтээлүүдэд олонгтаа тусгагсан байдгийг бил мэднэ. Оросын эрдэмтэн А.Н.Гумилев, И.Я. Залаткин, В.Я. Владимирцов, Францын эрдэмтэн Ш.Монгеские нарын бүтээлүүдэд<sup>3</sup> нүүдэлчилд болон Азийн бусад ард түмний түүхэн хөгжлийн оншлогийг тусгасан хөгжлийн хувилбар загварын тухай санаа дүгнэлт цөөнгүй тааралдлаг.

Хүн төрөлхтний нийгэм-иргэншилийн хөгжлийн түүхэн практик, тэдгээрийн талаарх мэргэд сэтгэгчийн бүтээсэн шаштираас үзэхэд хөгжлийн аливаа хувилбар загвар нь түүхэн туршилагыг нэйтгэн дүгнэж боловсруулсан тодорхой нэг онол, арга зүй үзэл баримтлалы тулгуурлаж байдааг нь илэрхий байна. Эдүгээ орчин үеийн иргэний нийгмийн төловшлийн үйл явцыг сулахад ямар нэг байдлаар суурь баримжаа болохуйц нийгэм-улс төрийн шинжктэй хоёр гол үзэл баримтлал байна гэж үзэж болох юм.

Нэг. Техникийн гарвалтай иргэншилийн хөгжлийн түүхэн явцад капиталист нийгэм-эдийн засгийн формыг өөроос нь ургуулан шинэтгэх замаар арчилал, зах зээлийн бие даасан тогтолцоог үүсгэн хөгжүүлж, тэр суурин дээрээ иргэний

<sup>1</sup> А.Тойнби. "Постижение истории" М., 1996 г. стр 28-29, 68-69, 71.

<sup>2</sup> К.Ясперс. "Смысл и назначение истории" М., 1994 г. стр 56, 70-72.

<sup>3</sup> А.Я.Залаткин, "Основные закономерности феодализма у коренных скотоводческих народов" и кн. "Типы общественных отношений на Востоке в средние века" М., 1982 г. стр 265.

нийгмийн үндсийг төлөвшүүлж буй Европ, Америкийн тэргүүний хөгжилтэй орнуудын бий болгосон хувилбар, хөгжлийн одоогийн загварыг тусгасан онолын нэгэн үзэл баримтлал байна. Үүнийг Өрнөдийн ихэнх эрдэмтэд хүн төрөлхтний хөгжлийн түүхэн жам ёсны үйл явцын илэрхийлэл гэж үзэг.

XVIII зуны үед амьдарч байсан Шотландын эдийн засагч Адам Смит үндсийг нь тавыж, Альфред Маршалл, Ф.Хаек, Мильтон Фридман нарын үргэлжлүүлэн боловсруулсан эн үзэл баримтлалын гол агуулга нь хувийн үйлдвэр, чөлөөт худалдааг бүх талаар дэмжиж эдийн засаг, нийгмийн хөгжил төрийн гүйцэтгэсэн үүрэг, оролцоог ихээхэн хязгарагдаг юм. Үүгээрээ орчин үеийн иргэний нийгмийн төловшища ихээхэн орон зайд нээж өгдөг. Өрнөдийн орнуудын ондөр хөгжлийн нэг гол хүчин зүйл энэ юм. Өнөө үед хөгжлийнхөө ирээдүйн хувилбар, загварыг сонгох штанд буй дэлхийн олон улс орон үүнийг анхааран судалж сонголтын баримжаа болгож байна. Хөгжлийн ийм хувилбар, загварын үзэл баримтлалыг АНУ-д Бута Найрамдах нам, Германда Христосын арчилсан нам, Англид Консерватив нам, Японд либерал арачилсан нам зэрэг улс төрийн налдээ бүхий хүчинүүд баримталж бүс нутгийнхаяа болон улс орныхоо нийгэм-иргэншийн амьараад хэрэгжүүлж байдаг.

Аливаа улс үндэстэн хөгжлийн энэ үзэл баримтлалыг удирдлагыг болговол эдийн засгийн өсөлтийн хурдааг харьшнүүгь богино хугацаанд нэмэгдүүлж, зохиц үр дүнү хүрдэг боловч нийгмийн хумуунлэгийн хүрээ, социаль хөгжлийн хувьд хури асуудалууд хуримтлаглаж, энэ чиглэлээр хөгжлийн улаашрал гарч эхээдэг байна. Энэ утгаарал дурыасан үзэл баримтлалыг иргэний нийгмийн төловшиийн хамгийн оновчтой багеөд ирээдүйтэй баримжаа болно гэж түйлшруулан ойлгож болохгүй юм. Сонголт хийхэд дэлхийн ирээдүйтэй чиг хандлага, тухайн бүс нутгийн болон улс үндэстний түүхэн уламжлал, өвөрмөц онцлогийг харуулсан маш нарийн тоошоо судалгаа, зөв оношгүй болдого, үйл ажиллагаа шаардагдана.

Дээрх үзэл баримтлал нь үүсэл, төловшиийн түүхэн агуулгаарал Өрнөдийн орнуудад эхэлж хөгжлийн боловсронгуй төвшинд хүрсэн боловч хэрэгжиж биежих прагматик утгаарал бол дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий хандлагыг илэрхийлж байгаа болохоор түүнийг аль нэг бүс нутаг юм уу улс оронд

бүрэн тохиирно, эсвэл тохирохгүй гэж механикаар хандах зүйл нийцэхгүй. Гагихуу шаг үеийг олж оншлогтоо нийцсэн хэлбэрээр баримжсаа болгон бүтээлчээр хандах нь чухал.

**Хоёр.** Үзэл баримтлалын дээр дурьласан шугамыг эсэргүүцэн сөрсөн вөр нэг үзэл баримтлалын үндсийг Германы их сэтгэгч К.Маркс тавьжээ. Үүний гол агуулга бол төрийн зөв зохицуулалт, төвлөрсөн төлөвлөгөө нь эдийн засаг, нийгмийн тулгуур хүчин зүйл гэж үзэх явдал мөн. Маркс капитализмын /тухайн үсийн/ эдийн засгийг хүмүүнлэг энэрэнгүй үзэл, нийгмийн шударга ёсны зарчмын байрнаас задлан шинжлээд ийм дүгнэлтэд хүрсэн байна. ХХ зууны эхэнд Оросын хувьсгалт онолч В.И.Ленин, Английн эдийн засагч Жон Кейнс нар энэ үзэл баримтлалд шинэтгэл хийсэн хоёр вөр хувилбарыг бий болгожээ. В.И.Лениний хийсэн шинэтгэл, тайлбарын дагуу хийсэн нийгмийн туршилт 70 жил болоод явцдаа явцууран тажуудаж мухардмал байдалд орлоо. Хэрэв 1920-иод оны дунд үед Ленин өөрийнхөө үзэл баримтлалд хийж эхлээд түйцээж амжаагүй шинэтгэл, тодотголыг түйцээн үргэлжлүүлж хэрэглэсэн бол үйл явцын өрнөлт, хувь заяа оноөдрийнхөөс арай өөр байж ч болох байсныг үгүйсгэх аргагүй.

Кейнсийн хийсэн шинэтгэлийн агуулга нь үндэсний орлого, хөрөнгө оруулалт, ажилгүйдэл, хуримтал зэрэг макро эдийн засгийн төвшинд төрийн зохицуулалтын үүрэг, оролцоог онолын талаар зохистой үндэслэхэд чиглэж байлаа. Тэгээд ч энэ онол 1929-1933 онд дэлхий дахиныг хамарсан нийгэм эдийн засгийн хямарлыг гэтлэн давахад гол түлхэц болжээ. Өнөө үед Р.Солоу нарын онолчиц уг онолыг цаашид хөгжүүлэн нарийн зохицуулалтыг нийгэм-иргэншилийн хөгжилд зохистой хэрэглэх арга механизмыг судлан боловсруулж байна. Эл үзэл баримтлал орчин үеийн хөгжилтэй орнуудын нийгэм-улс төрийн амьдралд өргөн хэрэглэгдэж байгаа юм. АНУ-ын ардчилсан нам, Европ, Канад, Японд социалист болон социал-демократ намууд сронхийшоёо энэ үзэл баримтлалыг баримтлан нийгэм улс төрийн үйл ажиллагасаа явуулдаг. Нийгмийн хөгжлийн хүмүүнлэгийн хүрээний социаль асуудлуудыг шийдвэрлэхэд голлон анхаардаг шинжээрээ иргэний нийгмийн хүмүүнлэг, энэрэнгүй шинж, шударга ёсны харилцанд чухал үүрэг түйштгэлдэг. Харин нийгмийн амьдрал, ялангуяа эдийн засагт төрийн оролцоог чухалчилдаг талаасаа бол иргэний нийгмийн сонгодог утганд төдий л нийштэй биш талтай. Дорно дахинь улс орнуудын

хувьд бол түүхэн ба үндэсний уламжлалд нь нилээд ойр учраас хөгжлийн сонголт хийхэд нь дээр дурьдсан либерал чиглэлийн үзэл баримтлалас илуү нийштэй байж болох юм.

Арга зүйн нийтлэг учир холбогдол бүхий дээрх хоёр үзэл баримтлал тодорхой нэг улс үндэстний нийгэм-иргэншийн тогтолцооны хөгжлийн хүрээнд зэрэгцээн үйлчилж хөгжлийн үе шатуудаар нөлөөллийн хэмжээ нь харилсан солигдох үйл явц орчин үеийн иргэний арчилсан нийгмийн нохцолд зүй тогтлын шинжктэй болоод байна гэж үзэж болно. Учир нь хөгжлийн энэ хоёр үзэл баримтлалын аль аль нь онол, арга зүйн ерөнхий зарчмуудаараа нэг нь негеөгийнхээ сүл буюу серег талыг нөхөн сэлбэж харилсан баяжуулж байдаг. Энэ нь нийгмийн шинжилгээний ерөнхий онолын хувьд бол формацийн хийгээд иргэншлийн хандлагын зохицтой хослол, нийгэм улс төрийн практикийн хувьд эдийн засаг, нийгмийн үйл явцын нэгдлийг илэрхийлж байдагтай холбоотой юм.

Иргэний нийгмийн хувилбар, үндэсний загварууд үүсэн хөгжихэд орчин үеийн нийгмийн хөгжлийн интеграши, дифференциацийн үйл явцыг дагалдан дэлхийн иргэншийн сүлжээнд шинээр үүсэн тогтох буй эдийн засаг, нийгэм, цэрэг улс төрийн бие даасан төвүүд бодитой нөлөө үзүүлэх хандлагатай байна. Өнөөдөр Америк тивд АНУ, Канад, Мексикээр төвлөсөн хүчирхэг бие даасан холбоо нэгэнт бий болдюү. Европод энэ зууны энэс гэхэд нэг галаад бодлоготой, нэг мөнгөн тэмдэгттэй, хил гаалийн болон нийгэм-улс төрийн нэгдсэн тогтолцоотой "Нэгдмэл улс" байгуулагдах нь улам бүр тодорхой болоод байна. Турк, Казахстанаар төвлөсөн Европын холбоо буюу бие даасан хөгжлийн төв үүсэх хандлага ажиглагдаж ирлээ. Ази тива цөмийн зэвсэгтэй дөрвөн/АНУ, ОХУ, Хятад, БНКазах, ял/ улсын зэрэгцээ худаллас санхүүгийн том гурэн Энэтхэг, Зүүн өмнөд Азид Вьетнам, Индонез тодорч 10-15 жилийн дараа дэлхийн энэ өнцөгт Европын холбоо шиг Зүүн өмнөд Азийн интеграц үүсэхийг үгүйсгэх аргагүй байна. Ойрын үед нэглмэл Солонгос Улс бий болж хөгжвэл Зүүн хойд Азид бас нэгэн хөгжлийн төв буй болохыг ч бас үгүйсгэх аргагүй юм.

Дэлхийн хөгжлийн шинээр буй болж байгаа энэхүү дүр төрх нь нэг талаас, геополитикийн шоо шинэ асуудлуудыг үүсгэж, олон улсын харилцаа олон туйлттай, нарийн нийлмэл шинжктэй болохыг харуулж байгаа бөгөөд негеө талаас хөгжлийн

...*synonym* *Ain cyllant* [1997 on, N.I., I.S.-I.G.] *supra* *tel.*

Зоне оподібні виробництві та землеробстві, а також в сільському господарстві, які використовують підприємства земельного фонду та земельно-рекреаційного фонду. Важливим є використання земельного фонду для розширення та підвищення ефективності земельного фонду та земельно-рекреаційного фонду. Земельний фонд використовується для виробництва та землеробства, а також для земельного фонду та земельно-рекреаційного фонду. Важливим є використання земельного фонду для розширення та підвищення ефективності земельного фонду та земельно-рекреаційного фонду.

бол Японы хөгжлийн загварын гол сүнс нь юм, "Нээлттэй хаалга" гэдэг бол харьшангуй ойлголт. Юуны өмнө хаалгаа хэнд, юунд нээж, хэнээс, юунаас хэзх, хэзээ хэаж, хэзээ нээх зэргийт маш нарийн тооюу ёстой аж. Япончууд дэлхийн хамгийн өндөр хөгжсөн техник, технологи, оюуны үйлдвэрлэлийн хамгийн өндөр түвшинд хүрсэн ололтод л хаалгаа нэгэн зэрэг, адил болзотойгоор ишээжээ. Үүнийхээ үрээр Япон Өриодийн аль нэг орны нөлөөнд ороогүй юм. Тэд эдгээр орноос зөвхөн техник, технологи төдий биш соёл, иргэншилийн ололтыг нь тодорхой шалгуур шаардлагатайгаар авч хэрэглэжээ. Шалгуур, шаардлагын агуулга нь тэдний үндэсний уламжлал, зан заншил, соёл, ёс суртахуунд харшилахгүй байх явалаар тодорхойлогдож байсан гэж үзэж болно. Ийм ч учраас Японы хөгжлийн загварыг япон хүний сэтгэлийн тэнхээ, уйгагүй хөдөлмер, даруу зан, нягт нямбай амьдрал, эвсэл хамтаж зуршил зэрэг Дорно дахины уламжлалт нийгэмтэй холбогдох онцлогтүйгээр төсөөлөх аргагүй юм. Энэ утгаар авч үзвэл олон зууны түүхтэй нүүдлийн сонгодог соёл, нийгэм-иргэншилийнхээ дэвштлэгтээ өвийг сэргээж түүхийн нэгэн цаг үел Монгол их гүрний буй болгож бүтээсэн хөгжлийн хувилбар загвараар баримжаалсан үзэл баримтлалаар хөгжих тухай манай нийгмийн сэтгэлгээнд оршиж буй хандлагыг буруутгах аргагүй мэт санагдана.

Өнөөдөр дэлхий сөртөнцөд олон авсан иргэншилийн үлэмж нарийн сүлжээ үйлчилж, тэр нь улс үндэстэн, бус нутаг бүрийн нийгэм-иргэншилийн хөгжлийн загварт тодорхой байдлаар нөлөөлж байна. Иргэншилийн олон шалгуур үзүүлэлтээр олон хэв маяг болгон ангилдаг. Тухайлбал, а/ газар зүйн байрлал, тивийн харьяаллаар нь Өрнүүн, Дорнын, Ази, Европ, Америкийн гэх мэт, б/ Бус нутгийн байдлаар нь Дорнод европын, Ойрхи дорнодын, Евро Азийн, Зүүн өмнөт, Зүүн хойд Азийн гэх мэт, в/ Аж төрөх ёсны хэлбэр, амьдралын хэв маягаар нь нүүдлийн ба суурин, уламжлалт ба орчин үеийн гэх мэт, г/ Оюуны соёл, шашны байдлаар нь Барууны, Конфуцийн, Японы, Лалын, Славян-ортодокс, Латин-Америкийн, Африкийн гэх мэтээр ангилах явдал орчин үеийн нийгэм, улс төрийн ном зохиолд түгээмэл тохиолддог. Энэ бол өнөөдөр хүн төрөлхтний нийгэм-иргэншилийн хөгжлийн аль ч асуудлыг иргэншилийн сүлжээнээс ангиа авч үзэх аргагүй байгаагийн тусгал юм. Иргэншилийн харьцангуй бие давсан

шинжтэй хэв маягууд үйлчлэн оршиж, тэдгээр нь ард түмэн бүрийн нийгмийн эмьдралын срөнхий дүр төрхийг тодорхойлоход нэлвээтэй байгаа учраас иргэний нийгмийн загвар, хувилбаруудын төлөвшил ч түүнээс олон талаар хамаарах нь ойлгомжтой. Орчин үеийн нийгэм судлалд, ялангуяа Монгол орны ирэхэдээ иргэншилийн хөгжлийн ирээдүйг улс орныхоо онцлогтой холбон ойлгох талаар наад зах нь гурван янзын байр суурь илэрч байна. Судлаачдын нэг хэсэг нь Монголчуудын уламжлалт буюу нүүдлийн иргэншилийг бүрэн үтгүйгэж, Өрнөдийн иргэншилийг хөгжлийн баримжкаа болгохыг уриалж<sup>1</sup> байхад нөгөө хэсэг нь Өрнөдийн техникийн гарвартай иргэншилээс татгалзаж Дорно дахины хөгжлийн зам, нүүдлийн сонгодог иргэншилд тулхүү ач холбогдол өгч байна.<sup>2</sup> Гурав дахь хэсэг нь хоёр иргэншилийн зохицтой хослолын тухай санааг голлон барьж байх жишээтэй. Энэ бол судалгааны бие даасан тусгай асуудал. Бид энд зөвхөн иргэний нийгмийн үндэсний загвар үүсч хөгжихэл иргэншилийн нөлөө багагүй болохыг тэмдэглэх зорилгоор дурьдав. Бидний хувьд гурав дахь байр суурийг илүү оновчтой гэж үздэг. Иргэншил бол аль ч ард түмний хамгийн тогтвортой гол шинжүүдийн нийлбэр цогц мен. Гэхдээ энэ ямар ч өөрчлөлтийг хүлээж авахгүй хөшүүн шаршанг зүйл огт биш.

АНУ-ын Харвардын их сургуулийн профессор Самуэл П. Хантингтон ирээдүйл "... дэлхийн боллогын зарчмын сэргэлдэөн нь янз бүрийн соёл иргэншилтэй үндэстэн бүлгүүдийн хооронд үүсэх болно"<sup>3</sup> гэсэн нь санамсаргүй зүйл биш юм. Түүнийхээр ойрын ирээдүйд дэлхий бүхэлдээ 7-8 бие даасан иргэншилийн хариулсааны талбар болох ажээ. Энэ профессорын хийж буй дутгэлттэй олон янзын санаа дэвшүүлэн ярих боломжтой хэдий ч бид энэ удаад зөвхөн иргэний нийгмийн төлөвшлийн үйл явц олон янзын загвар, хувилбаруудтайгаар хөгжихийн нэг үндэс болгон түүнээс ишилэл хийв.

Дээр дурдсан зүйлүүдээс үзэхэд иргэний нийгэмд хурех ард түмэн бүрийн зам нь олон янзын хувилбар, үндэсний

<sup>1</sup> Багчуулүүн. Соёл иргэншил нүүдэлж хоёр хосолдог уу? "АЭ" сонин. 1997 он. №44.

<sup>2</sup> Н.Хавх. "Монголчуудын соёл иргэншилийн түн ухаан". УБ., 1995 он. 141 дэв тал.

<sup>3</sup> "Эрэ чөлөө" сонин. 1993 он. №32.

загваруудтай байх нь тодорхой байна. Хувилбар, загвар бүр өөрийн өвөрмөц онцлогтой байх бөгөөд тэдгээрийг нэг бүрчлэн урьдзас томъёолж гаргах аргагүй юм. Харин онол, үзэл баримтлалын нийтлэг баримжaa хийгээд хувилбар загварыг зайлшгүй болгон буй хүчин зүйлүүднийг иш үндэс болгон тэдгээрийн мөн чанар, онцлогийг нь судлан боловсруулахад анхаарах сронхий зарчмуудыг тоймлон гаргаж болно. Уг зарчмуудын үндсэн шаардлага нь иргэний нийгмийн олон хувилбар, үндэсний загварууд аль нэг сонгодог бүдүүвчийг шууд хуулбарлах замаар ч биш, үндэсний онцлог, уламжлал бүхнийг явштал баримтлах замаар ч биш, тагихуу дэлхийн хөгжлийн нийтлэг хандлагаар нөхцөлдөн улс түмний нийгэм-иргэншилийн бодит практикаас үндэслэдэг явдал мон.

Хүн төрөлхтний түүхэнд үе үе тохиолдлог огцом их өөрчлөлтийн хүрээнээ зохицон дэвшлийн зам мөрийг олох нь түүрга туусгаар улс үндэстний түүхэн зайлшгүй үүрэг байдал. Монгол Улс ХХI зууны босгон дээр нийгмээ эрс өөрчлөх замыг сонгоходо хүмүүнлэг иргэний арчилсан нийгмийг эрхэм зорилгоо болгосон. Зорилгыг ямар ч утгаар ойлголоо гэсэн ирээдүйг тодорхойлдог. Орчин үеийн ирээдүй судлал / футурологи/ шуд, ойрын, алсын гэж ангилааг. Ийм ангилал харьцаангүй шинжлэй. Хүний нийгэм уламжлал, шинэчлэлийн залгамж холбоогоор хөгждэг учраас ирээдүйг зөвхөн тодорхой зорилгоор л таслан баримжаалж байна. Иргэний арчилсан нийгэм бол өвөөгийн Монголын шуул, ойрын болон алсын ирээдүйн залгамж холбоог илэрхийлсэн ерөнхий зорилго мөн. Энэ утгаараа түүнд хөгжиж хүрэх зам нь өвөрмөц загвартай байхын зэрэгцээ тодорхой үе шаттай байх болно. Иргэний нийгмийн хөгжил төлөвшлийн аливаа асуудлыг, юуны өмнө улс төрийн амьдралын тодорхой узэгдлүүдийг арчилалтай холбон авч үзэг нь санамсаргүй хэрэг бишээ.

Байгалиас хүмүүн бүрт адил тэгшээр заясан сэтгэж үйлдэх чадвар, хэл яриагаар өөр хоорондоо нэвтрэлийн чанар бол арчиллын хамгийн анхдагч нөхцөл юм. Хэл, сэтгэхүй, үйл хөдлөл нь хөгжлийн тодорхой шатанд, тодруулбал, эртний хүй нэгдэл, овог, аймгийн үес зохицуулалтын ямар нэг арга, зарчмыг бий болгож ирэв. Янз бүрийн газар орон дахь ийм зохицуулалтын нийт хүн төрөлхтөнд хамаарах арга зарчмын нийлбэр цогцыг арчилал хэмээн нээрлэж болно. Харин арчилал хаана, хөгжлийн ямар шатанл, ямар хэлбэр, агуулгатай

болж байсныг гаргах гэвэл уртын урт түүх хөврөх болно. Гагихүү арчилал бол сэтгэхүй, үйл хөдлөлийн тасралтгүй процесст үүсдэг нийгмийн харилцааны зохицуулалтын аргачилсан зарчим мөн гэсэн улс төр, философийн энэхүү тутгэмэл утга л элдүгээ бидний үед нийлээл цэгцэрэн уламжлагдаж ирсэн гэлэг гол санааг энд онцлууштай.

Бидний яриж буй "аргачилсан зарчим" хэмээх нь эзэн биегүй хийсвэр ухагдахуун. Энэ нь биет субъект, тухайлбал тодорхой хувь хүн, ард түмний амьт үйл ажиллагаанд биежин бодит зүйл болдог. Тэгэхдээ хүний үйл ажиллагааны хамгийн энгийн хэлбэрээс эхлээд төрийн засаглал хүртэл өргөн хүрээт хамарна. Хөгжлийн ийм бодит байдлыг арчиллыг хөгжүүлсэн "барууны", "Баруудын", Америкийн, Японы, Энэтхэгийн тэх мэт хувилбар, загварууд болгон ойлгодог. Арчиллыг хэн нэгэн "өмчилдөг" гэсэн санаа эндээс төрөх ёсгүй. Түүнийт өмчилж болсогтуй. Харин өөрийн болгон хэрэглэж, өөрийн гэсэн арга ухаанаар хөгжүүлж болдог. Арчиллыг хөгжүүлэх хувилбар буюу үндэсний загварыг "аргачилсан зарчим" гэсэн сренхий бөгөөд хийсвэр утганаас нь шууд гаргах гэвэл их төвөгтэй. Энэ зарчим иргэний нийгмийн хөгжлийн явцад тодорхой прагматик үзэгдлүүдээр дамжин хэрэгжинэ. Ийм учраас түүнийт тодорхой утгуудад буулгаж үзэх учиртай. Тодорхой утгууд нь улс орон бурийн нийгмийн бодит байдлыг тусгасан өвөрмөц онцлогтой байдал. Монгол улсын тухайд энэ нь эрх, үүрэг, хариуслагын нэгдэл, сахилга дэг журам, зохион байгуулалтын хэлбэр, бичигдэж батлагдаагүй амьдралын "хууль" ба бичигдэж батлагдсан төрийн хуулийн агуулгын зохицол, ард түмний улс төрийн уламжлал, ухамсар, соёлын онцлог байдал, төрийн засаглалын бүтэц, хэлбэр ба улс төрийн нам, байгууллагуудын уялдаа зохицол зэрэг улс төрийн үзэгдлүүдийн хэлбэртэй байгаа болно. Эдгээр багш үзүүлэлтүүдийг амьдрал дээр буулгаад үзэхээр улс төрийн харилцааны бодит хүчин зүйлүүдийн хэлбэрээр оршино. Гэхдээ тус тусдаа бие даасан байдлаар бус, өөр хоорондоо харилцан нягт шүтэлзээтэйгээр нарийн нийтмэл цогцолборыг үүсгэдэг. Ийм цогцолбор нь эсийн дүндээ арчилал, улс төрийн харилцааны бие даасан хувилбар, иргэний нийгмийн арчилсан дүр төрхийн улс төрийн агуулгыг илтгэнэ. Тэгэхээр тогтолцоо үүсгэгч хүчин зүйл шийдвэрлэх үүрэгтэй. Аливаа тогтолцоог бусдаас ялгагдах гол зүйл нь энэ юм. Тухайлбал, "барууны" гэж бидний нэрлэсэн иргэний нийгмийн

хөгжлийн тэр загварт ийм үүсгэгч гол хүчин зүйл нь "Эрх чөлөөний тухай" үзэл санаа байдаг. Энд дээр дурдсан улс төрийн бүх хүчин зүйлүүдийг хувь хүний бүх талын чөлөөт хөгжил, эрх чөлөөний тулгуур үзэлд зангилан зохицуулах үзэл баримтлал ноёрхдог. Харин "Баруудын" гэх шинээр эрчимтэй хөгжих буй Дорно дахины орнуудын загварын тухайд бол үндэсний онцлог байдлыг нь тусгасан сахилга, зохион байгуулалтын тогтолцоог уламжлалын үзэл санаатай няйт хослуулах эсүудал тогтолцоо үүсгэгч гол хүчин зүйл байх аж. Эдгээр орнуудад улс төрийн харилцааны бүх үзэгэл, арчиллын механизмыг чухам энэ хүчин зүйлийн суурь давсгэр дээр нэгтгэн авсан үзэл баримтлал үзэмж нөлөөтэй байдаг. Энэ мэтийнгээр аль нэг бүс нутгийн улс орнууд болон тодорхой ард түмний улс төрийн амьдрал, арчиллын хөгжилд өөр хоорондоо адил биш тогтолцоо үүсгэгч хүчин зүйлүүд байгаа нь тодорхой байна.

Иргэний нийгмийн үндэсний загвар нь зах зээлийн харилцааны хөгжлийн евөрмөц онцлогтой шууд холбоотой. Монголын нийгмийн эдийн засгийн амьдрал зах зээлийн харилцаанд төрийн оролцоо, зохицуулалт хөгжлийн аль ч үед оншгой үүрэгтэй явж ирсэн билээ. Орчин үеийн эдийн засгийн философиј "Төрийн зохицуулалттай зах зээл" гэдгийн изана К.Марксийн төрийн зохицуулалтын тухай үндэслэлийг бүтээлчээр хянан шинэчлэх замаар хөгжүүлсэн Ж.Кейнс, Р.Солоу нарын консерватив маягийн онол байгас гэж үзэг. Энэ онол үндэсний орлого, хөрөнгө оруулалт, хуримтлал, ажил эрхлэлт зэрэг макро эдийн засгийн төвшинд төрийн оролцоо хэрэгтэй гэхийн зэрэгцээ хувийн үйлдвэрлэл, худалдаа өрсөлдөөнийг чөлөөтэй хөгжих боломжийг угүйсгэдэгтүй ажээ. Үүнийг Америк, Европод ч, Япон, Зүүн өмнөд Азид ч тодорхой улс төрийн хүчинүүд баримталдаг. Энэ онолд түшиглэсэн хөгжлийн хувилбар нийгмийг харьцангуй цогчлбор шинжтэй хөгжүүлэх боломж олгодгоороо онцлог юм.

Ер нь зах зээлийн харилцаа гэдэг ямар боловч тодорхой онол, үзэл санаанд үндэслэдэг. Тэр онол тодорхой ард түмний төрийн байгууламж, үндэсний ухамсар, ёс заншил, соёлын онцлог байдалтай хосолж нийлээ зах зээлийг хөгжүүлэх бие даасан хувилбарын оюун санаа, улс төрийн үндэс болдог байна. Харин аль «хувилбар дан ганц энэ үндсэн дээр бий болж чадахгүй. Үүний зэрэгцээ байгаль орчин, газар нутаг, хүн ам,

аж ахуй эрхлэх уламжлал зэргийг багтаасан эдийн засаг-нийгмийн үндэсний суурь хөрс байх нь зайлшгүй. Энэ хоёр нехшэл буюу хүчин зүйлс үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хоорондох харилцаанд тусгалаа олсон тэр бодит байдлыг зах зээлийн тогтолцооны бие даасан хувилбар гэж үзэж болно. Эндээс ут хувилбарын хамгийн ерөнхий шинж байдлыг харуулах тодорхой үзүүлэлтүүдийн системийг ургуулан төсөөлөх боломжтой.

Үйлдвэрлэлийн эрх чөлөө, бие даасан байдалд үндэслэсэн чөлөөт өрсөлдөөнийг хэрэглэгчийн нийтлэг эрх ашгийн үүднээс зохицуулах төрийн зохицуулалтын арга хэлбэр, хүрээ хэмжээ бол зах зээлийн тогтолцооны хөгжлийн үндэсний хувилбар буй болж байгаа эсэхийн нэгэн чухал бүлэг үзүүлэлт мөн. Төр оршин байгаа нь улс орон тусгаар тогтион буйн гэрч байдаг болохоор төрийн зохицуулалтаас "бүрэн чөлөөт" үндэсний зах зээл гэж байх аргагүй. Бас бүхнийг төрийн гарг огчихсөн зах зээл урт насалдаатгүй. Тэгэхээр нэгэнт л үндэсний зах зээлийн тухай ярьж байгаа юм бол тэнд төрийн зохицуулалтын хэлбэр, хэмжээний тухай асуудал гол зүйл болдог нь жам ёс. Дээр дурдсан эдийн засгийн онолын алийг нь ч баримталсан гэсэн төрийн зохицуулалт макро эдийн засгийн түвшний асуудал байдаг. Энэ бол уг зохицуулалтын хүрээ үндсэндээ үндэсний орлогын үйлдвэрлэл, хөренгө оруулалтын хуваарилалт, хуримтлал, ажил эрхлэлт зэрэг цөөн асуудлыг хамарна гэсэн үт. Харин хэлбэрийн тухайт бол эдгээр хүрээнд тодорхой нехшэл байдлыг харгалзан төрөөс явуулдаг уян хатан бодлого, үйл ажиллагааны хэлбэрийн нийлбэр цогцыг хэлж болно. Тухайлбал, төрийн зүгээс үйлдвэрлэлийг урамшуулах бодлого, монополийн эсрэг бодлого, монгө, санхүү зээлийн бодлого, хүн амын нийгмийн хамгзалалтын бодлого гэх мэт.

Төрийн зохицуулалтаар хамрах асуудлын хүрээг тэлж, арга хэлбэр нь нарийсч "хатуурахын" хэрээр үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэнэ. Хүн амын нийгмийн хөгжлийн асуудлуул хоцрогдох, арчилал, эрх чөлөөний агуулга явцуурах хандлага бий болж ирнэ. Харин үүний эсрэг нехшэл үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил харьшангуй удаашран улс орны эдийн засгийн чадавхи сулрах хандлагатай боловч нийгмийн хүрээний асуудлуул илүүтэй шийдвэрлэгдэж, арачилал, эрх чөлөөний хувьа илүү ахиштай байдаг. Төрийн зохицуулалтыг ямар хэмжээнд байлгаж, улс нийгмээ яаж хөгжүүлэхийг эцсийн эцст төр биш ард түмэн шийддэг.

Шийдэх боломжийг нь төрийн ардчилсан тогтолцоо олгож байдаг.

Улс орны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваварь, эдийн засаг, газар зүйн мужлалын сронхий схем нь зах зээлийн хүрээнд үйлдвэрлэл, худалдааны бие даасан тогтолцоо бий болгох, үндэсний суурь хорс нь болдог. Энэ хорс суурин дээр зах зээлийн хариулцааг хөгжүүлэхэд эдийн засгийн оновчтой дэд бүтэц шаардлагатай болно.

Өнөөдөр манайд макро эдийн засгийн түвшин зах зээлийн хариулцааны сронхий зарчмууд нилээд зүгшрэх чиглэлийг олсон боловч микро түвшинд бодит өөрчлөлт гаралаагүй байна. Энэ нь юуны өмнө манай засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваварь, эдийн засгийн мужлал, дэд бүтшийн хөгжлийн асуудал үндсэндээ төвлөрсөн төлөвлөлтийн үеийнхээрээ байгаатай холбоотой. Эдгээрийг зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд нийцүүлэн шинэчлэхгүйгээр микро эдийн засгийн түвшинд зах зээлийн хариулцааны бие даасан хувилбар олигтой зүгширч өөрийн гэсэн өнгө аясах олж чадахгүй. Үүний зэрэгцээ олон жилийн туршил төвлөрсөн төлөвлөгөөний хөшүүн сэтгэлгээнд дассан хүмүүст орчин үеийн эдийн засгийн ухааны боловсрол олгох, зах зээлийн нөхцөлж аж ахуйгаа эрхлэх дадал эзэмшигүүлэх, үр ашигтай ухаалаг бизнес эрхлэх арга ухаанд сургах зэрэг нийгмийн эдийн засгийн сэтгэлгээг шинэчлэх явдал нэн чухал.

Хүн амын нийгмийн хамгаалалтын асуудал зах зээлийн хариулцааны нөхцөлж хамгийн нарийн төвөгтэй бөгөөд эмзэг асуудал байдаг. Ямар ч улс орны нийгмийн хамгаалалт нь догоолдоод ирвэл нийгэм бүхэлдээ тогтвортгуйжиж хямралын үзэгэлүүд бий болж ирдэг. Энэ омч хөрөнгөтэй бүх талын эрх чөлөөтэй иргэдийн өөрсдийн хөдөлмөр зүтгэл, авхаалж овстоо маш чухал үүрэгтэй. Негээ талаар, нийгмийн хамгаалалт нь хүн амын "эмзэг", "өртөмтгий" давхраа гэж нэрлээд буй өзвөхн тэр хэсэгт хамаарах явцуу асуудал бини. Зах зээлийн нөхцөлж хүн бүр нийгмийн талаар хамгаалгасан байх учиртай. Энэ хамгаалалтыг иргэн хүн өөрөө өөрийн хүч хөдөлмөр, ажил үйлсээр бий болгох ёстой. Үүнд нь төр туслах үүрэгтэй. Төр нь иргэний нийгмийн эдийн засгийн тогтолцоогоор нөхцөлдсөн нийгмийн хамгааллын баталгаа бүрдэхэд Монголын онцлогтой уялдсан дараах гол хүчинн зүйлсийг шийдвэрлэх үүрэгтэй. Тухайлбал:

а/ нялхас балчир, өвгөл отгосоө нийтээр асран халамжилж, хүндлэн дээдлэх ариун ёсон, ядуу доодсоо энэрэн туслах нигүүлсэнгүй үзлийн монгол уламжлалыг нийтээрээ овлон шинэ агуулгаар сэргээх.

б/ "Хүн хүндээ нөхөр" байх хүмүүнлэг ёсны түгээмэл зарчим, нүүдэлгүй монголчуудын амьдралын өвермөц орчинг тусгасан монгол хүний мөс чанарт /яс чанар/ үлээмж гүнзгий шингэсэн байглийг ямагт анхаарч зах зээлийн далбаан дор хүний мөс чнарын хомдолла орчихгүй байх.

в/ Дорно дахины гүн ухаанаас сурвалжтай хүн өөрөө өөртөө бурхан, өөрөө өөрийнхөө хувь заяаны эзэн байх монголчуудын амьдрах соёлын тулгуур зарчмыг зах зээлийн харилцаны гол зарчмуудтай зохистой хослох зэрэг нь нийгмийн хамгаалалтын шинэ тогтолцооны бие даасан хувилбар бий болгох гол хүчин зүйл болно.

Дүгнэж хэлбэл, Монгол улс иргэний нийгмийн эдийн засгийн суурь болсон зах зээлийн тогтолцоонд шилжих бие даасан хувилбар нь териийн зохицуулалтын үүрэг ролийг тулхуу анхаарсан хувийн үйлдвэрлэл, чөлөөт худалдаа зохистой хөгжих боломжийг хангасан, хүн амынхаа нийгмийн хамгаалалтын баталгааг орчин үеийн соёлт нийгмийн хэмжээнд хургэхийг эрмэлзсэн улс орныхоо эдийн засгийн чадавхийг богино хугацаанд өөд татахад чиглэсэн онол, улс төрийн чиг шугамыг баримжаалсан байх ёстой. Монгол улсын зах зээлийн харилцааг нэгэн бие даасан тогтолцоо болгон авч үзвэл түүний тогтолцоо үүсгэгч гол хүчин зүйл нь териийн зохицуулалтын өвермөц маягийн уян хатан механизм байж болно.

Иргэний нийгмийн хөгжил нь оюуны амьдралын өвермөц дүр төрх төловшиг замаар хэрэгжинэ. Түүхэнд аль нэг ард түмэн туурга тусгаар бие даан оршин буй эсэхийн нэгэн гол баталгаа нь түүний хэл, соёлт ажгуу. Бие даасан хэл, соёлтой байна гэлэг нь тухай ара түмний эрдэм ухааны ертенц бусдаас ялгарах өөрийн гэсэн онгэ аяс, дүр төрхтэй байна гэсэн уг. Монголчууд түүхийн тулгуур сурвалжас тасарч, оюуны дэвшлийн явцад тасалдал бий болгоно. Үүнийг билд ойрмогхон түүхийнхээ гашуун туршлагаас сайн мэднэ. Үндэсний монгол бичгээ сэргээн хэрэглэх тухай төр засгийн шийдвэрийн үзэл санааг буруутгах үндэсгүй. Гагцуу хэрэгжүүлэх механизм, шаг хугацааны тухайд л бодох асуудал. Манай хүн амын бүхэл бүтэн нэг үеийнхэн, тэр тусмаа амьдрал хөдөлмөрийн хамгийн

ицэвхитэй үсийнхэн мань үндэснийхээ бичгээс тасарсан явдал нь ут бичгийг сэргээн хэрэглэх ажилд ихээхэн бэрхшээл учруулж байгаа нь тодорхой. Үүн дээр бас багшлах боловсон хүчин, хэвлэлийн материаллаг бааз, боловсролын тогтолцооноос сургалтын агуулга зэрэг олон хүчин зүйл нелөөлж байна. Энэ бүхэн нь нэг хэсэгтээ Монгол Улс хос бичигтэй байхаас өөр зргагүйг харуулж байгаа юм. Негээ талаар үндэсний монгол бичиг нь орчин цагийн шинжлэх ухаан, техникийн дэвшлийг тусган өөрөө байнга төгөлдөржин боловсронгуй болох учиртай. Эс тэгвээс монголын нийгмийн оюуны дэвшлийн суурь үндэс байх үүргээ хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд монгол бичгээ сурх талаар иргэдийн анхаарал ч ихээхэн сударч, төр засгийн зүгээс дэмжин зохион байгуулах ажил ч бараг алга боллоо. Ийм байдлыг цаашид үргэлжлүүлмээргүй байна.

Үндэсний уламжлалт эрдэм ухааны сан хөмрөгийт орчин үсийн шинжлэх ухаан, дэвшлийн ололтоор тэтгэн аввижуулах нь манай нийгмийн оюун санааны амьдрал өөрийн гэсэн хувилбараар хөгжихийн нэгэн гол хүчин зүйл болно. Монголчуудын оюуны сан хөмрөг бол хүн байгалийн хариулсан зохицох жам ёсны нууцыг тайлахад чиглэсэн Дорно дахинь олон сав ухааны нийлбэр цогц мон. Бүхнийг нэг үзэл суртлын хатуу "шүүрээр" оруулдаг нийгмийн тоталитари тогтолцооны уршигаар сүүлийн хэдэн арван жил оюуны энэхүү баялаг өвөөсөө нилээд хөндлийрсон ч бүрэн тасарсангүй. Өнеөдөр оюуны эрх чөлөө, үзэл бодлын плюрализмыг баталгаажуулсан арчилсан үйл явцын хүрээнээ Дорно дахинь олон сав эрдэм ухааны чиглэл бүр оноогийн амьдарлын онцлогийг тусган сэргээх ёстой.

Монгол улс иргэний нийгэмд хөгжиж хүрэх зам, үндэсний загварын үндсэн зарчмын Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг төрийн тулгуур баримт бичгүүдээд томъёологсон боловч түүнийг нарийвчлан боловсруулж, төрийн бодлогын түвшинд мөрдөж ажиллах шаардлагатай байгаа билээ.

МОНГОЛЫН ДУНДАТ ҮЕИЙН ХУУЛЬ  
ЦААЗУУД ДАХЬ "ЕС ТОРГОХ ЯЛ"-ЫН  
ТУХАЙД

© 1999 он. Бодбаятарын ГҮНБИЛЭГ<sup>1</sup>

Монголчуудын амьжиргааны гол хэрэгсэл мал байсан учраас хүнийг хийсэн хэргийнх нь толоо тодорхой тооны малааз торгож, баалан шийтгэж байсан нь иэн эртнийг бөгөөд бур Хүннү, Сүмбэ улсын үеийнх юм. Харин "ес торгох ял"-ын төрөл хэзээ бий болсныг мешгэн үзвэл, ХҮІ зууны эцэс үеэс өөрөөр хэлбэл, "Алтан ханы цааз", "Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг"-ийн үеэс бололтой. Тухайлбал, "Алтан ханы цааз"-ын бичигт: Хүн албаас гурав жанчиж, тэргүүн есөөр торгох, Муу уршигаар буюу муу санаагаар түймэр тавибас нэг хэсэг жанчиж есөөр торго<sup>2</sup>, "Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн бичиг"-ийн Мичин жилийн их цаазад /1620/: "Хан ахайн зүүн, баруун жигүүр' болж отоглосон хэдэн их бага ноёд отог сольж нутаглаваас 50 алуу, 5 тэмээ ав. Тавнан ... нар салж нутаглаваас гурван ес ав"<sup>3</sup> гэжээ.

Хууль цаазны дурсгалт бичигүүдээс үзэхэл есийн доторх малын төрлийг тухайн тухайн цагт янз янзаар тогтоож иржээ. Академич Ш.Бира ХҮІ зууны үеийн "Алтан ханы цааз"-ын бичигт хийсэн судалгааны бутээлдээ: уг хуулиар ес хэмээгти нь адuu хоёр, үхэр хоёр, хонь, ямаа нийлээд тав /бүгд ес/<sup>4</sup> гэжээ. Харин "Халх журам"-д нэг ес бол дөрвөн бол, таван хонь, нас нь цөм шүдлэн, олон ес бол заримын нь тав бол, /дөрвөн хонь, таван мал бол хоёр бол, гурван хонь, гурав бол нэг нь бол, хоёр нь хонь/ байна<sup>5</sup> гэж зассан байна. Манжийн ноёрхлын үеийн "Монгол цаазын бичиг" буюу "Гадаад Монголын хууль

<sup>1</sup> МУИС-ийн Хууль Зүйн Дээд Сургуулний И замжсаны окуутан.

<sup>2</sup> Ш.Бира. БИМАУ-ын түүх соёл, түүх бичгээгийн асуудал. УБ., 1977. 126, 127 дахь тал.

<sup>3</sup> Монгол ба Төв Азиийн оринуудын сослын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, УБ., 1974. 109 дахь тал.

<sup>4</sup> Ш.Бира. БИМАУ-ын түүх соёл, түүх бичгээгийн асуудал. УБ., 1977. 126 дахь тал.

<sup>5</sup> Халх журам. УБ., 1995. 19 дахь тал.

зүйлийн бичиг"-т: Ес торговол морь 2, шар 2, үнээ 2, хонь 2, бяруу 1 гаргуулах, долоон ес торговол морь 1, шар 1, үнээ 1, хонь 2, бяруу 2, таван ес торгогдвол үнээ 1, шар 1, хонь 1, бяруу 2, гурван ес торгогдвол үнээ 1, хонь 1, бяруу 1-ийг гаргуулах ёстой<sup>1</sup> гэжээ. Бас говь хангайн бүсээс шалтгаалан бодын бутшэл тэмээ орж байсан байна. Ес торгоход адuu, ухэр гол суурийг эзэлж, дараа нь тэмээ, хонь, ямаа орж байжээ.

Түүнчлэн ес торгохын естэй харьцах тоог дэс дараалсан болон сондгой хэлбэрээр тогтоож иржээ. "Алтан ханы цазын бичиг", "Цааз эрхэмжийн бичиг", "Монгол-Ойрадын хууль", "Халх журам"-л нэг ес, хоёр ес гэх мэтээр есөөр торгохоор тогтоосон бол, "Гадаад Монголын хууль зүйлийн бичиг"-т 9, 7, 5, 3 гэж сондгой тоогоор тогтоожээ. Харин есийн тооны хувьд Чингис хаан морь хулгайлж үгүй хийсэн нэгэн гэмт этгээдээр уг морийг нь ивхен төлүүлээд дээр нь есөн залуу мориор торгох зарлиг буулгаж байснаас үүдэлтэй байж болох юм. Нёгөө талаар Монголчууд эртийэс есийн тоог билэгдэх, баалахын аль алиинд нь онцлон сонгож ирсэн уламжлалтай холбоотой болов уу.

Монголын төр, эрх зүйн түүхийг судалсан эрдэмтэд, судлаачид "ес торгох" ялыг монголчуудын эрхэлж ирсэн аж ахуйтай холбоотой ялын бие дээсан төрөл хэмээн санал нэгтэй үзэж байгаа багаад харин уг ялын бүтшийн талаар харишсан адилгүй үзэл бодолтой байна. Нэг хэсэг судлаачид тухайлбал, доктор Д.Гонгор агсан "Халх товчоон хэмээх бүтээлдээ: Хамгийн олонтаа хэрэглэх ял нь малаар торгох багаад дээд хэмжээ нь есөн ее наян нэгэн мал юм"<sup>2</sup> гэж бичсэн байхад Монгол Ойрадын хуулийг судалсан дэд доктор Д.Дашижээн: "Ноёдын багш лам нарыг дайрч доромжилсон байвал таван ес буюу дөчин таван мал эр, гэлэн хүнийг дайрч доромжилсон бол гурван ес буюу хорин долоон толгой малаар торгож шийтгэж байсан"<sup>3</sup> гэжээ. Энд естэй харьцах тоог үргүүлж торгох малын тоог тогтоосон байна. Негөө хэсэг судлаачид тухайлбал, дэд доктор Б.Содонсүрэн: "Ес торгох хэмээх нь малын төрлийг илрэхийлсэн өрөнхий нэр гэж үзээл, гурван есөөр торгох гэдэг

<sup>1</sup>Б.Содонсүрэн. Хувьсталийн өмнөх Монголын төр ба хууль нааз. /1911-1920/ УБ., 1988, 22 дахь тал.

<sup>2</sup>Д.Гонгор. Халх товчоон. I дэвтэр. УБ., 1970. 310 дахь тал.

<sup>3</sup>Э.Анирмэл, Д.Дашижээн, Г.Сод. Монгол зууль. УБ., 1997. 64 дахь тал.

нь гурван мал, таван есөөр торгох гэдэг нь таван мал гэх мэтээр авна гэсэн уг<sup>1</sup> гэж үзжээ. Эдгэр судлаачдын саналыг түүхэн цаг үед нь буулгаж үзвэл аль нь зөв байна. "Монгол-Ойрадын хууль", бас "Халх журам" үйлчилж байсан эхний үе, өөрөөр хэлбэл, XVI-XVIII зууны хоёрдугаар хагас хүртэл ес торгох ял сонгодог утгаараа үйлчилж байсан бололтой. Өөрөөр хэлбэл, нэг ес-9 мал, гурван ес-27 мал, таван ес-45 мал гэх мэт. Учир нь энэ үед ес торгохоос гадна малын тоо толгойны хувьд хэдэн арав ба хэдэн зуун малаар юм уу, бас хэд гурван малаар торгож байсан ялын оор төрөл хууль цаазын бичгүүдэл тусгагджээ. "Халхын цааз эрхэмжийн бичиг"-ийн зургаан хошууны цаазад: ноёд чуулганд эс ирвээс хуяг, зуун тэмээ, мянган адуу ав, Төмөр тахай жилийн /1611 оны/ очүүхэн цаазад: их чуулгандын болзоонд гурван хоногт эс ирвээс зуун адуу, арван тэмээ авах болов. Мичин жилийн /1620 он/ их цаазад чуулган чуулахад хан хүн эс ирвээс зуун адуу, арван тэмээ ав, тавнан, сигэчин нар эс ирвээс тавин алуу, таван тэмээ ав<sup>2</sup> хэмээжээ. Мен усан үхэр жил /1613 онд/ тогтоосон цаазад: ноёд хураасан отгоо эндээс гучин адуу авах болов<sup>3</sup> гэсэн байна. Эндээс үзэхэд "Торийн хэрэг бага ч гэсэн их, гэрийн хэрэг том ч гэсэн бага" хэмээн торийн хэргийг нэн эрхэмд үзэж байсан нь тодорхой байна. Иймээс үүний өмнөхөн гарсан "Алтан ханы цаазын бичиг"-т: Заверлар нь шударга хүн орж алагдаас алагч хүнийг нэг хэсэг жанчиж есон есөөр торго, Нүд тэслэбээс нэг хэсэг жанчиж есон есөөр торго, Жанчилдаж хүний хүсэл эдлэж эс чадах болговоос нэг хэсэг жанчиж есон есөөр торго<sup>4</sup> гэх мэтээр заасан нь хүний амь насанд халдсан буюу эрүүл мэндэд нь онц ноцтой хохирол учиралсан гэмт хэрэгтнийг есхэн малаар торгоод өнгөрч байгаагүй нь мэдээж. Чуулган тасалсан хан ноёлыг хэдэн зуун малаар торгосон байхад дээр дурласан онц ноцтой гэмт хэрэгтнийг есон ес буюу 81 малаар торгож байсан нь үнэндэ илүү ойртох буй заа.

<sup>1</sup> Б.Содонцурэн. Хувьсталийн омноо. Монголын тэр ба хууль шах. /1911-1920/ УБ., 1988. 22 дахь тал

<sup>2</sup> Монгол ба Төв Азийн оринуудын соёлын түүхэнд холбоодох хөсрөөнөөр сурвалж бичиг. УБ., 1974. 109 дахь тал.

<sup>3</sup> Монгол ба Төв Азийн оринуудын соёлын түүхэнд холбоодох хөсрөөнөөр сурвалж бичиг. УБ., 1974. 109 дахь тал.

<sup>4</sup> Ш.Бири. БНМАУ-ын түүх соёл, түүх бичилгийн асуудал. УБ., 1977. 127 дахь тал.

Түүничлэн есөөс цөөн малазр торгох тохиоддлыг дундат үсийн хууль цаазын бичгүүдээ мориор торго, үхэрээр торго, дөрвөн бэрхээр торго, таван бэрхээр торго гэх мэтчилэн залжээ. Зарим жишээ дурдвал "Алтанханы цалзын бичиг"-т хулгайн гэмт хэрэгтэй холбогдуулан, "Тэмээний намрын үсэнд-морь, үхэр хоёрыг ав. Тэмээний тушаанд хоёр морь ав, Бурантагт нэг морь ав, чедэрт гурван морь, тушаанд хоёр морь, үхрийн тушаанд хоёр үхэр ав, дөрөнд нэг үхэр ав". "Халх журам"-д Ер элч айсүйг сонсоод мал буруулбаас тэр малын эзэн лүн бүрээс нэг нэг шүдлэн морь ав"<sup>1</sup>. Ноёд хүүхдээ хурийласан болоод өөр тавнан дор өгвөөс таван бэрх тэргүүтэй /Таван хошуу мал. Б.Г./ тавин таван анзуугаар торгоё<sup>2</sup> гэжээ. Эдгээр баримт ч есөөр доош малаар торгох торгуулийг шууд малын төрлөөр зааж байсныг илтгэнэ. Ингэж үржүүлэн өсгөж торгож байсанас болж, хари ара тодийгүй, ноёд язгууртнууд ч хоосорч байсан баримт түүхэнд тэмдэглэгэн үлджээ. Хэрэгт холбогдсон хүмүүсийн ихэнх нь ядуурал хоосролын улмаас "ес торгох ял"-ыг барагдуулж чадахгүйд хүрсэн тул ес торгох тэдэг нь ут ялын торлийн еронхий нэр болж, гурван ес гэвэл 3 мал, таван ес гэвэл 5 мал гэх мэтээр торгох болсон бололтой. Энэ утгаараа Б.Содовсүрэн аbugtayn өгсөн тайлбар түүхэн цаг үедээ зөв зүйтэй байна. Мон "ес торгох ял"-ыг өөр ялаар золих /солих/ болжээ. Жишээ нь: "Халх журам"-д: "Хари хүн хари хүний эмд орвоос тучин бэрх тэргүүтэй гурван зуун анзуугаар торго. Эс түвшвээс нэг бодол хорин таван ташуур, ташуурыг зуугаас давуулахгүйгээр<sup>3</sup> хэмээн мал өгч чадахгүй үед түүнийг ташуураах ялаар золисон байна. Гүчин бэрх гэж морь, тэмээ, хонь, ямаа тус бүрд бүгд нийлээд тун хорин бог, бод өгөхийг хэлж байгаа юм.

"Галдад Монголын төрийг засах лицэлийн яамны хууль зүйлийн бичиг"-т торгуулийн мал гаргуулах журмыг тогтооходоо: "Аливаа хэрэг халдаж торговол зохих малыг цомийг баруу жургаанд бичиг хүрсэн одроос эхлэн есон бүрт 30 одрийн хугацаа өгч дуусган тушаалга. Өөр өөрийн таван өдөр илүү хугацаан, хугацаа дуусаж тушаалгүй бол тайж түшмээд малын тоог бодохгүй ер тушаалгах нь тоонд хүрэхгүй болбол заруй жинсийг байлгаж, хугацаа сунгаж хөөн тушаалга. Гураваутгаар

<sup>1</sup> Халх журам. УБ., 1995. 13 дах тал.

<sup>2</sup> Халх журам. УБ., 1995. 27 дах тал.

<sup>3</sup> Халх журам. УБ., 1995. 26 дах тал.

удаа хугашаа сунгахгүйд хүрээл үнэхээр чинээгүй, дуусган тушаалгаж үл чадагчдыг тайжийн зэрэг байлгаж гурван жил эндэгдэлгүй бол зэрэг дахиул, хөөж тушаалгахыг хэлтүүл. Ялыг тайжын зэрэг байлгахад зогсоохтун. Түшмэл бол даруй түшмэл эвд. Харц хүн мал тушаахдаа тоо нь үл хүрэх бол 1, 2 бол хорин таван ташуур, 3, 4 бол тавин ташуур, 5, 6 бол далан ташуур, 7-оод бол нэмэж нэг сарын дөнгөө дөнтөлж зогсоохтун"<sup>1</sup> гэжээ. Ийнхүү Манжийн ноёрхолын сүүлийн жилүүдэд "ес торгох ял"-ын зарим хэсгийг тайж, түшмэлийн жинс, зэрэг эвдэх, ташуурдах, дөнтөлөх ялгар зольж байсан нь Монголын нийгмийн янз бүрийн бүлэг, давхрааны амьжиргааны түвшин, хөрөнгө бэл бэнчин бүхэлдээ доройтож байсантай холбоотой юм.

Олноо өргөгдсөн Монгол улсын үед эрх зүйн шинэлгээний хийхэд ес торгох ял нь ялны нэг төрөл хэвээр үлдээн байна. Тухайлбал, "Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-т: Аливаа идэр эр хамжлагын эрийт зоргоор худалдаах ба худалдан авах болбоос өөр өөрийн 5 есөн мал торго", "Аливаа харьят түшмэд жич, харц хүн зоргоор төмрийн ирт юмыг барьж хүнийг хор хийснийг болох угий түшмэл болбоос түшмэл эвдэж, хоёр есөн мал торгож албандаа хадгалуул"<sup>2</sup> гэх мэтээр заажээ. Энэ үеийн хууль тогтоомжид "ес торгох ял"-ыг бусад ялны төрөлтэй хослуулан хэрэглэх нь омнох үесээ элбэгшсэн үзэгдэнэ.

Малын хулгай ёсож буй өнөөгийн нохцолд "ес торгох ял"-аас санзаа авч, хөдөөгийн нехшэлд мөнгөн торгуулийг малаар зольж болох юм. Энэ асуулдлыг зохих газрууд нарийн боловсруулж, эрүүтийн болон захиргааны хариуцлагын хууль тогтоомжид тусгах нь чухал бөлгөө.

<sup>1</sup> Б.Содолсүрэн. Хувьсталийн омноо Монголын төр ба хууль 1911-1920/УБ., 1988, 22-23 дахь тал

<sup>2</sup> Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. УБ., 1995, 56, 191 дахь тал.

## "ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЭД ХӨРӨНГИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ" СЭДЭВТ МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН БҮТЭЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улирсан: Хууль зүйн ухааны доктор /Ph/, профессор  
Т.МОНХЖАРГАЛ

Шүүмж бичсэн: Хууль зүйн ухааны доктор /Ph/, профессор  
Д.ЛҮҮНДЭЭЖАНЦАН

Гүйцэтгэсэн: ШУА-ийн Философи, социологи, эрхийн  
хүрээлэнгийн ажилтан, хууль зүйн ухааны магистр  
С.ЭНХЦЭНЭГ

Монгол оронд өрнөсөн нийгэм эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээн дэх шинэчлэл нь нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарч зохицуулахад чиглэгдсэн хууль тогтоомжуудыг шинэ үзэл баримтлал бүхий Үндсэн хуулинааз нийшүүлж батлах, өөрчилэн шинэчлэхийг зайлшигүй шаардсан байна.

Урьд Үндсэн хуулиудал өмчийн төрөл хэлбэрийг тодорхойлоходоо бүтгийт багтааж тоочин иэрлэдэг байсан уламжлалаас татгалзаж өрдөө л "хувийн" ба "нийтийн" гэсэн хоёр үндсэн томъёоллыг хэрэглэсэн нь ихээхэн өргөн гүн утга санааг илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл, нэг хүн ганцлараа эзэмшихээс эхлээд нийлж хэсэгт бүлгээрээ, бүр нийгэм хотлоороо хүртэл эзэгнэх өмчийн бүх төрөл хэлбэрийг эн ойлголтод хамааруулан ойлгож болно. Энэ нь өмчийн харилцаа өмчлөх эрхийт өргөн, чөлөөтэй болгосон эрх зүйн зохицуулалтын бас нэг хэлбэр юм.

Монгол улсын үндсэн хууль өмчийн эсэх өмнөө хэрхэн эзэмших, ашиглах, захиран зарцуулах тухай зарчмын асуудлыг зохицуулахдаа өмчлөх эрх нь хүний эрхийн нэгэн гол төрөл, хэлбэр юм гэсэн олон улсын нийтлэг жишгийг иш үндэс болгосон юм.

Үүнтэй холбоотойгоор хүмүүсийн хувийн өмчийн эрх бүх талаар ишгэдэж, эд хөрөнгө, капитал хуримтлуулах явдал өргөжиж байгаа онөө үед гэр бүлийн хуулдиг бүхэлд нь, ялангуяа гэр бүлийн гишүүдийн өмчийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагага урган гарч байна. Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж болж байдал. Энэ утгаараа гэр бүлийн

хөгжлийн асуудлыг төрийн бодлогоор зохицуулах ёстой болдог. Гэр бүл нь хүний аж төрөх, амьдралын хамгийн анхдагч бичил орчин учраас хүний бие бялдар, оюун сансаны хөгжил энэ орон зайнлас эхлэлтэй.

Иймээс гэр бүлийн эрх зүй нь нийгмийн олон талт амьдралаа эрх зүйн зохицуулалтын хамгийн бүтээлч, гол үүргийг гүйцэтгэх хариушаа юм. Өдгөө үед хүний оюун сансаа, эдийн засгийн байр суурийг төлөвшиүүлэх анхдагч нийгмийн хариушаа болох гэр бүлийн эрх зүй дэх "Гэр бүлийн гишүүдийн өмчийн эрх зүйн зохицуулалт"-ын асуудалдаа шинэлэг байрь суурьнаас хандаж, онол практикийн талаас нч судлаж боловсруулан практикт извтрүүлэх шааралыга гарч байна. Эдүгээ гэр бүлийн асуудлыг олон улс анхааралдаа авч тэрийн зохицуулалтын үндэс болгож байгаа нь сайшалтай юм.

Гэр бүлийн өмчийн хариушаа нь гэр бүлийн гишүүдийн хооронд үссэн нийгмийн харищаагаар тодорхойлогдож буй түүний нэг төрөл юм. Нэгэн үеийн амьдралын дадал туршилага ногоо үедээ замжуулах арга хэлбэр нь уламжлал, зан заншил, түүнийг орчин үеийн нохцолд тохируулсан өөрчлөн хөгжүүлэх нь шинэчлэл юм.

Гагшүү уламжлал, зан заншил дээр тулгуурлан аливаа шинэчлэлийг хийх нь хөгжлийн эх үндэс буюу "Гэр бүл" тэгч нийгмийн "эс" нь аль ч нийгэмл оршин тогтнож ирсний хувьд гэр бүлийн эрх зүйн, ялангуяа гэр бүлийн өмчийн эрх зүйн зохицуулалт монголчуудын торт ёсны түүхэн хөгжлийн турш хэрхэн хөгжиж байсныг товч авч үзэх нь зүйтэй болов уу. Чингисийн "Их засаг" бол Монголын хууль шазын дотор хувийн өмчийг хамгаалах талар гарсан зихны баримт гэж үзэж болно. Энэ хуудийн өмч хоронго, өмч залгамжлах тухай шааз бүлэгт "Их түшмээ, ноёд буюу ард иргэд үхсэн хойно түүний эд хөрөнгө хэдий байсан ч хонллонгөөс ингэ гэж үл болох... Ухэгээл залгамжлах үр хөвгүүн угүй болбоос эд хөрөнгийг нь түүний шавь буюу зарцаа нь огч болохоос биш улсын санд оруулж огт болохгүй" гэж заажээ.

Үг хуулиар "Өрхийн тэргүүн наас барсны дараа ууган хүүд бусдаас илүү хувсаарилах зарчмаар өмчийг хувьсан. Оттон хүүд гэр, мал сүргийг оролцуулан гал голомтыг огох тухай заасан байна."

Мөн хуулийн 24-р зүйлд "Татвар /хууль бус эхнэр/

эмээс гарсан хүүхдүүд хууль ёсоор гарсан хүүхдийн ашиг эрхтэй."<sup>1</sup>

1640 оны "Монгол-Ойрадын хууль шазын бичиг"-т гэр булийн өмч нь "хамтын өмч" бөгөөд эмэгтэй хүний хэрэглэх зүү, утас, товч, шилбэ, хайч, шөвөг хуруувч зэрэг олон зүйлийг нэр зааж, хэн ч үл хөндөж болох бөгөөд энэ нь эмэгтэйн хувийн өмч байжээ.<sup>2</sup>

"Хадх журам" хуулийн 81-р зүйлд "Тавнан авайг / эхнэрээ/ гээвээс /хаях/ ташуурас барьж гарах /гэрээсээ мал авалгүй ганцаараа тонилох/ авай инжээ авч хошуундаа биээ мэдэх, тавнангийн талсан /авсан/ эд малыг хувааж хагасыг нь засагтаа авах, хагасыг нь авайд өгөх". 82-р зүйлд "Авай дээр эм авбаас эмийг нь хагацуулья, тавнант золиогүй /ташуурдах шийтгэлийг малаар сольж болохгүй/ ная ташуурдья. Авай инж болоод сүрэг мал, гэрээ аван хошуун лотроо биээ мэдтүгэй")

Ийнхүү эрт монголчууд эрт дээр үзэс өмчлих эрхийг зохих хэмжээнд хүлээн зөвшөөрч, түүнийг эрх зүйн актаар баталгаажуулж байсан ба эмэгтэйчүүд хүүхдүүд өмчлих эрхийн хувьд гэр булийн тэгш эрхт гишүүн байсныг харуулж байна.

Негеетэйгүүр гэр булийн тогтвортой бат бэх байдлыг илүүд үзэж, гэр бүл бусниулагч эмс, ноёдыг шийтгэх эрх зүйн хатуу залт үйлчилж байсныг "Хадх журам" хуулиас үзэж болно.

Тиймээс өрх гэр бий болсон үзэс түүний оршин тогтох, хөгжих зүй тогтол нь эзэстээ өмчтэй холбогдох, өмчийн харилцаанд зайлшгүй хамрагдах болдог.

Гэр бүлийн өмч гэдэг нь эд хөрөнгийг гэр бүлийн гишүүд оорийн болгох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хуваарилах явшид үүссэн эдийн засгийн харилцаа юм. Гэр бүлийн өмчийн эрх бол тэрхүү өмчийн эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын хэлбэр болно.

Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцааг

1.Энэг эх, хүүхдүүдийн эд хөрөнгөтэй холбоотой харилцаа,

2.Мөн тэдний хооронд бис биээ тэжээн тэтгэхтэй холбоотой харилцаа гэж хоёр төрөлд хувцас авч үзлэг.

<sup>1</sup> "Этийн Чингис-Их Засаг" ном МУИС-ХЭДС УБ., 1995. 45 дахь тал

<sup>2</sup> С.Бадарын "Эмэгтэйчүүд, хүүхдээ хамгаалж ирснэ Монголын хууль цэсийн эрзиний узлийн жалал". УБ., 1995.15 дахь тал

<sup>3</sup> С.Жалан-Алжан. Хадх журам. УБ., 1995. 26 дахь тал.

Энд эхний хэсэг буюу эд хөрөнгөтэй холбоотой харилцааг авч үзэж байгаа учир уг харилцааны онцлог шинжийг тодорхойлж бол:

1. Гэрэлт, гэр бүл гэлэг ойлголтын мөн чанартай уялдан уг харилцаанд оролцогч субъект нь зөвхөн гэр бүлийн гишүүл байна.
2. Уг харилцаанд оролцогч субъектүүд нь бие биенээ хайрлах хайр сэтгэл, итгэлийл, ураг төрлийн холбоотой евормоц харилцатай байдаг учир зарим эд хөрөнгийн хувь хариу төлбөргүй байдгаараас бусад салбар эрх зүйн эд хөрөнгийн харилцаанаас ялгаатай.
3. Гэр бүлийн эд хөрөнгийн харилцаа нь эд хөрөнгийн бус амины шинжтэй харилцаан дээр үндэслэж үүсдэг. Фороор хэлбэл, эд хөрөнгийн бус амины харилцаа субъектүүдийн хооронд үүссэгүй бол эд хөрөнгийн харилцаа тэдгээрийн хооронд үүссэхгүй.
4. Эд хөрөнгийн үүргээ хэн нэг нь билүүлэсэгүй тохиолдолд хариушлагын асуудал эрүүтийн эрх зүйн "ял" бусад эрх зүйн хариушлагас ялгаатай байдаг.
5. Энэ харилцаанд ёс суртахуун, заншлын хэм хэмжээ бусад салбар эрх зүйг бодвол илүү үйлчлэх хандлагатай байдаг.
6. Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны зохицуулалт нь гэрээ болон эрх зүйн хэм хэмжээ аль аль нь байж болно.

Одоогийн Иргэний хуулийн 97-р зүйлд зааснаар гэрлэгсдийн эд хөрөнгийг а/ дундын, б/ хуваарыт гэж хоёр төрөлд ангилж байна. Дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн нэг хэлбэр нь гэр бүлийн эд хөрөнгө байна. /Иргэний хуулийн 94-р зүйл/. Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн ангилах нь орх гөрийн үйлдвэрлэл, аж ахуйг эрхлэн хотлох нохцолийг бий болгох, гэрлэгсдийн эд хөрөнгийн эрхийг хамгзалах, хожим үүссэж болзошгүй эрх зүйн зорилгоос урьдчилан сэргийлэх аж холбогдолтой юм. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөд дараах эд хөрөнгө хамзарч байна.

1. Гэрлэснээс хойш гэрлэгчиц, гэр бүлийн бусад гишүүний хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас буй болсон эд

хөрөнгө, мөнгөн хурийтлал,

- Гэр бүлийн гишүүн өөрийн хувьарыт эд хөрөнгөнөөс дундаж хамтран ёмчлехэд зориулж шилжүүлсэн эд хөрөнгө, мөнгөн хурийтлал,
- Гэр бүлийн гишүүдийн хамтын хөдөлмөрийн үр дүнд олсон ашиг, орлого, үр төл, шинээр бий болсон эд хөрөнгө,
- Гэрлэгсдийн хувьарыт эд хөрөнгийг гэр бүлийн гишүүн чанаржуулсаны үнэ нь үзэмж нэмэгдсэн бол дундаж хамтран ёмчлех эд хөрөнгө болгон тогтоож болно.

Гэрлэгчдээс дундын ёмчлэлд шилжүүлэхээр тохиролцоогүй бол дараах эд хөрөнгө хувьарыт эд хөрөнгөд хамаарна.

- Гэрлэгчдээс гэрлэхийн ёмно олж авсан эд хөрөнгө, мөнгөн хурийтлал, эд хөрөнгийн эрх,
- Гэрлэгчид өв залгамжлал, бэлэглэлийн журмын шилжүүлэн авсан мөнгөн хурийтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэлгээрийг худалдаж, арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө,
- Гэрлэгчийн хувийн хэрэгцээг хангахад зориулагласан эд хөрөнгө, мөнгө,
- Оюуны ёмчлелийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал,
- Хувийн авьяас, чадвар, ололт амжилтыг сайшсан шагнаасны орлого,
- Гэрлэгчид хувьарыт эд хөрөнгөөрөө олж авсан бэгээд тэдгээрээс мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагдах эд хөрөнгө.

Энэхүү дундын эд хөрөнгийг бусад улс орнуудад хэрхэн ангилдагчийг авч үзэх нь сонирхолтой юм. Тухайлбал Германы иргэний хуулийн 1363-р зүйлийн I-д "Гэрлэгчдээс ёмнихи хөрөнгө нь тухайн хүний өөрийн хувьарыт омч бөгөөд харин гэрлэсний дараа олж авсан хөрөнгө нь гэрлэлтийн гэрээнд өөроор заагаагүй бол хамтран ёмчлех дундын омч байна"<sup>1</sup> гэж залжээ.

ОХУ-ын Гэр бүлийн хуулийн 39-р зүйли "Гэрлэлт цушлах тохиолдолд тэнийн өр эд хөрөнгө хувласан процентоор хуваагдана." Үүнээс үзэхэд дундын хөрөнгө нь нийт дунгээрээ хасах дүнтэй гарч болох талтай. Тиймээс гэрлэлтийн гэрээг

<sup>1</sup> В.В. Залесский, Германское право. М., 1996. стр. 282.

хатуу заалттай байгуулбал өрийн асуудлыг зохицуулж болно. Дэлхийн улс орнуудын жишгээс үзвэл гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг хуулиар зохицуулааг журмаас хамаарч гэр бүлийн эд хөрөнгийг сронхийл нь З антилж үзэг байна.<sup>1</sup>

/Хавсралт №1/

I бүрэг Гадаадын /дуудлын/ эд хөрөнгийн байн	II бүрэг Гадаадын салбартын /туудын/ эд хөрөнгийн байн	III бүрэг Хөдлийн /иңдээдийн/ ба салбартын эд хөрөнгийн хөдлийн
<p>Франц -Испания -Латин Америк -АНУ-ын 8 муж /Техн., Бумажны, Калифорни, Альбама, Нью-Мексико, Невада, Аризона/</p>	<p>Англи -Америкийн 47 муж -Шинэ Зеланд -Мусульман шашиний орон</p>	<p>-Герман -Скандинавийн орнууд -Кохта Риза -Швейц -Италии -Дами гүн зог</p>
<p>Энэ систем Швейцарын шүүчин ролдай Хувьцас энэ ба дундын энэ байна Хувьцас энэ Он цагааны бодлогодор энэ хөрөнгийн байна</p> <p>Дундын энэ Гарданын байраалсан бүрдүүлэх орлогийн байна Нийтийн худалдаан хөрөнгийн байна Хувьцас хөрөнгийн байна Хувьцас хөрөнгийн байна</p>	<p>Гадаадын энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн байна. Гадаадын энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна. Мөн энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна. Гадаадын энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна.</p> <p>Энэгээг энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна. Гадаадын энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна. Гадаадын энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна.</p>	<p>Энэгээг энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна. Гадаадын энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна. Гадаадын энэгээг энэхүү хөрөнгийн хөдлийн эд хөрөнгийн төслийнгүй байна.</p>

Манай улсад гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийг дараах байдлаар антилж болохоор байна:

Дундын эд хөрөнгөд 1/ Тэтгэвэр тэтгэмж, 2/ Гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийн орлогоор олж авсан хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, 3/ Банк, бусад аж ахуйн байгууллагал хувь болгон оруулсан ноогдол ашиг, үнэт цас, 4/ ихэх болон эхнэр, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагас үл шалтгаалан гэрлэснээс хойш буй болсон бусад хөрөнгө, 5/ Оюуны өмчлөлийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал, 6/ Анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашлаа, байшин/ бол хамтран өмчлөх дундын эд хөрөнгө

<sup>1</sup> В.П.Мозолина, М.И.Кулагина, Гражданское и торговое право капиталистических стран. М., 1980, стр 351.

болгон тогтоох нь зүйтэй байна. Харин одоогийн Иргэний хуульд зассан "тэрлэгсдийн хуваларьт эд хөрөнгө" гэсэн ойнголтыг "тэр бүлийн гишүүдийн" гэж субъектийн хүрээг өргөтгөх нь зөв юм.

Гэр бүлийн гишүүдийн өмчөө хэрхэн захиран зарцуулах асуудал бол эрх зүйн тодорхой үр дагаваруудыг төрүүлдэг үзэгдэл юм. Тодруулбал, гэр бүлийн гишүүд өмчөө хэрхэн зөв захиран зарцуулахаас тэдний ёс суртахуун, эдийн засаг, эрх зүйн хүмүүжлийн төлөвшилт нөлөөлөөд зогсохгүй үүнийг зөв зохицуулсанаар гэр бүлийн хүрээнд хойшид гарч болох гэр бүлийн гишүүдийн эрх зөрчигдхөхөөс хамгаалж урьдчилан сэргийлж болох талтай.

Орчин үеийн гэр бүл эд хөрөнгөө зөв "хэмнэлттэй" захиран зарцуулах талаар залуу гэр бүл их анхаарал тавыж энэ асуудлаа эрх зүйн актын хэлбэртэй хууль, гэрээ, өрхийн төсөв зэргээр зохицуулах хандлагатай болж байна. Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилшааг зохицуулах асуудлыг бусад улс оронд ялангуяа эх газрын болон далайн эрх зүйн тоотолцоотой улсуудын жишигтэй харыцуулан авч үзвэл, Оросын Иргэний хуулийн 253-р зүйлд "Гэр бүлийн гишүүд эд хөрөнгөө зээмших, ашиглах, захиран зарцуулахдаа харилцан зөвшөөрөлцсөн байх ёстой. Хэрэв зөвшөөрөл аваагүй тохиолдолд уг харилцаанд оролцоогүй гуравдагч этгээд гомдоо 1 жилийн дотор шүүхэд гаргах эрхтэй. Энэ зөвшөөрөл иотарнатын баталгаа байна."<sup>1</sup> Германы Иргэний хуулийн 1365-р зүйл "Эхнэр, нөхрийн аль аль нь өөрсдийн эд хөрөнгийг зарцуулах эрхийг нөгөөгийнхөө зөвшөөрөлтэйгөөр хэрэгжүүлнэ. Хэрэв энэ талаар гэрээ хийх бол зөвшөөрлийг заавал авахыг шаардана." 1369-р зүйлд "Гэр бүлийн гишүүд гэрийн эд хогшилоо захиран зарцуулахдаа гэр бүлийн бусад гишүүний зөвшөөрлийг заавал авна." 1408-р зүйл "Гэрлэгсэл эд хөрөнгөө захиран зарцуулах журмын талаар гэрээ байгуулна." 1447-р зүйлд "Дундын эд хөрөнгө захиран зарцуулж байгас нөхөр /эхнэр/-ийнхөө үйл ажиллагааг зогсоох талаар доорх тохиолдолд нөгөө тал нь шүүхэд өргөдөл гаргах эрхтэй:

1.Хөрөнгө захиран зарцуулах чадваргүй, дундын хөрөнгөө буруугаар ашиглаж байгас нь цаашдын амьдралц гарз хохирол учруулах бол,

<sup>1</sup> М.В.Антокольская. Семейное право. М., 1996. стр 157.

2.Гэр бүлийн бусад гишүүнээ тэжээн тэтгэх үүргэс биелүүлэхгүй байгаа бол,

3.Гэр бүлдээ асар их гарз хохирол учруулахийн ортэй болсон үед.

4.Эд хөрөнгөө захирсан зарцуулах эрх нь оор хүний мэлээд орсон тохиолдолд.<sup>1</sup>

Манай улсын хувьд шинэлэг бөгөөд Иргэний болон Гэр бүлийн хуульд бие даан тусгагдаагүй үүргийн тусгай төрөл бол "Гэрлэлтийн гэрээ" юм. Энэ гэрээний эрх зүйн зохицуулалтын түвшин онцлог байдаг орнууд нь АНУ, Франц, Герман, Испани гэх мэт орнууд. Эдгээг орнуудад гэрлэгдсийн омчиний эрх зүйн хамгаалалт амжилттай хөгжих байна.

Мөн ийм жишигт манай хууль тогтоомжид урын байсаныг дурдах нь зүйтэй. 1926 оны анхны Иргэний хууль "Эр эм хоёр аливаа хогшлын тухай завсар дор хууль ёсны гэрээ хэлэлциэр байгуулж болно" гэсэн заалт байсан бөгөөд харин амьдралд тэр бүр байгуулж байсангүй.

- Зах зээлийн эдийн засагт шилжсэн онюү үед гэр бүлийн хүрээнд асар их монго, хоронгө хуримтлагдан аж ахуйн нэгж байгуулах гэх мэт гэр бүлийн эд хоронгийн харилцаа улам бүр өргөжиж байгаатай уялан "Гэрлэлтийн гэрээ"-г заавал байгуулах чиглэл руу орох нь зүйтэй гэж үзэж байна. Гэхдээ энэ нь гэр бүлийн эд хоронгийн бус амины харилцаа биш зөвхөн эд хоронгийн харилцааг зохицуулах гэрээ байх ёстой. Тодруулбал, энэ гэрээг "Гэр бүлийн гишүүдийн өмчлөх эрхийн гэрээ" гэж нэрлэх нь зүйтэй болов уу.
- Одоо даган мөрдөж байгаа Иргэний хуульд гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан овчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр нохөр, гэр бүлийн бусад гишүүн эд хоронгөө хамтран өмчлөх эрх эзлэхээргүй утгатай заалт байгаа юм. Иймээс гэр ахуйн ажил болон хүүхэд асрах гэх мэт маш хүнд ажлыг үнэлгээтэй болгох нь зүйтэй юм.
- Гэр бүлийн эд хоронгийн харилцааг зохицуулсан хуулинд гэр бүлийн эд хоронгийн харилцааны

<sup>1</sup> В.В.Залесский. Германское право. 1996, стр 282.

субъектүүдийг тодруулах нь зүйтэй юм. Өөроор хэлбэл, нэг заалтад "тэрлэгчид" гэж оруудсан атлаа негеэв заалтад "тэр бүлийн гишүүд" гэж заасан байна. Хуулинд "тэрлэгчдийн хувваарыт өмч" гэж байгаа атлаа хүүхэд хувваарыт өмчтэй байна гэж заасан нь зөрчилтэй байгаа юм.

УДШ-д дундын эд хөрөнгө хувваарилах талаар сүүлийн 3 жилийн 30 хэрэг хянагдсан бөгөөд 1995 онд 12 хянагдсанын 10 хэргийн, 1996 онд 14 хянагдсанын 13 хэргийн, 1997 онд 6 хэрэг хянагдсанын 6 бүх хэргийн шийдвэр, магадлал хүчингүй болж өөрчлөгдсөн байна. Энэ байдлаас үзэхэд гэр бүлийн дундын өмчлийн маргаантай хэрэг харьцаангуй бага хянагдлаг боловч хянагдсан хэргийн шийдвэр, магадлал хүчингүй болж өөрчлөгдэх явдал 83.3-аас дээш хувийт эзлэж байгаа нь энэ төрлийн маргаантай хэргийт шийдвэрлэх талаар нэгдсэн ойлголт тогтоогүйтгэй холбоотой байна.<sup>1</sup>

Гэр бүлийн дундын өмчийн маргаантай хэргийн 80 хувийт гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмшиж байсан орон сууцны эзэмшилээс үүссэн маргаантай хэрэг эзэлж байна. Гэр бүлийн дундын өмчийн маргаантай хэргийн шийдвэр, магадлал хүчингүй болж, өөрчлөгдэж байгаа шалтгазныг судлаж үзвэл,

1. Гэр бүлийн гишүүд дундаа хамтран өмчлох эд хөрөнгийг бүрдүүлэхэд тэдний оруулсан хөдөлмөрийг харгалзаж нотлох баримтлаар тогтоогоогүй, дундын өмчийн эд хөрөнгийг хувваарилахдаа Иргэний хуульд заасан өв залгамжлах эрхийг нь хязгаарлах, Иргэний хуулийн 97-р зүйлд заасан гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлох дундын өмчийг толорхойлсон заалт болон түүний талаар маргаан гарвал аль нэгний эрх ашигийг харгалзаж, гэрлэгдэл оногдох хувийт шүүх өөрөөр тогтоож болно гэсэн заалтыг анхааралгүй хэргийт үндэслэлгүй шийлвэрлэх,

2. Иргэний хуульд заасан гэр бүлийн гишүүнд ямар субъектүүд орохыг анхаараагүй, Иргэний хуулийн 251-р зүйлд заасан орон сууц хөлслөгчтэй хамт амьдардаг гэр бүлийн гишүүд нь хууль буюу гэрээнд олгогдсон хөлслөгчийн бүх эрхийг эдлэж үүрэг хүлээнэ гэсэн заалтыг зөрчсөн,

3. Дундын өмчийн эд хөрөнгийг хувваарилахад баримтлах хуулийн заалт өнөөгийн шаардлагад нийцэхгүй байгаагаас

<sup>1</sup> Монгол Улсын дээз Шүүхийн мэдээлэлийн сэргүүлэлт. 1998. №4. 60 дахь тал.

шүүхүүд энэ төрлийн маргаантай хэргийг харилсан адилгүй шийдвэрлэх, гэрлэгслийн хамтран өмчлөх дундын өмчийн хэмжээг нотлох баримтыг үндэслэн тогтоохгүйгээр хэрэг шийдвэрлэх, маргаж буй эд хөрөнгө нь дундын эсхүл хуваарьт эд хөрөнгө болохыг нотлох баримтаар тогтоогоогүй зорг болно.

Ийнхүү гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилсааг боловсронгуй болгох талаар доорх асуудалаа анхаарлаа хандуулах нь онол болоод практикийн ач холбогдолтой юм.

- Хуулинд "Анх гэр бүл болоход нь зориулагдсан орон сууц, гэр хашаа байшин нь гэр бүлийн гишүүдийн хэвийн амьзарах салишгүй нохшол нь болж байгаа тохиолдлыг дундын өмчид тооцож болно" гэсэн заалт оруулах,
- Гэр бүлийн гишүүдийн өмчөө захиран зарцуулах явнал үүссэн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, /Өөрөөр хэлбэл, гэр бүл цуцалсаны дараа эд хөрөнгийн талаар маргах бус хамт амьдрах хугацаанд гэр бүл дэх эдийн засгийн аливаа нэг хүчинхийгийн эсрэг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхийт нээлттэй болгох,
- "Сайн дурын үндсэн дээр гэрлэх тухай болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай" конвенцид зааснаар бүх гэрлэлтийг албан ёсоор бүртгэх, бүртгэлгүй гэр бүлээс төрсөн хүүхэд бүртгэлтэй гэр бүлээс төрсөн хүүхдийн адил эрх эдлэж байхадар, мөн гэрлэлтийн хууль ёсоор батлуулаагүй ч 3 буюу түүнээс дээш жил хамтран амьдарсан, дундаасаа хүүхэдтэй болсон нь тогтоогдвол тэдний эд хөрөнгийг хувширилахдаа баталгаатай гэр бүлийн адил авч үзэх хэрэгтэй гэж үзэж байна.
- Гэр бүлийн эд хөрөнгийн харилцаанаас үүссэн хэрэг, маргааныг шийдвэрлэх шүүхийн эжиллагаа удаашрах, хуулийн хугацаа алдаа, иргэл хохирох явдал их байна. Иймд "Гэр бүлийн гишүүдийн өмчлөх эрхийн гэрээ"-г заавал байгуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Гэрлэлт цуцлахад гэр бүлийн аль нэгэн гишүүнд учирсан оюун санааны болон материалын хохирлыг нохон төлүүлэхээр шүүх тогтоож болох заалтыг хуулинд тусгах,
- Өрхийн тэргүүлэгч гэрийн эзэгтэй нарын эрх үүргийг хуулинд тусгах, гэр бүлийн дотор гарч буй гол зорчил бол "Би чамайг тэжээж байна", "Би чиний үр хүүхдийг осгож

зовж байна" гэдэг. Амьарадл нөхөр нь эхнэрээрээ зээ тэжээлгээд, эхнэр нь тэрээ авч явах, үр хүүхдээ есacen хүмүүжүүлэх гэх мэт давхар ачаалал чүрч байдаг. Энэ нь тэдний үүрэг эсхүл бие биснийхээ өмнө оногдуулах хариушлагага гэдгийг зааглаж нэгэнт үүрэг бол түүнийг хууль зүйн болоод "журамт үүрэг" гэж хуулинд оруулах саналтай байна.

- Өдгөө дэлхийн улс орнуудад арчилсан, чөлөөт нийгэм ноёрхж гэрлэлтийн болон гэр бүлийн эд хөрөнгийн харишатай холбоотой янз бүрийн хэлбэрүүд бий болж байна. Тухайлбал, Гейчүүд, Лесьбиянкуудын гэрлэлтийг хуулиар албан ёсоор зөвшөөрсон улс орнууд /Африкийн болон Скандинавын орнууд/ ч байна. Мөн тэрээт гэрлэлтийн зохицуулалт болон биотехнологийн аргаар гуравдагч этгээдэл үр суулгах, түүнтэй холбоотой эд хөрөнгийн харишашан асуудал гэх мэт. Зарим хүмүүс манай улсал гей, лесьбиянкуудын гэрлэлтийг албан ёсоор хуулиар зөвшөөрөх нь зүйтэй, энэ бол гаж зүйл бус хүний эрх гэж үзэж байгаа боловч энэ нь байгалиас заявсан "гэрлэлт" гэсэн ойлголтын агуулгыг зөрчдөг учраас одоогоор манай улс энэ харишаг хүлээн зөвшөөрч хуулиар зохицуулах боломжгүй юм тэж үзэж байна. Негеетэйгүүр гуравдагч этгээдэл үр суулгах нь гэр бүлд тодорхой хэмжээний эд хөрөнгөтэй холбоотой харишаг бий болгодог боловч энэхүү гуравдагч этгээд нь гэр бүлийн эрх зүйн субъектийн мөн чанарыг аль ч талараа агуулдагтүй учраас үүнийг гэр бүлийн хуулиар зохицуулах боломжгүй юм.

## ПИТЕРИЙН ЗАРЧИМ\*

*Аль ч шатлан захирагч ёсонд хувь хүн бүр  
өөрийнхөн мэдлэг чадвар дутах түвшинд  
хуртлээ дэвших хандлагатай байдал*

Яагаад ажил хэрэг буруу ташаа сольж бүтэлгүйтдэг вэ?

Намайг нэг тээнэгэлзэл зовоож байна.

Ер нь дэлхийт хэн удираад байгаа юм бэ? Нэг бол мэдлэг, чадваргүй боловч үнэнч хүмүүс үү, аль эсвэл бицний толгойг эргүүлээд байгаа ухаантай залуус уу гэдгийн учрыг би олохгүй байгаа юм. Та бүхэн дараах жишээнүүдэл чухам ямар логик алдаа байгааг болон тэдгээрийг ямархуу мэдлэг, чадвартай хүмүүс хийснийг ажиглаад миний санааг чухам юу зовоож байгааг ойлгох болно.

Би Британийн Колумбийн Их Сургуулийн профессор байхдаа нэгэн санамж бичгийг хүлээн авлаа. Гэтэл тэнд "Өөрийн хувийн нарийн бичгийн даргагүй профессорууд нарийн бичгийн дарга нарын нэгдсэн бүлгээс охицуудыг ашиглаж болно" гэж бичсэн байв.

Түүнчлэн Вискинсон мужийн Стоутон хотод гардаг "Курьер" гэдэг сонинд "Фортон-стритэд онгөрсөн намар нурж унасан гүүрийт сэргээн засварлаж дууслаа. Тэнд төмөр бүслүүртэй тулгуур багануудыг дахин сольж тавьсан багоод одоо гүүр нурахын өмнө ямар байдалтай байсан тэр хэвэндээ эргэж орлоо" гэж мэдээлсэн байлаа.

Би энэ мэтчилэн асар олон ажил хэргүүд яагаад буруу ташаа болж бүтэлгүйтэж байгаагийн үндсэн шалтгааныг ойлгох гэж нийээд шаргуу оролцлого хийдэг байлаа. Гэсэн хэдий ч би энэ бүх мэдлэг, чадваргүй байдал /некомпетентность/-ын

\*Энэ бүх огүүдээг нь дохижоч /Лоуренс Жонсон Питер (1919-1989)/ оюуц огүүдээг байгаа хэмбэрээр бичигдсэн. /Хураангуйж оруулав./

илрэлүүдийн цаанаа өөрийнхөө ажилд үнэн сэтгэлээсээ зүтгэж явваа тэнэг хүний зүтгэл эсвэл хорон муу санзатай мэхлэн төөрүүлэгчийн тоглоом хоёрын аль нь нуугдаж байгааг маш цөөн удаа яг тодорхой тогтоож байв.

### Та тушаал дэвшихээсээ өмнө яваарай.

1966 онд Өмнөд Калифорнийн Их Сургуульд сурган хүмүүжүүлэх ухааны профессор болсноор би сүүлчийн удаа тогтон үйлчилж буй шатлан захирах ёс /иерархийн/-ид өөрийн албан тушаалын үүргийг биелүүлж эхэлсэн юм. Энэ албан тушаал дээр ажиллаж байх үед надад өөрийн мэдлэг, чадварын дээл түвшинд хүртэл дэвших тоолшгүй их боломж гарч байсан бөгөөд тэр бүхнийг би ашигласан бол өөрийнхөө гаргасан зарчмын золиос болох байлаа. Миний бодлоор би өөрийнхөө сонгосон мэргэжлийн үйл ажиллагзаны хүрээнд өөрийнхөө хувьд үр нөлөөтэй байдлын хамгийн тохиромжтой түвшинд хүрсэн, энэ ажилдаа би үнэн сэтгэлээсээ дуртай бөгөөд энэ ажлазасаа би асар их баяр баясгаланг мэдэрдэг байсан юм.

Нэг удаа миний ажилладаг хэлтсийн даргыг өөр ажилд шилжүүлээд, намайг хэлтсийг удирдахыг санал болголоо. Би энэ саналаас татгалзсан. Яагаад гэвэл миний тэр үед ажиллаж байсан албан тушаал надад эртний мөрөөдлийг минь биелүүлэх боломжийг олгодог байсан юм. Ийм шийдвэр гаргасны дараа хүмүүсийн зүгээс яаралгүй сайн бодож байж шийдах хэрэгтэй тухай цөхрөлтгүй зөвлөгөөнүүд надад ирж байлаа. Дараагийн долоо хоног гэхэд намайг дарга нар ятгаж, миний хамтран ажиллагцид шахалт үзүүлж эхлэв. Энэ бүхэн нь намайг маш эвгүй байдалд оруулж байсан учир би зориудын мэдлэг чадваргүй байдал гаргахаар шийдсэн юм. Энэ аргын гол утга нь өөрийн одоо хийж буй ажилдаа хамаарахгүй ямар нэг асуудлалар мэдлэг, чадваргүй болохоо харуулна гэсэн үт. Харин зориаго нь бол удирдлагадаа та өөрийгөө одоо ажиллаж байгаа албан тушаал дээрээ бол хамгийн мэдлэг, чадвартай боловсон хүчин боловч цааш дэвших ямар ч боломжгүй хүн гэж ойлгуулах явдал юм. Танд үүнийг хийхэд хэцүү юм шиг санадж байж магадгүй. Гэвч амьдрал дээр бол маш амархан байдаг төдийгүй маш их баяр баясгалан авчирдаг юм. Миний хувьд бол би хэдхэн л удаа өөрийн машиныг сургуулийнхаа деканы машиннаа тавьдаг байран дээр нь тавьсны дараахнаас намайг дэвшүүлэх

тухай санал ирэхээ больсон юм. [...]

Надал сурган хүмүүжүүлэх ухааны салбар дахь сулалгааны ажлынхаа талаар илтгэл тавыж өгөөч гэсэн санал удаа дараа ирдэг байв. Би илтгэлээ улам сонирхолтой болгохын тулд мэдлэг чадваргүй байдлын тухай ёт, хошин жишээнүүдийг ашигладаг болсон юм.

Миний эхний жишээ бол манай сургуулийн залуухан багш бүсгүй байлаа. Түүний бүтээх чадвар нь яг олшруулах машинтай адилхан байсан учир би түүнийг "хатагтай Дардас./ мисс штамиг/" гэж нэрлэсэн юм. Тэр багшийн коллежид сурч байхдаа цагаа барьлаг, хэлсэн Сүхнийг биелүүлдэг, профессоруудынхаа нэг ч үтийг гээлгүй сонедог хамгийн сайн оюутнуудын нэг байсан юм. Түүний тэмдэглэсэн леки нь профессоруудын хэлсэн үгтэй яв цав нийшдэг байсан юм. Тэрээр сайн оюутан байсан болохоор анги дэвших нь түүний хувьд ямар ч бэрхшээлгүй байсан төдийгүй ямар нэг аргаар багшлах дэллагтыг шалгальтгүй хүртэл өгч амжсан байлаа. Харин тэр Их Сургуулийн багш болсноор өөрийнхөө мэдлэг, чадваргүй байдлын түвшинд гайхалтай хурдан хүрч чаджээ. Эндээс тэр мэдлэгийг хүлээн авч хэрэглэгчийн хувьд мэдлэг чадвартай / компетентный/ байсан боловч мэдлэгийг тараагчийн хувьд бүрэн сүйрэлц орсон хүн гэдэг нь харагдаж байв.

Түүний боловсролын онцлог бэлтгэл нь түүний заасан аль ч хичээл дээр зөвхөн залхуутай байдлыг л төрүүлж чадж байв. Тэр бол хаалгаар гармагч нь өрөөнд гэгээ татдаг хүмүүсийн нэг байсан юм. Тэр цагаа барьлаг, хэлсэн бүхнийг гүйшэтгэдэг, баглох ёстой баримтуудаа шагтаа бөгөлдөг учир түүнийг хэзээ ч ажлаас нь халахгүй. Гэтэл түүний ганцхан чадаагүй зүйл нь бусдал зажж сургах явдал байсан юм.[...]

Сургуулийн захирадлал Остоду Лоп бол миний амьдралдаа хэзээ ч тааралдаж байгаагүй "бусдыг ойнгохгүй байх чадвар"-ыг эзэмшиж нэгэн байсан юм. Тэр уг нь маш мэдлэг, чадвартай судлаач, дээд зэргийн сурган хүмүүжүүлэгч байлаа. Оюутнууд түүний үг болгоныг сонедог байсан бөгөөд оюутнуудыг сахынга баттай байлгахад түүнд ямар ч бэрхшээл гардаггүй байжээ.

Захирадлал болсныхоо дараа тэрээр багш, алжилчдынхаа зовлон бэрхшээлтэй асуудлуудыг ойлгож, дэмжих хандлага огт гаргаагүй юм. Тэрээр оюутнуудтай сайн ойлголцож ажиллаж болдог байсан хэрээ өөрийн ажилтуудтай харилцах болгондоо тааламжгүй байдалд хүрээд байгаад их гайхсан байна. Тэр

цээшид дэвшиж чадах хүн биш бөгөөд түүний одоогийн амьдралын ихэнх цаг нь өмнө нь хичээлийн танхимд өнгөрүүлсэн сайхан цагаа дурсахад зарцуулагдаж байлаа.

Мэдлэг, чадвартай хүүхдүүдийн сурган хүмүүжүүлэгч мэдлэг, чадваргүй томчуллын удирдагч болтлоо дэвшсэн нь энэ байлаа. [...]

Өөрийнхөө лекциэнд би дараах үзэгдлийг Питерийн зарчим гэж нэрлэсэн. Энэ бол "Аль ч шатлан захирах ёсонд хувь хүн бүр өөрийнхөө мэдлэг, чадвар дутах төвшинд хүртлээ дэвших хандлагатай байдаг" явдал юм.

Заавал бүх тохиолдолд үйл явц ийм байдлаар хэрэгжиж байх ёстой биш харин ерөнхий зүй тогтол, хандлага иймэрхүү байдлаар илрэч байгаа учраас би үүнийг "хууль" биш зарчим гэж нэрлэсэн юм. Тогтолцоо хувь хүмүүсийг өөрийнхөө мэдлэг, чадваргүй байдлын түвшинд хүрэхийг шахаж, шаардаж байна. Хэрэв чи өөрийнхөө ажлыг их хүч зарцуулалтгүйгээр үр дүнтэй, чадварлаг гүйцэтгэж байвал хэн нэг нь чамд "Энэ ажил чамд өөрнийгээ харуулах боломжийг олгохгүй байна, тиймээс чи дээшээ дэвших хэрэгтэй" гэж хэлнэ. Гэтэл иймэрхүү маягаар дэвшсээр байгаад эзест нь та хэзээ нэгэн цагт өөрийнхөө мэдлэг, чадвар дутах албан тушаалц очих бөгөөд тэр үед та ч өөрийн хүрсэн амжилттаасаа ухрахыг хүсэхгүй, таныг удирдлагага чинь бас дэвшүүлэхийг хүсэхгүй учир энэ албан тушаал чинь таны байнгын ажил болдог. Ингэснээрээ та тухайн албан тушаалтны гүйцэтгэвэл зохих бүх ажлыг сүйрүүлээд зотсохгүй таны хамтран ажиллагчид цохронгое барж, эзест нь байгууллагын ажлын үр дүнг бүхэлд нь муутгахад хүрдэгт л гол бэрхшээл нь оршиж байгаа юм. [...]

Мэдээж хэрэг, би өөртөө миний судалсан энэ сургуулийн тогтолцоотой адилхан бүх шатлан захирах ёсонд ийм үзэгдэл оршиж байлаг юм биш биз дээ? гэсэн асуултыг тавьсан. Тэгээд амьдрал дээр энэ үзэгдэл нь яаж илрэч байна вэ? гэдгийг анхааралтай авч үзэхээр шийдсэн юм.

Үр дүн нь хамгийн сургамжтай байдлаар илрэсэн. Нэг удаа би нийтийн номын санд орох үедээ жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тухай номниудыг хамгийн доод талын тавиур дээр байрлуулсан байхыг ажигласан юм. Эндээс үзвэл, тэр номниудыг яг сонирхох ёстой хүмүүс нь одж харах, авч үзэх боломж хэт хомс байгаа юм. Би бас нэгэн томоохон хэвлэлийн газарт бизнесийн хүрээн дэх мэдлэг, чадваргүй

байдалын тухай бичсэн ном байвал наадаа явуулаач гэсэн захиалга егсен юм. Хоёр долоо хоногийн дараа ирсэн хариу захианд: "Бид манайд захиалга өгсөнд тань их баярлаж байгаа богоод таны захиалгыг аль болох хурдан шуурхай билүүлэхийг хүсэж байна. Гэвч манай байгууллагыг өөрийнхөө ажлыг сайжруулах оөрчилгэлт хийж байгаа учраас таны захиалтыг түр хойшлуулахаас оөр аргагүй байдалд хүрээд байна" гэж бичсэн байв.

Түүнчлэн би Вэнс Паккардын чанар муутай бүтээгдэхүүн гэргадаг уйлдвэрлэгчдийн тухай бичсэн "Хог уйлдвэрлэгчид" гэдэг номыг уншиж байсан юм. Гэтэл юу болсон гэж санана. Би номыг уншиж дуусаагүй байтал өмсүүн хавтас нь салаад бүх хуудаснууд нь тараад унчихсан юм.

Тэгээд би сургуулийн систем доторх болон түүнээс гаднах байгууллагуудын удирдах хүмүүсээс тэдний боловсон хүчинийг дэвшүүлэхдээ баримталааг бодлогынх нь талзар асууж, судлалтаа.

Сургуулийн ахлах байцаагч Кэн Прис үүний учрыг "Аль ч мэдлэг чадвартай хүн бол албан тушаал дэвших боломжтой хүн гэсэн үг" гэж товчихон тодорхойлсон юм. Мэдлэг, чадвартай байдал нь илүү ондөр албан тушаалаар урамшуулагдах ёстой, харин мэдлэг, чадваргүй байдал нь албан тушаал дэвшихэд саад болдог гэлгийт тооцож үзэх ёстой гэдэг лээр миний уулзсан бүх удирдах хүмүүс санал нэгдэж байсан юм.

Гэхдээ мэдлэг, чадвартай байдал нь албан тушаалдаа дэвших үндэслэл болдог, мэдлэг чадваргүй байдал нь албан тушаал дэвшихэд саад болдог тогтолцоонд ямар ч ажилтан дэвишсээр байгаад эсний дүнг өөрийнхөө мэдлэг, чадвар дутах түвшинд хүрээд зогсдог гэлгийг хэн нь ч ойлгохгүй байгаа нь харагдаж байлаа.

### Шатлан захирах ёсны илүү ондөр шатан дээр.

Надад 1964 онд Британийн Колумбиин Их сургуулийн профессор байх үед Ванкуверийн "Метро" гэдэг театрт болсон нэг үзэгдэлт жүжгийн их наадмыг үзэх хувь тохиосон юм. Нэгэн жүжгийн үйл явдал нь хадан уулын орой моргоод далайлд живж буй усан онгошон дээр болж байлаа. Жүжигчид тайлан дээр нэгэн зэрэг хоёр тийшээ найган хөдөлж далайн шуурга болж байгааг дурслэн үзүүлж байв. Гэтэл гол дүрд тоглож байсан жүжигчин байн байн үзэгчил рүү нуруугаа харуулан

бусдын эсрэг тал руу найган хөдөлж, түүнчлэн хөшигний ар тал руу гараарцаа ойлгомжгүй дохио өгч байлаа. Завсарлагаанаар би өөрийнхоо наиз жүжгийн зохиолч Рэймунд Халстай жүжгийн талаар ярилцсан юм.

Би түүнээс "Бидний сая үзсэн энэ гайхмаш үзэгдэл чамд ойлгомжтой байв уу?" гэж асуусан юм. Тэгэхэд тэрээр: "Тиймээ. Уг нь гол дура тоглосон жүжигчин бол сайн жүжигчин байгаа юм. Хамгийн гайтай нь юу вэ? гэвэл тэрээр өөрөө энэ жүжгийн зохиолыг бичээд, өөрөө найруулаад, бас өөрөө гол дурд нь тоглосон явдал юм. Тэгээд заримдаа тэр өөрийгөө тайлан дээр тоглож байгаа жүжигчин гэдгийгээ мартаад бусад жүжигчдийг удирдаж эхэлдэг юм. Тэр хөшигний ар тал руу зангаад байсан ойлгомжгүй дохионууд чинь гэрэлтүүлэгч, тайз засагчдыг удирдаж байгаа хэрэг" гэж хэллээ.

Би түүнл "Тэр гол дүрийн жүжигчин бол Питерийн зарчмын золиос болжээ. Мэдлэг, чадвартай жүжигчин маань мэдлэг, чадваргүй жүжгийн зохиолч, найруулагч болтлоо дэвшсэн байна шүү дээ" гэж хэлсэн юм. Рэйд миний санаа илт таалагдсан бөгөөд тэрээр намайг өөрийнхөө нээлтийн тухай ном бичих хэрэгтэй гэж зөвлөж эхлэв. Тэр үед би сурах бичиг бичээд нилээд завгүй байсан тул энэ удаал татгалзсан юм. Рэй энэ Питерийн зарчмын тухай ном бол нийгэмд маш хэрэгцээтэй болох тухай надад дахин дахин хэлж байсан бөгөөд налтай хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм. Үүнийг нь би зөвшөөрч, жилийн дараа гэхэд бид хоёр номоо бичихээр суусан. Бид өөрдийнхөө гар бичмэлд хэлэх гэсэн санаагаа бүгдийг шингээж дуусгажд нэгэн томоохон хэвлэлийн газарт номоо санал болгосон юм.

### Питерийн зарчмын золиос.

Эхний татгалзалтай захианд "Харамсалтай нь бил таны номыг хэвлэснээр олж болох ямар ч худалдааны ашигтай боломжийг харахгүй байгаа учир танд ямар нэг тааламжтай мэдээ дуулгаж чадахгүй нь дээ" гэж бичсэн байв. Үүний дараах хэдэн жилийн турш бил 13 хэвлэлийн газарт өөрдийн гар бичмэлийг явуулж байсан юм. Зарим үед татгалзсан хариунуул нэг хэвиийн байцаг байв. Заримдаа хэвлэлийн газрууд тэлэнд бидний гар бичмэлээс юу нь таалагдахгүй байгааг тайлбарлахыг оролдлог байв. Нэг нь "Та ийм чухал сэдэвт ийм хөнгөмсөг

хандаж болохгүй" гэсэн байхад негээс нь "Та инээдмийн зохиол бичиж байгаа юм бол ниймэрхүү эмгэнэлтэй нөхцөл байдлуудаа анхаарлаа хандуулах хэрэгтүй болов уу" гэж зөвлөсөн юм. Гурав дахь нь "Хэрэв та номоо дахин биччээд нэг бол хошин шог зохиол эсвэл чухал асуудлыг хөндсөн шинжлэх ухааны бүтээлийн шинж чанартай болгочихвол бил таны номыг хэвлэх талаар эргэж ярилцахад бэлэн байна" гэж мэдэгдсэн. Бидний зохиол оорт нь таалагдсан бас нэгэн хэвлэгч пүссийнхээ редакторуудын зөвлөлөөр хэлэлчүүлэхээр оруултал тэл миний бүтээлийн төрөл зүйл/жанр/-ийг тодорхойлж чадаагүй учир хэвлэхээс татгалзсан байна.

Харин би тэдэнд миний зохиол бол уран элэгэлийн хэлбэрээр бичигдсэн гэдгийт батлан хэлж байсан юм. Ихэвчлэн "Би таны зохиолыг уран элэглэл гэж бодохгүй байна. Миний бодлоор бол та үнэн сэтгэлээсээ бичиж байна" гэсэн утгатай хариу авдаг байлаа. Хэвлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг ийм олон хүмүүс уран элэглэл хэмээх уран зохиолын төрөл зүйлийн талаар ямар ч төсөөлөлгүй байгааг хараад би айх шиг боллоо. Уран элэглэл гэдэг бол гүн гүнзгийг агуулгыг ётг хошин байдлаар илэрхийлэн бичсэн уран зохиолын төрөл зүйлийг хэлдэг юм хэмээн би тэдэнд тайлбарласан боловч энэ бүхнийг ойлгомжтой болгох гэсэн миний зүтгэл амжилт олоогүй юм. Миний санаж байгаагаар бас нэгэн хэвлэгч миний тайлбарыг маш тэвчээртэй сонсож дуусмагц толгойгоо сэргээрэд: "Таны ярыж байгаа эн бүхэн бол зөвхөн онол. Харин би, таныг чухам үнэн сэтгэлээсээ бичиж байна уу, угүй юу гэдгийг л мэдмээр байна" гэж хэлдэг байна шүү. Надад гарал алдлахаас оөр арга үлдээгүй юм.

Хэвлэлийн газрууд бидний номыг хэвлэхэд бэлэн биш байсан болохоор бил Питерийн зарчмын талаар хэдэн өгүүлэл бичиж, хүмүүсийн зүтгээс ямар үнэлэлт авахыг нь ажиглахаар шийдсэн юм. Өгүүллүүдийг "Эсквайр" болон бусад бүх орон даяар уншааг сэтгүүлүүдэд хэвлүүлсэн бөгөөд түүнийг олон нийт сайнаар хүлээж авлаа.

"Уильям Морроу энд компани" гэдэг хэвлэлийн пүссийн срөнхийлөгч Лоуренс Хьюз надад хандан "Та Питерийн зарчмын тухай ном бичиж хэвлүүлье гэж бодлогтуй байсан уу?" гэж асуусан байлаа. Тэгэхээр одоо надад түүний редакторуудын хэн нэг нь миний амьдарч байсан Калифорнид ирэх үед нь хуучин гар бичмэлийнхээ тоосыг нь үлээчинхээл л танилцуулах үлдсэн байв.

1969 оны 2 дугаар сард хэвлэгдэн гарсан миний ном 7 дугаар сарын сүүлч гэхэд "Нью-Йорк тайме" сонини хамгийн гүйлгээтэй номны жагсаалтад уран сайхны бус зохиолын төрлийн I дүгээр байрт шалгарсан байв. Энэхүү тэргүүлэх байр сууринд хагас жил хэртэй байсны дараа олон нийтэд зориулсан зах зээл дээрх зөвлөн хавтастай номнуудын дунд лахин олон сарын турш хамгийн гүйлгээтэй номонд тооцогдоор байлаа. Тэрээр галаал хэл дээр орчуулагдан хилдийн чандад нийтдээ 37 удаа хэвлэгдсэн бөгөөд иймэрхүү байдлаар мөн л олон улсын хамгийн сайн гүйлгээтэй ном болж чадсан юм.

"Питерийн зарчим" ном хэвлэгдсэний дараа намайг өндөр албан тушаалд дэвшүүлэх тухай санал ирэхээ болсон. Үүнээр нь манай сургуулийн удирдах хүмүүс өөрсдийнхөө хүрээнд тэднийг үзэн сэтгэлээсээ хүлээж авахгүй байгаа хүнийг харахыг хүсээгүйд байгаа юм. Энэ ном бол миний зориудын мэдлэг чадваргүй байдлын оргил болсон нь харагдаж байх шиг байна. 1974 онд намайг сурган хүмүүжүүлэх тогтолцооноос гарах үед надал зориулж уламжлал болсон үзэлтийн цайлаглагыг зохион байгуулаагүй юм. Энэ бүхэн бол ойлгож болох зүйл.

Тэр үеэс хойш би ямар ч шатлан захирах ёсны үүрэг болон хязгаарлалтаас хараат биш тийм таатай нехцэлэл ажиллаж байна.

Зарчмыг нээсэн явдал нь надад олон хариулсан дээр тус болж байсан боловч өөрийнхөө нөлөөнөөс намайг хамгаалж чадаагүй юм. Бид далайн эрэг дээр нэгэн хуучин, жижигхэн байшинд амьдрахаар болж нүүсэн юм. Тэр байшинд нийзээд их засварын ажил хийх шаардлагатай байсан бөгөөд тэлгээр ажлуудын дотор онгойхгүй байгаа миний ажлын өрөөний цонхыг онгойдог болгох ажил бас орж байлаа. Мужаан ирж цонхны хүрээг засал, тавшант нь сольж өглөө. Түүнийг ажлаа дуусгахад цонх онгойдог болсон боловч чийдэн асахаа болсон байв. Уригdsan шахилгаангчин цонхны тавшиангийн доод хэсэгт байрлах шахилгааны шугаманд хадаас зоосны улмаас богино холболт үүсэж шахилгаан түйхээ болсон байна гэдгийг олж тогтоогоод чийдэнг засдаг болгож өглөө. Гэвч түүний ажлын үр дүнд цонхны шил цуурсан байв. Цонх шиллэгч ирээд цонхны шилийг сольж өгөв. Энэ бүгдийн дараа би цонхыг улам цэмшигэр болгохын тулд будагчныг дуудсан. Тэгэхээр одоо л нэг бүх юм ёсоороо боллоо гэж би веертөө хэллээ. Гэтэл будагчин маань

*"Шинэхүүрүү"* эрх түйн шийжлэх ухааны онол, арга түйм смыгч. 1999 он, №2  
ционхыг халалтай байдалд байхад нь будсанас болоод цонх  
дахин онгойхгүй болсон байв.

/Үргэлжлэлтийн бий/

*П.С.Тарапов, канд.философских наук,  
"УПРАВЛЕНИЕ БЕЗ ТАЙН"  
номноос эдийн засгийн ухааны  
магистр С.Бекбулат<sup>1</sup> орчуулав.*

<sup>1</sup> Энэхүү огуулалтний утга санаа нь огцүүлэгдэж буй иштглийн үзэгдлийн түү  
тогтол имар байдаг тухай болон билдний амьдарти буй голчилжсаны "худал  
харжны /хууль/-ыг ишн гаргаж тавысан бөгөөд энэхүү тогтолчинийд важ  
жэхжижон амьдрах ёстойг хүмүүст ойлтуулжад чиглэж байгаа юм. Харин имар  
иц чухал ясувалж дэвшүүлэхээ гүүнийн хөрмэн шийдвэрээрээ то гэсэн арга  
заммыг хайсан агуулалтуү билээ. Иштглийн үзэгдэл, иштглийн "хууль" /хуу  
тогтолтыг/ энэ чөөрчилж чадахгүй науу лээ. Энэ ялдамаа сөрийн сайн дурсаар  
мэждээ, чалваргүй орчууллагч болж дэвшүүлэхээ ушигчийн агутай танаас худалж  
өчье.

## ТЭМДЭГЛЭЛ